



БОЛОВСРОЛ,
СОЁЛ,
ШИНЖЛЭХ УХААНЫ ЯАМ

МОНГОЛ УЛСЫН
БОЛОВСРОЛ, СОЁЛ,
ШИНЖЛЭХ УХААНЫ ЯАМ
МОНГОЛ УЛСЫН
БОЛОВСРОЛ, СОЁЛ,
ШИНЖЛЭХ УХААНЫ ЯАМ



БАГШЛАХУЙН ХӨГЖИЛ: “ХҮН-ОРЧИН” ХИЧЭЭЛИЙН МОДУЛЬ

ЕБС-ийн Бага боловсролын багш нарт зориулав.

Улаанбаатар

2013 он



БОЛОВСРОЛ,
СОЁЛ,
ШИНЖЛЭХ УХААНЫ ЯАМ

МОНГОЛ УЛСЫН
БОЛОВСРОЛ, СОЁЛ,
ШИНЖЛЭХ УХААНЫ ЯАМ
МОНГОЛ УЛСЫН
БОЛОВСРОЛ, СОЁЛ,
ШИНЖЛЭХ УХААНЫ ЯАМ



Бүтээгдэхүүн "А" нь бүтээгдэхүүн з о, бүтээгдэхүүн ж бүтээгдэхүүн
хэрэгжүүлж буй "Багшлах аргазүйн
бүтээгдэхүүн А бүтээгдэхүүн А бүтээгдэхүүн бүтээгдэхүүн бүтээгдэхүүн"
Бүтээгдэхүүн А бүтээгдэхүүн нь төслийн хүрээнд
бүтээгдэхүүн бүтээгдэхүүн.

БАГШЛАХУЙН ХӨГЖИЛ

“ХҮН-ОРЧИН” ХИЧЭЭЛИЙН МОДУЛЬ

Боловсролын түвшин: Бага

Улаанбаатар

2013 он

БОЛОВСРУУЛСАН БАГ:

Ахлагч:

Эрдэнэчулууны Мөнгөнтулга

МУБИС-ийн Байгалийн Ухааны Сургуулийн багш

Гишүүд:

Гүрдагвын Нэргүй

МУБИС-ийн Багшийн Сургуулийн багш

Цэвэгжавын Пагмасүрэн

МУБИС-ийн Байгалийн Ухааны Сургуулийн багш

Пүрэвдоржийн Алтанцэцэг

МУБИС-ийн Боловсрол судлалын Сургуулийн багш

Д.Энхтуяа

ЭКСПЕРТИЙН БАГ:

Ахлагч:

Чодингийн Ганцэцэг

БШУЯ-ны Сургуулийн өмнөх, бага боловсролын
хэлтсийн мэргэжилтэн

Гишүүд:

Ноокоогийн Оюунцэцэг

МУИС-ийн Хими, Химийн Инженерчлэлийн
Сургуулийн багш

Бадамжавын Золзаяа

МУБИС-ийн Компьютер, Мэдээллийн Технологийн
Сургуулийн ахлах багш

Шагдарсүрэнгийн Сайнбилэг

МУИС-ийн Хими, Химийн Инженерийн Сургуулийн
багш

Цэвэгжавын Пагмасүрэн

МУБИС-ийн Байгалийн Ухааны Сургуулийн багш

РЕДАКЦИЙН БАГ:

Чодингийн Ганцэцэг

БШУЯ-ны Сургуулийн өмнөх, бага боловсролын
хэлтсийн мэргэжилтэн

Мөнхжаргалын Баасанхүү

БХ-ийн Бодлого, стратеги хөгжлийн судалгааны
секторын эрдэм шинжилгээний дадлагажигч ажилтан

Дагдангийн Ганболд

МУБИС-ийн Багшийн Сургуулийн багш

ЗӨВЛӨХ БАГ:

Иший Тэцүя

Төслийн менежер

Сүзүки Саяака

Сургалт, хяналт үнэлгээ хариуцсан мэргэжилтэн

Такахата Хироши

Токио Гакугэй их сургуулийн профессор

Камата Масахиро

Токио Гакугэй их сургуулийн профессор

Фүкүчи Акитэрү

Токио Гакугэй их сургуулийн профессор

Мацүра Шюү

Токио Гакугэй их сургуулийн профессор

Бадамсамбуугийн Хишигбаяр

Төслийн мэргэжилтэн

ГАРЧИГ

УДИРТГАЛ

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ. “ХҮН-ОРЧИН” ХИЧЭЭЛИЙН АРГА ЗҮЙН ХӨГЖИЛ

- 1.1 “Хүн-Орчин” хичээлийн хөгжлийн чиг хандлага, шинэ шаардлага
- 1.2 “Хүн-Орчин” хичээлээр суралцагчдын суралцахуйг дэмжих арга зүйг хөгжүүлэх нь

ХОЁРДУГААР БҮЛЭГ. “ХҮН-ОРЧИН” ХИЧЭЭЛД СУДАЛГААНЫ ҮНДЭСТЭЙ ХАНДАХ НЬ

- 2.1. Хичээлийн бэлтгэл судалгаа, аргачлал, жишээ
- 2.2. Хичээлийн ажиглалт, аргачлал, жишээ
- 2.3. Хичээлийн хэлэлцүүлэг, аргачлал, жишээ

ГУРАВДУГААР БҮЛЭГ. МОДУЛЬТ СУРГАЛТЫН АРГА ЗҮЙ

- 3.1. Сургалтын төлөвлөгөө, хөтөлбөр (5 өдрийн)
- 3.2. Арга зүйн төлөвлөлт

ХАВСРАЛТ

Хавсралт 1.

Хавсралт 2.

Хавсралт 3.

Хавсралт 4.

НЭР ТОМЬЁОНЫ ХУРААНГУЙ

ЛАВЛАХ МАТЕРИАЛ

УДИРТГАЛ

Бага боловсролын байгалийн ухааны “Хүн–Орчин” багийн боловсруулсан “Багшлахуйн хөгжил” модуль хөтөлбөрийг Та бүхний гарт хүргэж байна.

Энэхүү модуль хөтөлбөрийг БСШУЯ, Японы “Жайка” Олон улсын байгууллагын хамтарсан “Багшлахуйн арга зүйн хөгжлийг түгээн дэлгэрүүлэх тогтолцоог бэхжүүлэх нь” төслийн хүрээнд боловсруулсан болно. Төслийн зорилго, үр дүн, хэрэгжих арга зам зэргийг уг төслийн хүрээнд боловсруулсан “Үндсэн модуль”-аас уншиж танилцсан гэдэгт итгэлтэй байна.

МУБИС-ийн Багшийн сургуулийн Бага боловсролын Байгалийн ухааны дидактикийн төв, БУС-ийн багш нарын хамтарсан “Бага боловсролын байгалийн ухаан”-ы баг нь 2006-2009 онд хэрэгжсэн “Суралцагчдын суралцахуйг дэмжих арга зүйн хөгжил” төслийн 3 жилийн хугацаанд ЕБС-ийн 1-3 дугаар ангид үзэх “Хүн орчин” хичээлийн тодорхой бүлэг сэдвүүдийг заах арга зүйн зөвлөмж боловсруулан хүргэсэн билээ. Үүнд:

Зөвлөмж -1: Амьд биеийн хөгжлийг таниулах арга зүй /2-р анги/

Зөвлөмж – 2: Монгол орны бүс нутгийн байгаль ба нийгэм ахуйн шүтэлцээг таниулах арга зүй /3-р анги/

Зөвлөмж – 3: “Хүрээлэн буй орчинг тоглоомын явцад таниулах арга зүй” /1-р анги/ зэрэг болно.

Бидний энэ удаагийн боловсруулсан модулийн гол зорилго нь:

1. Өмнөх төслийн хүрээнд боловсруулсан арга зүйг түгээн дэлгэрүүлэх
2. Модулийг ашиглан багшлах арга зүйг хөгжүүлэх сургалт зохион байгуулах
3. Багш, хичээлийн судалгаа хийхдээ модулийн агуулгыг ашиглаж болохуйц хэрэглээтэй байх зэрэг болно.

Багшийн мэргэжлээ дээшлүүлэх үр дүнтэй аргуудын нэг нь сургуульд суурилсан хичээлийн судалгаа болох нь нэгэнт олон улсын туршлагаар батлагдсан.

Төслийн хоёрдугаар шатанд “Хүн–Орчин” хичээлээр хичээлийн судалгаа хийж, зохих туршлага хуримтлуулсан бөгөөд энэхүү туршлагаасаа та бүхэнтэй хуваалцахыг зорилоо.

Бидний хийсэн хичээлийн судалгааны арга зүй менежменттэй танилцан өөрсдийн ажилд авч ашиглана гэдэгт найдаж байна. Асууж тодруулах болон санал, шүүмж байвал “Хүн–Орчин” мэргэжлийн багийнхантай холбогдоорой. Та бүхний эрдмийн их үйлсэд амжилт хүсье.

Зохиогчдын баг

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ. “ХҮН-ОРЧИН” ХИЧЭЭЛИЙН АРГА ЗҮЙН ХӨГЖИЛ

1.1 “Хүн-Орчин” хичээлийн хөгжлийн чиг хандлага, шинэ шаардлага

“Хүн-Орчин” хичээлийн үндэс суурь нь Богд хаант Монгол улс байгуулагдсан 1911 оноос эхэлсэн гэж үздэг. Энэ үед бага сургуульд “Монгол ба бусад олон газрын байдал”, “Аж төрөхийг сайжруулах ёс” зэрэг хичээлүүдийг зааж байжээ. Ардын хувьсгал ялсан эхний жилүүдэд дээрх агуулгыг үндсэнд нь хэвээр хадгалж байсан бөгөөд хожим агуулга, арга зүй нь байнга өөрчлөгдөн сайжирсаар ирсэн байна. Бага ангийн байгалийн ухааны хичээлийг дараах байдлаар нэрлэж иржээ. Үүнд:

- 1921-1935 онд 1-3 дугаар ангид Түмэн бодис
- 1932-1971 онд 1-4 дугаар ангид Байгалийн шинжлэл
- 1972-1991 онд 1-4 дугаар ангид Түмэн бодис
- 1992 онд 4-6 дугаар ангид Байгаль шинжлэл
- 2005 онд 2-3 дугаар ангид Хүн байгаль
- 2006 онд 1 дүгээр ангид Хүрээлэн буй орчин
- 2007 оноос 1-3 дугаар ангид “Хүн-Орчин”

1925 онд бага ангийн байгалийн ухааны хичээлийн хамгийн анхны хөтөлбөр батлагдан 2-р ангид: сав ертөнц, түүний баялаг, шохой, нүүрс, чулуулаг, төмөр, зэс, алт, мөнгө, 3-р ангид: ургамал, амьтны аймаг, нян, хүний биеийн бүтэц, амьдрал, Монгол улсын нутгийн байдал зэрэг агуулгыг үзэхээр тусгажээ.

1932-1950 он хүртэл Оросын нэрт сурган хүмүүжүүлэгч М.Н.Скаткины боловсруулсан байгалийг судлах арга зүйн үзэл баримтлалд тулгуурласан агуулгыг судалж байсан ба 1950-аад оны дунд үеэс “Түмэн бодис” хичээлийн агуулгад Монгол орны байгалийн бүс бүслүүрийн ургамал, амьтдын нэр, хөрс боловсруулах арга туршлагыг нэмж тусгасны зэрэгцээ хүний биеийн бүтэц, амьдралын орчны тухай оруулсан байдаг.

1960-аад оноос амьд ба амьгүй байгалийн тухай ойлголтыг нилээд өргөжүүлэн (ЗХУ-ын бага сургуулийн 4-р ангид үздэг “Байгаль судлал” хичээлийн агуулгын бүтэц, дэс дарааллыг үндсэнд нь хадгалсан) өнгөн хөрс, ашигт малтмал, төмөрлөгүүд, ус, агаар, тэнгэрийн дуу, цахилгаан хэмээх бүлэг сэдвүүдийг судлах болсон байна. Түүнчлэн заах арга зүйн талаас нь нэлээд анхаарч байгаль, цаг агаарын үзэгдлийг ажиглалт, туршилтаар судлах, экскурсээр явж хөрс, ашигт малтмал, ургамалтай танилцахаар оруулсан.

1972-1990-ээд он хүртэл “Түмэн бодис” хичээлээр 1-3 дугаар ангид чулуулаг ба эрдэс, өнгөн хөрс, ус, агаар, ургамал, амьтан гэсэн агуулгыг судалж байв. Харин 2004 оны Боловсролын шинэ стандартын үзэл санааг хэрэгжүүлэхтэй холбогдон суралцагчдад хүрээлэн буй орчинтой зөв харьцах, нийгмийн харилцааны болон эрүүл аж төрөх, аюулгүй амьдрах энгийн ойлголт, чадварыг цогц байдлаар төлөвшүүлэх, хичээл хоорондын уялдаа холбоог хангах зорилгоор 1-3 дугаар ангид “Хүн-Орчин” хичээлийг судлах болсон. Энэ нь “Хүн-байгаль”, “Хүн-нийгэм”, “Эрүүл мэнд” гэсэн 3 хичээлийн агуулга, арга зүйг интеграцичлан БСШУ-ны сайдын 2007 оны 8 дугаар сарын 20-ны өдрийн 286 дугаар тушаалаар оруулсан болно.

2008-2010 онд 1-3-р ангийн “Хүн-Орчин” хичээлийн сургалтын үндэсний хөтөлбөр, зөвлөмж, сурах бичиг хэвлэгдэн гарч сургалтад ашиглагдаж байна. “Хүн-Орчин” хичээлийн агуулга нь цаашид судлах Байгалийн ухаан, Нийгмийн ухаан, Эрүүл мэнд хичээлийн суурь болно. Багш та “Хүн-Орчин” хичээлийн анги тус бүрийн агуулгын тогтолцоог “Ерөнхий боловсролын 12 жилийн сургуулийн үндэсний хөтөлбөр, зөвлөмж”-өөс дэлгэрүүлэн уншиж судлаарай.

“Хүн-Орчин” хичээлийн агуулгын тогтолцоо

Эрүүл амьдрах үндэс	Хүрээлэн буй байгаль	Нийгэм, соёл
- Биеийн эрүүл мэнд (зөв хооллолт, хувийн эрүүл ахуй, ариун цэвэр, амны хөндийн эрүүл мэнд) - Аюулгүй амьдрал (эрүүл орчин бүрдүүлэх, бие эрхтнээ хамгаалах, осол гэмтлээс сэргийлэх, эрүүл аж төрөх)	- Амьгүй ба амьд бие (Амьгүй ба амьд биеийн шинж чанар, амьдралын орчин) - Байгаль, цаг агаарын үзэгдлүүд (байгаль, цаг агаар, улирлын өөрчлөлт, байгалийн гамшигт үзэгдэл) - Байгаль хамгаалах	- Нийгэм, соёлын орчин (би, гэр бүл, анги хамт олон, төрөл садан, найз нөхөд, сургууль гэх мэт) - Эрх үүрэг, дүрэм журам, ёсзүй (сурагчийн эрх үүрэг, сургууль соёлын орчин дахь хүүхдийн эрх гэх мэт)

“Хүн-Орчин” хичээлээр суралцагчдад байгаль, нийгэм, эрүүл аж төрөх ёсны түгээмэл ойлголтуудын талаар мэдлэг, чадвар олгох учраас багшаас дараах мэдлэг, чадварыг эзэмшсэн байхыг зүй ёсоор шаарддаг. Үүнд:

- Байгаль шинжлэл, түүх, нийгэм судлал, хууль эрх зүй, эрүүл мэндийн боловсролын талаар онолын зохих мэдлэгтэй байх
- Бага насны суралцагчдын нас сэтгэхүйн онцлог, хэрэгцээ сонирхолд нийцсэн сургалтын агуулга, арга зүйг оновчтой сонгон сургалтыг төлөвлөх, зохион байгуулах чадвартай байх
- Хичээлийн тодорхой арга зүйг хамтран турших, харилцан суралцах, арга зүйгээ сайжруулах хүсэл эрмэлзэлтэй байх зэрэг орно.

Бусад улс орны жишгээс харахад “Хүн –Орчин” хичээл өөр өөр нэртэй боловч агуулга ойролцоо байна. Жишээ нь, Япон улсад 1-2 дугаар ангид Амьдрах ухаан, 3-6 дугаар ангид Байгаль шинжлэл гэсэн нэрийн доор хүнийг хүрээлэн буй байгаль орчин, нийгмийн харилцаатай холбон сонирхолтой хэлбэрээр заадаг байна. Америкт Байгалийн ухааны хичээлээр хүн – байгаль – нийгмийн харилцан холбооны талаар сонирхолтой жишээ баримт авч дэлгэрүүлэн судалдаг. Иймээс “Хүн-Орчин” хичээлийг дээр дурдсан агуулгын хүрээнд үргэлжлүүлэн судалж, түүнийг сайжруулан, арга зүйг нарийвчлан боловсруулж өгөх хэрэгцээ шаардлага байсаар байна.

1.2. “Хүн-Орчин” хичээлээр суралцагчдын суралцахуйг дэмжих арга зүйг хөгжүүлэх нь

БШУЯ, Японы Жайка олон улсын байгууллагын хамтарсан “Суралцагчдын суралцахуйг дэмжих арга зүйн хөгжил” төслийн хүрээнд **2006-2009 онд** ЕБС-ийн 1-3 дугаар ангийн “Хүн орчин” хичээлийн

зарим бүлэг сэдвээр (Хүснэгт 1.) “Суралцахуйг дэмжих арга зүй”-г туршин, багшид зориулсан зөвлөмж боловсруулан хэвлүүлсэн билээ.

Төслийн хугацаанд боловсруулсан арга зүйн 3 зөвлөмжийн онцлог, дэвшүүлсэн санааг товч сийрүүлбэл:

Зөвлөмж -1. Амьд биеийн хөгжлийг таниулах арга зүй

Энэ зөвлөмжид 2-р ангийн “Хүн –Орчин” хичээлийн “Ургамал бидний орчин” бүлэг сэдвийг заах арга зүйг оруулсан ба амьд биеийн хөгжлийн ерөнхий зүй тогтлыг хүүхдэд ойр байдаг ургамлын жишээн дээр таниулахаар зорьсон. Мөн энэ зөвлөмжөөр хүүхдийн хөгжил гэж юу болох, хүүхдийн хөгжлийг дэмжих талаарх онолын асуудлуудыг тусгасан болно.

Зөвлөмж 1-д амьд биеийн хөгжлийн жишээ болгон авсан бүлэг сэдэв нь хүүхдүүд ажиглаж тэмдэглэх, судалгааны энгийн аргыг хэрэглэх хялбар туршилт хийх замаар хүрээлэн буй орчинд байгаа ургамлаа таньж нэрлэх, юунд хэрхэн хэрэглэдэг болон түүнийг ач холбогдол, өсөлт, хөгжилт, бүтцийн тухай ойлголт өгнө. Зөвлөмжийг ашиглах зааврыг “Зөвлөмж-1”-д дэлгэрэнгүй тайлбарлан бичсэнтэй танилцаарай.

“Амьд биеийн хөгжлийг таниулах арга зүй” зөвлөмжид дараах сэдэвт хичээлүүд багтсан. Үүнд:

1. Ургамал бидний амьдралд
 - 1.1. Ургамлыг юунд хэрэглэдэг вэ?
 - 1.2. Таримал ургамал
2. Ургамал ургахад юу хэрэгтэй вэ?
 - 2.1. Тасалгааны цэцгийн ургах нөхцөлийг тодорхойлох нь
 - 2.2. Ургамал ургахад юу хэрэгтэй вэ?
3. Ургамлын өсөлт, бүтэц ба хэлбэр
 - 3.1. Ургамал өсөж том болох нь
 - 3.2. Ургамал юунаас бүтдэг вэ?
 - 3.3. Модлог, сөөглөг, өвслөг ургамал
4. Ургамал – амьд бие
 - 4.1. Ургамал амьд бие болох нь

Хичээлийн сэдвийн нэрийг хүүхдэд ойр, ойлгоход хялбар байхаар оруулсан бөгөөд сэдвийн дарааллыг хүүхдүүдийн амьдралд ойр, таньж ойлгоход хялбар байх талаас бодолцож хэрэглээнээс эхлэн оруулсан. Бид анх энэ хичээлийг төлөвлөж байхдаа Ургамлын бүтэц, Ургамлын хэлбэр гэх мэт “том” агуулгаар эхэлж байсан нь тухайн насны хүүхдийн нас сэтгэхүйн онцлогт тохироогүй бөгөөд сурагчдад ойлгомжгүй, бодит бус хийсвэр ойлголт, мэдлэгийг олгох ба мэдлэг нь чадвар, хэрэглээ болж чаддаггүйг олж мэдсэн.

Зөвлөмж – 2. Монгол орны бүс нутгийн байгаль ба нийгэм ахуйн шүтэлцээг таниулах арга зүй

Энэ зөвлөмж нь “Хүн–Орчин” хичээлийн 3-р ангийн “Манай орны байгаль” бүлэг сэдвийг заах арга зүйн тухай болно. Зөвлөмжийн зорилго нь “Хээр тал”-ын жишээн дээр суралцагчдад Монгол орны бүс нутгийн байгаль ба нийгмийн ялгаатай байдал, тэдгээрийн онцлог болон харилцан шүтэлцээг орон нутгийн байгалийн онцлогт тулгуурлан таниулах явдал юм.

“Манай орны байгаль” бүлэг сэдвийн хүрээнд эзэмшүүлэх мэдлэгийг багш шууд тайлбарлах, мэдээлэл дамжуулах бус гарын доорх материал ашиглан ажиглалт, туршилт явуулах, харилцан ярилцах замаар сурагчид өөрсдийн бүтээлч үйл ажиллагаагаар мэдлэг бүтээж, байгаль нийгмийн талаар ойлголттой болно. Жишээ нь, “Манай орны гол мөрөн, нуур” сэдэвт хичээл дээр доорх туршилтыг хийснээр урсгал ус болон тогтоол усны ялгааг ойлгож мэднэ. Туршилт хийхдээ, жижиг цаасыг хумьж уул нурууг дүрслэн, цэнхэр өнгийн усаар хур тунадасыг төсөөлнө. Өндөр уулын орой дээр усыг гоожуулахад уулын налуу хажууг даган ус урсах бөгөөд хонхор газар нь ус тогтоно. Урсаж байгаа усыг гол, тогтсон усыг нуур гэж нэрлэнэ гэдэг ойлголтыг олгоно.



“Зөвлөмж-2”-оор дамжуулан эзэмшүүлж байгаа хүрээлэн буй орчны тухай мэдлэг, чадвар нь байгаль, нийгэм болон хүний эрүүл мэндэд ямар ач холбогдолтой болохыг ойлгуулж байгаль орчноо хайрлан хамгаалж, өөрийгөө болон бусдыг хүндэлж, хайрладаг, улмаар нийгмийн амьдралд идэвхтэй, хариуцлагатай оролцдог иргэнийг төлөвшүүлэхэд хувь нэмрээ оруулах болно.

“Монгол орны бүс нутгийн байгаль ба нийгэм ахуйн шүтэлцээг таниулах арга зүй” зөвлөмжид дараах сэдэвт хичээлүүд багтсан. Үүнд:

1. Орчноо ажиглацгаая
 - 1.1. Бидний эргэн тойрны газрын гадаргын хэлбэр
 - 1.2. Манай орны гол мөрөн
 - 1.3. Өнөөдөр гадаа ямар байна вэ?
 - 1.4. Одоо ямар улирал болж байгаа вэ?
2. Манай орны байгаль олон янз
 - 2.1. Манай орны ой тайга, хээр тал, говь цөл
 - 2.2. Бидний мэдэх амьтан
 - 2.3. Бидний мэдэх ургамал
 - 2.4. Хүмүүсийн эрхлэх ажил хөдөлмөр

Мөн энэ зөвлөмжөөр “Хүн-Орчин” хичээлийн агуулга, түүний онцлог болон 8-9 настай хүүхдийн нас сэтгэхүйн онцлог, хичээлийн бэлтгэл судалгаа болон хүүхдийн алдааг шинжлэх тухай дэлгэрэнгүй тайлбарыг өгсөн (Зөвлөмжтэй танилцаарай).

Зөвлөмж – 3. “Хүрээлэн буй орчинг тоглоомын явцад таниулах арга зүй”

“Зөвлөмж 3” –ын зорилго нь 6 настай 1-р ангид элсэн суралцаж буй бяцхан сурагчдад биднийг хүрээлэн буй орчны тухай ойлголтыг энгийн хялбар аргаар таниулах явдал юм. Энэ насны сурагчид нь цэцэрлэг, гэрийн орчноос сургуулийн орчинд шилжиж байгаа бөгөөд тэд тоглох, дуурайх, хийсвэрлэн

сэтгэх зэрэг оюуны үйлийн хамгийн энгийн шатанд байдаг онцлогтой. Иймээс бид энэхүү зөвлөмжөө “Хүрээлэн буй орчинг **тоглоомын** явцад таниулах арга зүй” хэмээн нэрлэсэн.

Нэгж хичээл бүрийн агуулгыг тухайн сурагчдын нас, сэтгэхүйн онцлогт тохируулан боловсруулахыг хичээсэн. Тухайлбал, “Миний эргэн тойронд юу байдаг вэ?” гэсэн эхний хичээлийг экскурс хэлбэрээр явуулахаар төлөвлөсөн бөгөөд хүүхдүүд багштайгаа хамт сургуулийнхаа орчинтой танилцаж тэнд байгаа амьтан ургамал, байшин барилга, уул ус гэх мэт зүйлийг ажиглаж мод, чулуу, навч, боргоцой зэргийг түүж, дараагийн хичээлд ашиглан дуртай тоглоомоо хийх ёстой. Энэ үед багш, сурагчдыг яриулах, санал бодлыг нь чөлөөтэй сонсох, бусдыг хүндэтгэх талаар хэлж, нийгэмшихүйн анхны чадваруудыг төлөвшүүлж эхлэх юм. Мөн гадаа гудамжинд гарч явахдаа аюул ослоос болгоомжлох, зөв хувцаслах, гарын ариун цэврийг сахих зэрэг эрүүл мэндийн асуудлыг ч мөн ойлгуулах юм.

Арга зүйг 6 настай хүүхдийн нас, сэтгэхүйн онцлогт тохируулан, зохих судалгаа хийсний үндсэн дээр сурагчдаар ажиглуулах, жишиж харьцуулах, ажигласан зүйлийг тайлбарлуулах, зуруулах, өөрсдөөр нь хийлгэж бүтээлгэх, хайчлуульж наалгах зэрэг идэвхтэй үйл ажиллагаанд тулгуурлан, үйлийн явцад суралцах сургалтын ерөнхий зарчмыг баримталж боловсруулсан. Мөн сурагчдаар тоглоомын явцад мэдлэг бүтээлгэх арга зүйд анхаарч суралцагчид тоглонгоо суралцах, суралцангаа тоглох гэсэн ерөнхий арга зүйгээр нэгж хичээл бүрийн арга зүйг боловсруулсан. Түүнчлэн Монгол орны байгаль, нийгмийн олон янз байдалд аль болох зохицуулах, өөрөөр хэлбэл, аль ч аймаг, байгалийн бүсийн суралцагчдад ойлгомжтой байхаар бодож даалгавар, өгөгдлийг бодитой сонгохыг хичээсэн. Тухайлбал, хот суурин газрын онцлог, орчин нөхцлийг харгалзан үзэж хүүхдүүдийн тоглодог тоглоом, хайртай амьтад, дуу шүлэг зэргийг сонгож оруулсан. Сурагчид хичээлийн явцад өөрсдийн тоглодог тоглоомыг танин мэдэж, түүнийгээ зурж бүтээхийн зэрэгцээ, бусад газарт ямар тоглоом наадгай байдаг талаар анхны мэдэгдэхүүнийг олж авах болно. Өөрөөр хэлбэл, биднийг хүрээлэн буй байгаль дэлхий, хүн төрөлхтөн олон янз байдаг талаар анхны ойлголт авна.

Эхний шатны төслийн явцад суралцагчдын суралцахуйг дэмжих арга зүйг туршин хэрэгжүүлснээр туршигч багш нар болон сурагчдад дараах өөрчлөлтүүд ажиглагдсан.

Багшид гарсан өөрчлөлт	Сурагчид гарсан өөрчлөлт
- Зургаан настай сурагчдын нас, сэтгэхүйн хөгжлийн онцлогийг судалж түүнд тохируулан үг яриа, биеийн байрлал, хөдөлгөөн, дохио зангаа, үйл хөдлөл зэрэгтээ анхаарч ажиллах болсон. - Хичээлийн төлөвлөлт, бэлтгэл үйл ажиллагааг сайтар хангаж хичээлээ явуулж байхын ач холбогдлыг ойлгож, үүнийгээ өөрийн ажлын гол хэсэг гэдэгтэй санал нийлж биелүүлэх хандлагатай болсон. Хичээлийн төлөвлөлтдөө хүүхдийн хариулж болох боломжит хариултыг урьдчилан таамаглаж, хэрвээ багшийн хүссэн хариулт гарахгүй тохиолдолд хэрхэн түүнийг гаргуулах талаар тодорхой хэмжээний ойлголт, мэдлэг, ур	- Багаар ажиллах чадвартай болж, сурч мэдэхийн төлөө мэрийх болсон - Сурагчид багшаасаа айж эмээлгүй, дотно харилцаж, санал бодлоо чөлөөтэй илэрхийлэх болсон - Ажиглалт хийх анхан шатны мэдлэг, чадвартай болсон - Аливаа зүйлийг сонирхон байгалийг танин мэдэх хүсэл нь зарим сурагчдад илүү өрнөсөн - Хичээлд хандах хандлага өөрчлөгдсөн. Тухайлбал, “Манай ангийн хичээлдээ анхаардаггүй, сурах сонирхолгүй, идэвхгүй байсан сурагч туршилт хичээлийн дараа маш идэвхтэй болж, сурах сонирхол

чадвар, эв дүйтэй болсон. • Хичээлийн агуулгыг сурагчдын амьдралд аль болох ойр, тэдний бодит төсөөлөлд тулгуурлан явуулахын ач холбогдлыг ухаарсан • Сурагчдыг сэдэлжүүлэхэд илүү анхаарч ажиллах болсон • Сурагчдаар мэдлэг бүтээлгэх арга зүйд суралцаж, түүний ач холбогдлыг ойлгосон • Сургалтын аргуудыг хослуулан хэрэглэх арга зүйг туршиж, хичээлдээ бүтээлчээр хандах болсон • Гарын доорх материал ашиглан сургалтын хэрэглэгдэхүүн бэлтгэж, хичээлдээ хэрэглэдэг болсон • Хүүхдийн гаргаж болох алдааг урьдчилан таамаглаж хичээлдээ бэлтгэх болсон • Багш нар багаар хамтран ажиллаж хичээлээ хамтран төлөвлөж, зохион байгуулж, бие биедээ зөвлөн тусалдаг болсон. • Хичээлийн хэлэлцүүлгийг зохион байгуулах арга зүйд суралцсан	нь нэмэгдсэн” гэж Сэлэнгэ аймгийн бага ангийн багш бидэнд хэлж байв. (Энэ хүүхдийн ээж нь багшид хүүхдээ өөрчлөгдсөнийг ярьж, түүнд баярлан, уйлж байсан гэнэ). • Суралцах идэвх сонирхол нь дээшилсэн. Сурагчид хичээлд идэвхтэй оролцож, бие биеэсээ суралцахын зэрэгцээ мэдлэгээрээ өрсөлдөх, түрүүлж даалгавраа дуусгахыг хичээх, багшдаа шалгуулахаар уралдах, дараагийн хичээл орох өдрийг тэсэн ядан хүлээдэг болсон. • Олж авсан мэдлэгтээ дүн шинжилгээ хийж, мэдлэгээ хамтран бүтээхэд суралцаж эхэлсэн. • Санаа бодлоо чөлөөтэй илэрхийлэх чадвар нь сайжирсан. • Өөрийн болон бусдын сул талыг ажиглан мэдэрч бусдадаа нөлөөлөх болсон гэх мэт маш олон давуу талууд илэрч байсан. Иймээс багшлах арга зүй хөгжих нь хичээлийн чанарт нөлөөлнө.
---	---

**Бага боловсролын байгалийн ухааны багийн 3 жилийн хугацаанд
боловсруулсан зөвлөмжийн бүтэц, агуулга**

№	Он	Зөвлөмжийн нэр	Анги	Цаг	Бүлэг сэдвийн нэр	Нэгж хичээлийн сэдвийн нэр
1	2007	Амьд биеийн хөгжлийг таниулах арга зүй	2-р анги	8	Ургамал бидний орчин	- Ургамал бидний амьдралд - Ургамлыг юунд хэрэглэдэг вэ? - Таримал ургамал - Ургамал ургахад юу хэрэгтэй вэ? - Тасалгааны цэцгийн ургах нөхцлийг тодорхойлох нь - Ургамал ургахад юу хэрэгтэй вэ? - Ургамлын өсөлт, бүтэц ба хэлбэр - Ургамал өсөж том болох нь - Ургамал юунаас бүтдэг вэ? - Модлог, сөөглөг, өвслөг ургамал - Ургамал – амьд бие - Ургамал амьд бие болох нь
2	2008	Монгол орны бүс нутгийн байгаль ба нийгэм ахуйн шүтэлцээг таниулах арга зүй	3-р анги	12	Манай орны байгаль	- Орчноо ажиглацгаая - Бидний эргэн тойрны газрын гадаргын хэлбэр - Манай орны гол мөрөн - Өнөөдөр гадаа ямар байна вэ? - Одоо ямар улирал болж байгаа вэ? - Манай орны байгаль олон янз - Манай орны ой тайга, хээр тал, говь цөл - Бидний мэдэх амьтан - Бидний мэдэх ургамал - Хүмүүсийн эрхлэх ажил хөдөлмөр
3	2009	Хүрээлэн буй орчинг тоглоомын явцад таниулах арга зүй	1-р анги	8	“Миний гэр, сургуулийн орчин”	- Миний эргэн тойронд юу байдаг вэ? - Гэрээс сургууль хүрэх замд - Соёл үйлчилгээний газартай танилцъя - Дүгнэлт хичээл

ХОЁРДУГААР БҮЛЭГ.

“ХҮН-ОРЧИН” ХИЧЭЭЛД СУДАЛГААНЫ ҮНДЭСТЭЙ ХАНДАХ НЬ

1.1. Хичээлийн бэлтгэл судалгаа, түүний аргачлал, жишээ

Хичээлийн бэлтгэл судалгаа буюу “Кёсай кенкю” гэдэг нь тухайн хичээлээр тавьсан зорилгодоо хүрэхийн тулд хийж буй судалгаа юм. Энэ нь тасралтгүй үргэлжлэх үйл ажиллагаа бөгөөд тухайн хичээлийн бэлтгэлд өмнөх хичээлийн явц, үр дүнг бүтээлчээр хэрэглэдэг, өнөөдрийн хичээлээс дараагийн хичээлийн бэлтгэлд хэрэглэх санааг олж авч байдаг үе шаттай судалгаа юм. Хичээлийн бэлтгэл судалгаа нь дараах судлагдахууны цогц юм. Үүнд:

1. Судлагдахууны агуулгын судалгаа
2. Мэдлэг эзэмшилтийн явцын судалгаа
3. Заах арга барилын судалгаа
4. Үнэлгээний судалгаа
5. Хэрэглэгдэхүүний судалгаа

1. Судлагдахууны агуулгын судалгааг хэрхэн хийх вэ?

Агуулгын судалгааг хийхдээ боловсролын стандарт, үндэсний хөтөлбөр, сурах бичгийн агуулгыг нарийвчлан судалж, агуулгын хүрээг ангиар нь бүлэглэн дараах аргачлалын дагуу хийж болно. Үүнд:

1. Тухайн хичээлийн агуулгыг жагсаана.
2. Түүнийгээ багцлан, энгийнээс нарийнд, ерөнхийгөөс тусгайд шилжүүлэх замаар бүлэглэнэ.
3. Багцалсан агуулгыг хэрэгжүүлэх суралцахуйн үндсэн үйл ажиллагааг баримжаална.
4. Тухайн үйл ажиллагаагаар дамжуулан эзэмших чадваруудыг ур ухааны нэгжээр томьёолон бичнэ.
5. Чадваруудыг хичээлийн зорилго, зорилт болгон томьёолно.
6. Агуулгын залгамж холбоог гаргана.

Хичээлийн судлагдахуун ба ур ухааны нэгжийг зөв тодорхойлсноор суралцагчдын эзэмших мэдлэг, чадвар болон хичээлийн зорилго, зорилт тодорхой харагдана. Жишээ нь: 2-р ангийн “Хүн-Орчин” хичээлийн “Сургуулийн орчин” нэгж хичээлийн агуулгыг хэрхэн гаргасныг дараах хүснэгтээс харна уу.

“Хүн-Орчин” 2-р анги. “Сургуулийн орчин” нэгж хичээлийн сэдвийг багцалсан нь:

№	Ээлжит хичээл	Хугацаа	Хичээлийн хэлбэр
1	Бид сургууль дээрээ • Бид сургууль дээрээ • Бид юу хийж чадах вэ?	70 минут	Экскурс Танхимын хичээл
2	Сургуулийнхаа түүхтэй танилцацгаая	35 минут	Танхимын хичээл
3	Сургуулийн дүрэм • Сургуулийн дүрэм • Ангийн журам	70 минут	Танхимын хичээл

Эндээс үзвэл “Бид сургууль дээрээ” ээлжит хичээлийг хоёр цаг судлах бөгөөд эхний цагт сургуулийн орчноор аялж, сургуулийн дотоод орчинтой танилцах ба дараачийн цагт нь захирал, сургалтын менежер, номын санч, эмч, хөгжмийн багш, биеийн тамирын багш, цайны газрын ажилчин, үйлчлэгч зэрэг хүмүүстэй уулзаж ярилцан, тэдний ажил, мэргэжлийн онцлогтой танилцана.

Хичээлийн агуулгын судлагдахуун ба ур ухааны нэгжийг зөв тодорхойлсноор суралцагчдын эзэмших мэдлэг, чадвар болон хичээлийн зорилго, зорилт тодорхой харагдана.

Нэгж хичээлийн агуулга:

№	Ээлжит хичээл	Хугацаа	Агуулга	
			Судлагдахуун	Ур ухаан

1	Бид сургууль дээрээ	35'	-Сургуулийн бүтэц зохион байгуулалт: Захирал, сургалтын менежер, номын санч, эмч, хөгжмийн танхим, биеийн тамирын танхим, цайны газар, ариун цэврийн өрөө гэхмэт. -Үйлчилгээний ур чадвар, соёл	• -Сургууль дотроо экскурс хийх замаар сургуулийнхаа бүтэц зохион байгуулалттай танилцах, байршлыг мэдэх • Сургуулийн захирал, эмч, номын санч, сургалтын менежер зэрэг хүмүүсийг мэддэг болох • Зөв боловсон үйлчлүүлэх, зөв харилцах
2	Бид юу хийж чадах вэ?	35'		
3	Сургуулийнхаа түүхтэй танилцагч	35'	-Сургуулийн түүх -Сургуулиас төрсөн алдартнууд -Сургуулийн онцлог -Ахмад багш нар	• Сургуулийнхаа түүхийг мэдэх • Алдар цуутай хүмүүсээр бахархах • Сургуулийнхаа онцлогийг мэдэх
4	Сургуулийн дүрэм	35'	• Дүрэмт хувцас өмсөх • Цаг баримтлах • Анги тахимдаа хог хаяхгүй, цэвэр байх • Сургуулиас зохион ажилд оролцох • Сургууль, ангийн эд зүйлсийг хамгаалах	• Сургуулийн орчин биеэ зөв авч явах, мэдлэх хүндлэх ёсонд суралцах • Анги танхимдаа эрүүл цэвэр орчинг бүрдүүлэх • Сургуулийн эд хогшлыг хайрлан хамгаалах
5	Ангийн журам	35'	• Хичээлдээ идэвхтэй оролцох, жижүүр сурагчийн тавьсан шаардлагыг биелүүлэх • Гэрийн даалгаврыг тогтмол хийх • Найз нөхдөө хүндэтгэх • Хичээлээ таслахгүй, хоцрохгүй байх, бусдын үгийг анхааралтай сонсох • Дэг журмаа хэрэгжүүлэх	• Анги хамт олон, найз нөхдөө хүндэтгэх • Зөв харилцах • Хичээл таслахгүй, хоцрохгүй байх • Бусдын үгийг анхааралтай сонсох • Дэг журмаа хэрэгжүүлэх, мөрдөх

Агуулгын залгамж холбоог дараах байдлаар авч үзнэ. Үүнд:

1. Анги хоорондын залгамж холбоо (заримдаа босоо холбоос гэх нь бий). Энэ нь хичээлийн агуулга анги ахих тусам хэрхэн өөрчлөгдөж байгаа болон суралцагчдын эзэмших мэдлэг, чадвар хэрхэн ахиж байгааг судална гэсэн үг юм.
2. Сэдэв хоорондын залгамж холбоо(заримдаа хөндлөн холбоос гэх нь бий). Энэ нь хичээлийн агуулга өмнөх болон дараачийн сэдвийн агуулгатай хэрхэн холбогдож буйг харуулна.

Жишээ нь: “Хүн-Орчин” хичээлээр сургуулийн орчны талаарх суралцагчийн мэдлэг, чадвар хэрхэн ахиж байгааг авч үзвэл: 1-р ангид өөрийн сургуультай танилцах, 2-р ангид сургуулийн бүтэц, зохион байгуулалт, дүрэм журамтай танилцах, дагаж мөрдөх, 3-р ангид сургуулийн орчинтой танилцаж, нийгмийн харилцаанд оролцох гэх мэт /Бүдүүвчийг үзнэ үү/.

Залгамж холбоо:



2. Мэдлэг зэмшилтийн судалгааг хэрхэн хийх вэ?

Энэ судалгааг тухайн хичээлийн агуулга нь хүүхдийн хөгжлийн түвшинд таарч байгаа эсэх, тухайн хичээлийн агуулгыг судлахад суурь болж өгөх мэдлэг, чадварыг хүүхдүүд ээмшсэн байгаа эсэх гэсэн 2 түвшинд явуулна. "Бид сургууль дээрээ" нэгж хичээлийн хөтөлбөрийг боловсруулахдаа 1-р ангийн "Сургуультайгаа танилцах" нэгж хичээлийн хөтөлбөртэй уялдуулан сурагчдын мэдлэг эзэмшилтийн түвшинг тогтооно. Сурагчдын өмнөх төсөөллийг илрүүлэхдээ хэд хэдэн арга хэрэглэж болно. Тухайлбал, ярилцлага хийх, тест авах, зураг тайлбарлуулах, уралдаан тэмцээн зохион байгуулах гэх мэт.

3. Заах арга барилын судалгааг хэрхэн хийх вэ?

Ауулгын болон мэдлэг эзэмшилтийн явцын судалгаанд үндэслэн тухайн хичээлд тохиромжтой сургалтын арга, хэлбэрүүдийг сонгоно. Сургалтын олон арга байдаг бөгөөд энэ нь

- Сургалтыг үр дүнтэй болгох
- Хичээлийг бүтээлч болгох
- Сурагчдыг идэвхжүүлэх зорилготой бөгөөд тухайн хичээл болон сэдвийн онцлог, сурагчдын нас, сэтгэхүйн онцлог, сургуулийн орчин, нөхцлийн ялгаатай байдлаас хамаарна.

Мөн хичээлийг нийт ангид заах уу?, ганцаарчилж заах уу?, багаар ажиллуулах уу?, хос хосоор нь ажиллуулах уу?, илтгэл тавих маягаар уу? гэх мэт ямар хэлбэрээр хичээлээ зохион байгуулах нь илүү үр дүнтэй болохыг тунгаан бодох хэрэгтэй. Хичээлийн цаг хязгаартай учраас цагийн нягтралыг сайн бодолцох хэрэгтэй. Нэгж сэдвийг судлахад оноогдсон цагийг ямар байдлаар хуваарилах вэ? гэдэг асуудал тухайн нэгж сэдвийн хичээлүүдийг яаж зохион байгуулахаас шалтгаална. Тиймээс үр дүнтэй цагийн хуваарилалт гэдэг нь зөвхөн ээлжит хичээлд л хамаатай биш, нэгж сэдвийн хувьд ч мөн анхаарах ёстой зүйл юм. Үүний тулд хичээлийн агуулгыг гүнзгий сайн судалсан байх хэрэгтэй болж байна. Энэхүү агуулгыг ямар арга, хэлбэрээр

явуулбал илүү үр дүнтэй, суралцагчдад ойлгоход хялбар дөхөм болох талаар урьдчилан тооцоолсон байх хэрэгтэй. Сургалтын арга, агуулга хоёр хоорондоо салшгүй холбоотой. Жишээ нь, 2 дугаар ангид “Бид сургууль дээрээ” ээлжит хичээлд экскурсийн аргыг хэрэглэдэг бол, “Сургуулийн түүхтэй танилцаагай” хичээлийг заахдаа тус сургуулийг төгссөн алдар цуутай хүмүүстэй уулзах, ярилцах аргаар, “Сургуулийн дүрэм журамтай танилцаагай” хичээлийг заахад бүлгээр ажиллаж жижиг хэмжээний хэлэлцүүлгийг хийх гэх мэтээр агуулгатайгаа уялдуулан, олон янзын аргыг хэрэглэж болно.

4. Үнэлгээний судалгааг хэрхэн хийх вэ?

Үнэлгээг хийхдээ суралцагчдын эзэмшвэл зохих мэдлэг, чадварыг урьдчилан тооцох нь чухал. Гэхдээ суралцагчид, ялангуяа бага ангийн хүүхдүүд хичээлээр үзсэн бүх агуулгыг багшийн төсөөлснөөр бүрэн авах боломжгүй байж болно. Энэ тохиолдолд багш сайн, дунд, муу гэх мэт үнэлгээг яаран тавих нь суралцагчдын идэвх, оролцоог бууруулах магадлалтай байдаг учраас багш ангид байгаа нийт суралцагчдынхаа мэдлэг эзэмшилтийн түвшин, бие бялдар, сэтгэхүй, хэл ярианы онцлог зэргийг сайтар судалж, түүнд нь тохируулан хүүхэд тус бүрт үнэлгээ хийх нь зохимжтой. Үнэлгээг хийхдээ дараах зүйлийг харгалзахыг зөвлөж байна. Үүнд:

- Хүүхэд бүрийн хөгжлийн **ахицыг** тодорхойлох
- Хүүхдийн **хөгжлийн бүх талыг** хамрахыг хичээх
- Хүүхдийн **танин мэдэх сонирхлыг идэвхжүүлэх**
- Хүүхдийн **өөртөө итгэх итгэлийг дэмжихэд** чиглэсэн байх зэрэг болно.

5. Хэрэглэгдэхүүний судалгааг хэрхэн хийх вэ?

Тухайн хичээлээр судлах гэж буй агуулгын боловсролын ач тусыг хүүхдүүдэд мэдрүүлэхийн тулд ямар хэрэглэгдэхүүнийг ашиглавал илүү үр дүнтэй байх вэ? гэдгийг сайн тунгаан бодох нь зүйтэй. Энэ судалгаа нь хичээлийн сэдэв, агуулга, арга зүйгээс ихээхэн хамаардаг. Гарын доорх материал ашиглан суралцагчдаар өөрсдөөр нь сургалтын хэрэглэгдэхүүнийг бэлдүүлж, ашиглах нь илүү үр дүнтэй байгаа нь олон улсын туршлагаас харагдаж байна. Тухайлбал, байгалийн ухааны хичээлийн судлагдахуун нь байгаль дээрх бодит зүйлс байдаг. Жишээ нь, мод, чулуу, хөрс, ургамал, амьтан гэх мэт. Эдгээрийг суралцагчид шууд байгаль дээр нь ажиглаж, судалж, турших боломжтой бөгөөд эдгээрийг ашиглан хичээлийн хэрэглэгдэхүүнийг ч хийх боломжтой. Тухайлбал: хатаадас, ургамлын хатаасан навч, боргоцой, чулуу зэргийг ашиглан төрөл бүрийн амьтан, ургамал, байшин, барилга, тоглоом гэх мэт зүйлсийг бэлтгэн хичээлдээ ашиглах бүрэн боломжтой байдгаараа давуу талтай.





Сурагчдын хийсэн бүтээлээс

2.2. Хичээлийн ажиглалт, аргачлал, жишээ

Хичээлд ажиглалтыг яаж хийх вэ?

Хичээлийн судалгааны чухал хэсэг бол хичээлд ажиглалт хийх явдал юм. Хичээлийг ажиглахдаа Хэн? Юуг? Яаж? ажиглахыг урьдчилан төлөвлөж, тогтох хэрэгтэй.

Хичээлийн ажиглалтыг хийхдээ дараах үндсэн үйл ажиллагааны дарааллаар явуулна. Үүнд:

1. Зорилго тодорхойлох
2. Нийтэд зарлах
3. Хичээлийг ажиглах
4. Ажиглах хуудас бөглөх
5. Хэлэлцүүлэгт бэлтгэх

1. Зорилго тодорхойлох

Хичээлийн ажиглалтыг явуулахдаа юуны түрүүнд анхаарах ёстой зүйл бол тухайн судалгаат хичээлээр чухам юуг илрүүлэх гэж байгааг тодруулах явдал юм. Өөрөөр хэлбэл, судалгаат хичээлийнхээ зорилгыг тодорхой болгох хэрэгтэй. Тухайлбал:

- Багшийн үйл ажиллагааг
- Сурагчдын үйл ажиллагааг
- Сэдэлжүүлэлтийг
- Хүүхдэд тавих асуултыг
- Самбар ашиглалтыг ажиглах гэх мэт.

Зорилго тодорхой болсноор ажиглалт хийх багш нар нэгэн зорилгын дор үр дүнтэй судалгааг хийх болно. Уламжлалт нээлттэй хичээлийн үед гардаг гол алдаа нь ажиглагчид тодорхой зорилго, үүрэггүй хичээлд суугаад анхаарах ёстой гол хэсгийг илрүүлэлгүй, нэг л зүйлийг давтан ярих хандлагатай байсан бөгөөд хэлэлцүүлгийн төгсгөлд ярих багш нар ярих зүйлгүй болж “санал нэг байна” гэсээр ярилцлага дуусдагт оршино.

2. Нийтэд зарлах

Зорилгоо тодорхой болгосны дараа ажиглалт хийх нийт хүмүүст мэдэгдэнэ. Өнөөдрийн судалгаат хичээлээр бид энэ үйл ажиллагааг илрүүлэхийн тулд ийм ийм зүйлийг ажиглана гэдгийг танилцуулна. Тухайн судалгаат хичээлийн зорилгоос хамаараад дараах зүйлсээс сонгож ажиглана. Үүнд:

1. Хөтөлбөрийн хэрэгжилтийн байдал:
 - Хөтөлбөрийн цагийн төлөвлөлт оновчтой болсон эсэх
Хичээлийн үе шат бүрийн цагийн хуваарилалтыг хэр бодитой тооцож чадсан эсэхийг ажиглан тэмдэглэл хөтлөх
 - Зорилго, зорилтын томъёолол оновчтой болсон эсэх
Хичээлийн хэрэгцээнд суурилан зорилгыг зөв тодорхойлсон эсэхийг анзаарна. Зорилго, зорилт нь хоорондоо уялдсан эсэх. Өөрөөр хэлбэл, дэвшүүлсэн зорилгын хүрээнд зорилгоо зөв тодорхойлж чадсан уу гэдгийг анзаарах хэрэгтэй. Багш нарын хөтөлбөрийг харахад том зорилго тавиад жижиг зорилтыг дэвшүүлсэн, эсвэл жижиг зорилгын доор том зорилтыг тавьсан, үг өгүүлбэрээ буруу томъёолсон зэрэг нийтлэг

алдаа дутагдал байдаг. Энэ нь хөтөлбөрийн судалгааг бодитой хийгээгүйтэй холбоотой. Зорилго, зорилтоо оновчтой, зөв тодорхойлох нь хичээлийн дараагийн үйл ажиллагаанд сайнаар нөлөөлдөг.

- Хичээлийн эхлэл, зохион байгуулалтын төлөвлөлт:
Анги зохион байгуулалт, багийн зохион байгуулалт зэрэг нь тухайн хичээлийн агуулга, арга зүй, хэлбэртэй холбоотой байсан эсэхийг анзаарна.
- Сэдэлжүүлэлтийг оновчтой хийсэн эсэх:

Сурагчдын сонирхлыг хэр татаж, хичээлийг ямар нэгэн асуудалгүй, тасралтгүйгээр үргэлжлүүлэх эхлэлийг тавьж чадсан эсэхийг анзаарна.

- Шинэ мэдлэг эзэмших үйлийг оновчтой төлөвлөсөн эсэх:
Сурагчдаар мэдлэг бүтээлгэхээр төлөвлөсөн байдлыг анзаарна. Мэдлэг бүтээлгэх гэж бичсэн хэрнээ мэдлэг дамжуулахаар төлөвлөсөн байх нь элбэг тохиолддог.
- Бататгах дасгал даалгаврууд оновчтой эсэх:

Тухайн бүлэг сэдэвтэй холбоотой эсэхийг анзаарна. Мөн тухайн сурагчдын нас, сэтгэхүйн онцлог болон орон нутаг, сургуулийн орчин нөхцөлд нийцсэн, хүүхдийн бүтээлч үйл ажиллагааг дэмжсэн эсэхийг харна.

- Хичээлийн үнэлгээ, дүгнэлтийг хийсэн байдал:
Хичээлийн үнэлгээ нь зорилттойгоо тохирч байгаа эсэхийг анзаарна. Анх дэвшүүлсэн зорилттойгоо уялдаагүй бол хичээлийн зорилго биелсэн эсэхийг тооцоход бэрхшээлтэй байх болно.
- Гэрийн даалгаврын төлөвлөлт:
Гэрийн даалгавар нь өнөөдрийн хичээлийг бататгасан, хэрэглээ, дадал болгоход чиглэсэн, хүүхэд бүрийн ялгаатай байдлыг харгалзсан, сонирхолтой, мөн дараагийн хичээлтэй холбогдож байгаа эсэхийг анзаарна.

Анхаарах зүйл:

Хөтөлбөрийн хэрэгжилтийг ажиглагч хүн, тухайн хичээлийн хөтөлбөрийг урьдчилан сайтар судалсан байх ёстой бөгөөд эхний байдлаар өөрийн дүгнэлтийг бичиж, онцолж харах зүйлээ тодорхой болгох нь үр дүнтэй байх болно. Хичээл заах явцад хичээлийн хөтөлбөрт тусгагдсан үе шат бүр хэр оновчтой болж байгааг анзаарч тэмдэглэл хөтөлнө.

2. Хичээлийн агуулга:

- Агуулга нь тодорхой зорилго, чиглэлтэй эсэх
- Агуулга нь сургалтын хөтөлбөртэй уялдаж байгаа эсэх
Тухайн ангийн Үндэсний хөтөлбөрийн агуулгатай нийцэж байгаа эсэхийг анзаарах. Туршлагаас үзэхэд зарим хичээлд агуулга хүндэдсэн, хэт олон зүйлийг “хамж” орж байгаа байдал ажиглагддаг. Энэ нь хичээлийг үр дүнгүй, “хэлбэр төдий” хичээл болгодгийг анхаарах хэрэгтэй.
- Хичээлийн шинжлэх ухааны агуулга оновчтой эсэх
Тухайн сэдэвт хичээлээр сурагчдад шинжлэх ухааны шинэ мэдлэгийг үнэн зөв бөгөөд ойлгомжтой зааж байгаа эсэхийг анхаарах хэрэгтэй.
- Тухайн ангийн хүүхдийн нас сэтгэхүйн онцлогт тохирсон эсэх
Дэвшүүлж буй асуудал нь хүүхдийн нас, сэтгэхүйд тохирч байгаа эсэхийг анзаарах нь туйлын чухал юм. Хэт их мэдээллийг өгч өөрийгөө мэдлэгтэй гэдгээ харуулах гэж буй мэт сурагчдад хүртээмжгүй, ойлгомжгүй хичээл заахаас сэргийлэх хэрэгтэй.
- Агуулга нь бүх талыг хамарсан эсэх
Шинжлэх ухааны, онолын, танин мэдэхүйн, практикийн, хэрэглээний аль алийг нь хамарсан байх
- Агуулгын систем, дэс дараа, уялдаа холбоотой байдал
Агуулга нь өөр хоорондоо болон өмнөх, дараах агуулгатайгаа хэрхэн холбогдож байгааг анзаарах хэрэгтэй. Хичээл хоорондын уялдаа холбоог хангасан эсэхийг анзаарах хэрэгтэй.
- Амьдралтай холбосон эсэх

Анхаарах зүйл:

Хамгийн гол нь хичээлийн агуулга нь хэрэгцээ, зорилго, зорилттойгоо уялдаж чадсан эсэхийг анзаарах хэрэгтэй.

3. Сургалтын аргыг оновчтой сонгосон эсэх

- Сургалтын аргуудыг хэрхэн хослуулан болон дангаар хэрэглэсэн байдал
- Хүүхдийн нас сэтгэхүйн онцлогт тохирсон эсэх
- Хичээлийн сэдэв, зорилго, агуулгатай зохицсон байдал
- Багшийн туршлага, ур чадвар
- Бүтээлчээр хэрэглэсэн байдал

Анхаарах зүйл:

Тухайн сэдэвтэйгээ уялдуулан сурагчдын мэдлэг бүтээх үйлд тохирсон аргыг сонгосон эсэхийг анзаарна. Түүнчлэн, хэрэглэж буй аргынхаа онцлогийг сайтар мэдэж, хэдийд хэрхэн, яаж хэрэглэж байгааг анзаарч харах хэрэгтэй. Тухайлбал, тоглоомын аргыг хичээлийн аль үе шатанд (мэдлэг бүтээх, бататгах, дүгнэх гэх мэт) хэрэглэх нь оновчтой байсныг тооцоогүйгээс тоглож л байвал сайн хичээл мэт андуурч хичээлээ үр дүнгүй болгох тохиолдол байдаг.

4. Багшийн үйл ажиллагааг ажиглах
 - Сурагчдад сургалтын зорилго, зорилтыг танилцуулсан байдал /сэдэл хэрэгцээг төрүүлсэн/
 - Шинэ мэдээлэлтэй танилцуулсан байдал
 - Мэдлэг бүтээх үйл явцыг удирдсан байдал
 - Шинжлэх ухааны зүй тогтлыг ухамсарлуулах үйл явцыг удирдсан байдал
 - Онол практик хоёрыг холбож буй байдал
 - Эрэн сурвалжлах ба судалгааны үйл ажиллагааг зохион байгуулах
 - Суралцагчдын хөгжил, сургалтын явцад гарсан өөрчлөлтийг шалгах үнэлэх

Анхаарах зүйл:

Багш төлөвлөлтийн дагуу хичээлээ хэрхэн удирдан чиглүүлж, зохион байгуулж байгааг ажиглан, алдаатай, оноотой зүйлийг нь олж харах хэрэгтэй. Багшийн үйл хөдлөл, үг яриа, дохио зангаа, биеийн байрлал зэрэг нь зааж байгаа хичээлтэйгээ болон хүүхдийн үйл ажиллагаатай уялдсан эсэхийг ажиглана. Гэхдээ багшийг шүүмжлэх үүднээс бус, хичээлийг илүү үр дүнтэй, сайн зохион байгуулахад анхаарлаа хандуулах хэрэгтэй.

5. Сурагчийн үйл ажиллагааг ажиглах
 - Сурах эерэг сэдэл бий болох үйл ажиллагаанд орсон эсэх
 - Шинэ мэдлэг, чадварыг ойлгож ухамсарласан эсэх
 - Анализ, синтез хийх, харьцуулах системчлэх үйл ажиллагаа хийж байгаа эсэх
 - Байгаль, нийгмийн үзэгдэл, зүй тогтол, хуулиудыг ухамсарлах, шалтгаан үр дагаврын холбоог ойлгосон эсэх
 - Мэдлэг, чадвараа ашигласан байдал
 - Практик үйл ажиллагаанд бие даан оролцох, үүссэн асуудлыг бие даан шийдвэрлэх чадвар
 - Өөрөө өөрийгөө хянах оношлох байдал

Анхаарах зүйл:

Энэ үйл ажиллагааг хэд хэдэн аргаар ажиглаж болно. Гэхдээ үүнийгээ урьдчилан ярьж тохирсон байна. Зөвхөн нэг хүүхдийг үү, нэг багийн сурагчдыг уу, эсвэл бүх сурагчдыг ажиглах уу? гэдгийг тохирно. Сурагчдыг ажиглах хэд хэдэн арга байдаг бөгөөд үүнийг өмнөх зөвлөмжөөс харах боломжтой.

6. Цаг ашиглалтын байдал
 - Хичээлийн үе шат бүрт зарцуулсан хугацаа
 - Багшийн (ярих, бичүүлэх, тайлбарлах) үйл ажиллагаандаа зарцуулсан хугацаа
 - Сурагчийн (бие даан болон хамтран ажиллах, ярих, бичих, тайлбарлах) үйл ажиллагаандаа зарцуулсан хугацаа
 - Дидактик алхмуудад зарцуулсан хугацаа

Анхаарах зүйл:

Хамгийн гол нь тухайн хичээлийн агуулга цагтаа багтаж зорилгодоо хүрсэн үү гэдэг нь чухал. Өөрөөр хэлбэл, тухайн өдрийн төлөвлөлт зөв болсон эсэх, аль үе шат болон үйл ажиллагаанд хэдэн минут төлөвлөсөн, тэр нь зөв болсон эсэхийг анзаарч, дараа нь хэрхэн сайжруулах боломж байгааг харах хэрэгтэй.

7. Сургалтын хэрэглэгдэхүүн

- Сургалтын хэрэглэгдэхүүн нь хичээлд хэрэглэж буй сургалтын агуулга, дидактик зорилтод нийцэж байгаа эсэх
- Мэдлэг бүтээхэд дэмжлэг болж байгаа эсэх
- Хүүхдийн нас сэтгэхүйн онцлогт тохирсон эсэх
- Өнгө, үзэмж, эрүүл ахуйн шаардлага хангасан эсэх
- Бодитой, үр дүнтэй болсон эсэх

Анхаарах зүйл:

Олон “гоё” хэрэглэгдэхүүн хэрэглэхдээ биш хамгийн гол нь тухайн хичээлийн агуулга, дэвшүүлсэн зорилго, зорилтод нийцсэн эсэхийг харах нь зүйтэй. Тухайлбал, компьютер, проекторыг хэрэглэвэл сайн хичээл болдог мэтээр ойлгон, түүнийг заавал хэрэглэх ёстой гээд хөгжөөнт тоглоомын аргад хэрэглэх нь илүүц байдаг. Тоглоомын зааврыг хэлэхийн төлөө дэлгэцээр гаргаж, хүүхдээр уншуулах нь үр ашиггүй, цаг үрсэн ажил болдог.

Ажиглагчид ажил, үүргээ хуваарилан ажиглах хэдий ч, тухайн зүйлээр зөвхөн хязгаарлагдах нь зохисгүй. Жишээлбэл, цаг ашиглалтыг ажиглах үүрэгтэй хүн зөвхөн цагаа л хараад хичээлийн ерөнхий байдлыг харахгүй өнгөрөх нь буруу юм. Цаг ашиглалтыг голчлон ажиглангаа хичээлийн ерөнхий байдлыг ажиглах хэрэгтэй. Учир нь хичээлийн ерөнхий байдлыг харалгүйгээр хичээлийн сайн, мууг мэдрэх боломжгүй бөгөөд ажиглагчдад шинэ зүйл суралцах боломжийг ч олгохгүй юм.

3. Хичээлийн ажиглалт

Ажиглагчид 40 минутийн хичээлд биш, хичээлийн бэлтгэл судалгаанд анхаарлаа хандуулан, хичээлийг бүхэлд нь ажиглах ёстойг сануулна. Хичээлийн бэлтгэл хэр хангагдсанаас тухайн хичээлийн чанар, үр дүн харагдах учиртай.

Хичээлд ажиглалт хийхийн өмнө тухайн багшийн хичээлийн хөтөлбөртэй урьдчилан танилцсан байх хэрэгтэй. Учир нь, тухайн хичээлээр анх дэвшүүлсэн зорилго, зорилт, үйл ажиллагааг мэдэж байх нь өөрийн ажиглаж буй зүйлийг бүрэн гүйцэд илрүүлж, хэлэлцүүлэгт бэлтгэхэд тустай. Ажиглагчид хичээлийн явцад хөтөлбөрийг нь хамт тулгаж яваад аль хэсэгт нь алдаа гарч байна, түүнийг арай өөрөөр хэрхэн хийж болох байсан талаар тэмдэглэх хэрэгтэй. Учир нь хичээл дууссаны дараа зарим алдаанууд мартагдах магадлалтай. Судалгаат хичээлийн гол утга учир нь хичээлийн бэлтгэл судалгааг яавал сайтар хангаж, хичээлийг үр дүнтэй заах вэ гэдгийг илрүүлэхэд оршино. Улмаар багш өөрөө хөгжиж, тэгснээр сурагчид хөгжих болно.



4. Ажиглалтын хуудас бөглөх

Ажиглах зорилгоос хамаарч хичээлийн ажиглалтын тэмдэглэлийг янз бүрээр хөтөлж болно. Гэхдээ аль болох энгийн, хялбар байх хэрэгтэй (Энэ талаар дэлгэрэнгүй мэдээллийг “Хичээлд мониторинг хийх зөвлөмж” /УБ., 2009/-өөс мэдэж аваарай).

Жишээ болгон ажиглалтын тэмдэглэлийн хувилбаруудыг танилцуулж байна.

Ажиглалтын хуудас 1.

Сурагчдын оролцоог ажиглах хуудас.



Тайлбар: Та аль нэг баг болон сурагчийг сонгон өөрт ойлгомжтой байдлаар тэдний идэвх, оролцоог тэмдэглээрэй.

Ажиглалтын хуудас 2

Сэдэв:		Хичээл заасан багш:	
Огноо:		Ажиглалт хийсэн:	
Сурагчийн мэдлэг бүтээх үйл ажиллагаа		Багшийн дэмжлэг	

Ажиглалтын хуудас 3

Сэдэв:			Хичээл заасан багш:		
Огноо:			Ажиглалт хийсэн:		
Сайн тал		Дутагдалтай тал		Сайжруулах санал	

Ажиглалтын хуудас 4

<i>Хичээлээс олж авсан санаанууд</i> <i>Хичээлд ажиглалт хийх явцдаа өөрт төрсөн анхны сэтгэгдлийг тэмдэглэнэ.</i>	
Санал шүүмжлэл <i>Танд ямар зүйл шүүмжлэлтэй санагдсан бэ?</i> <i>Та яагаад эсрэг байр суурьтай байна вэ?</i> <i>Таны өгсөн шүүмжлэлийн гол санаа нь юу вэ?</i>	Эргэлзээтэй санагдлаа <i>Танд ямар зүйл нь эргэлзээтэй санагдсан бэ?</i> <i>Таны бодлоор яавал дээр вэ?</i>

Ажиглалтын протокол хөтлөх

Ажиглагч багш бүр өөрийн үүргийн дагуу болон хичээлийг ерөнхийд нь ажиглаж байх үедээ хичээлийн протоколыг хөтлөнө.

Протоколын хуудас

Хугацаа	Багшийн үйл ажиллагаа	Хугацаа	Сурагчийн үйл ажиллагаа	Санал, сэтгэгдэл

Ажиглагч багш, сурагчийн үйл ажиллагаа болон тухайн үед гарч байсан алдаа, оноотой зүйлийг сайтар тэмдэглэх хэрэгтэй. Энэ нь ажиглалтын хуудсыг бөглөх болон хэлэлцүүлэгт хэрэг болно. Бүх үйл ажиллагааг нэг бүрчлэн бичихээсээ илүү, гол анхаарах ёстой, цаашид анхаармаар зүйлийг тэмдэглэж явах нь оновчтой. Бүх үйл явцыг бүтэн бичнэ гэвэл цаг алдахын зэрэгцээ, зарим зүйлийг анзааралгүй өнгөрсөн байдаг.

Сэдэв:

Хичээл заасан багш:

Огноо.

Ажиглалт хийсэн багш:

Ажиглах зүйл:		
Оновчтой зүйл	Дутагдалтай зүйл	Сайжруулах боломж

Б. Хичээлийн явцыг бүхэлд нь ажиглах хуудас

Сэдэв:

Хичээл заасан багш:

Огноо.

Ажиглалт хийсэн багш/захирал/сургалтын менежер/:

Хичээлийн үе шат	Хугацаа	Оновчтой болсон зүйл	Дутагдалтай болсон зүйл	Сайжруулах боломж

Ажиглалт хичээл дууссаны дараа 3-5 минутийн хугацаанд хичээлийн тэмдэглэл бичсэн хуудас болон өөрийн санаанд байгаа зүйлдээ түшиглэн, ажиглалтын хуудсыг бөглөнө. Япон зөвлөхүүдийн санал болгосноор ажиглалтын хуудсан дахь оноонд ач холбогдол өгөх шаардлагагүй. Учир нь багш нарт хүндрэлтэй /хэдэн оноо тавих нь шийдэхэд хэцүү/, судалгаат хичээл гэхээсээ илүү уралдаан тэмцээний шинжтэй болох, уламжлалт нээлттэй хичээл рүү хазайх магадлалтай. Үүний оронд, энэ хичээлийг заахдаа цаашид юунд илүү анхаарах хэрэгтэй байна вэ? гэдгийг илрүүлж түүнийгээ хэлэлцүүлгийн явцад хэлж, санал бодлоо солилцох нь үр дүнтэй.

2.3. Хичээлийн хэлэлцүүлэг, аргачлал, жишээ

Ээлжит хичээлийн дараа хэлэлцүүлгийг явуулах нь хичээлийн үр дүнг сайжруулах сайн талтай бөгөөд дараагийн хичээлийн бэлтгэл болдогоороо онцлогтой.

Хэлэлцүүлгийг доорх дарааллаар явуулбал зохистой. Үүнд:

- Хичээл заасан багш хичээлийн зорилго болон хичээл заах явцад тохиолдсон ололттой ба хүндрэлтэй асуудлыг танилцуулна.
- Ажиглагчид өөрийн зорилгын хүрээнд анхаарсан зүйлээ хэлэх ба хичээл заасан багшийг шүүмжлэхийг урьдал болголгүй, төлөвлөсөн гол асуудалдаа анхаарлаа хандуулж, энэ бол бид бүгдийн хамтын хичээл юм гэсэн хандлагатай оролцож багшийн арга зүйг сайжруулах үүднээс зөвлөгөө өгнө (Би заасан бол гэсэн үүднээс хандах).
- Хичээл явуулсан багш, ажиглагч багш нарын зөвлөгөөг сонсоод дараагийн удаад хэрхэн сайжруулах талаар хэлнэ.
- Хэлэлцүүлгийн протоколыг хөтлөгч, багш нарын хэлсэн саналуудыг нэгд нэгэнгүй сайн тэмдэглэж, түүнийг баримтжуулан хадгална. Энэ нь тухайн хичээлийг цаашид сайжруулах чухал баримт бичиг болох учиртай.
- Удирдагч багш хэлэлцүүлгийн үйл ажиллагааг нэгтгэн дүгнэж, хаалтын үг хэлнэ.

Хичээлийн судалгааны баримт цуглуулах

Судалгааны багийн гишүүд судалгааны явцад өөрт хэрэгтэй баримтуудыг цуглуулж, дүн шинжилгээ хийх шаардлагатай болдог. Хичээлд ажиглалт хийсний дараа ажиглалтын тэмдэглэлдээ үндэслэн дараах асуултын дагуу холбогдох баримтуудыг цуглуулна. Үүнд:

Хичээлийн зорилго, зорилтууд

- ◆ Сурагчид юуны тухай хичээл болохыг ойлгосон уу? Яаж түүнийг мэдэх вэ?
- ◆ Хичээлийн төлөвлөлт хэр оновчтой байв?
- ◆ Сурагчдад ямар зүйл хүндрэлтэй байсан бэ?
- ◆ Хичээлийн амжилтын үзүүлэлт, шалгуурыг сурагчид мэдэж байсан уу?
- ◆ Сурагчид юу сурав? Сурсан зүйлс нь тэдэнд тустай байж чадсан уу?
- ◆ Хичээлийн үеэр сурагчид юу давтсан бэ? Давтлага тэдэнд тустай байсан уу?

Үйл ажиллагаа ба сургалтын хэрэглэгдэхүүн

- ◆ Хичээл дээр ашигласан сургалтын хэрэглэгдэхүүн болон гүйцэтгэсэн ажлууд нь сурагчдын сонирхлыг татаж чадсан уу?
- ◆ Сургалтын хэрэглэгдэхүүн нь бүрэн хэрэглэгдсэн үү?

Сурагчид

- ◆ Бүх сурагч даалгаврыг гүйцэтгэж чадсан уу? Яагаад?
- ◆ Хичээлийн аль хэсэг хүүхдүүдэд хамгийн сонирхолтой эсвэл хамгийн сонирхолгүй байсан бэ? Яагаад?

Анги зохион байгуулалт

- ◆ Төлөвлөсөн үйл ажиллагаануудын цагийн төлөвлөлт оновчтой байсан уу?
- ◆ Ангиар, бүлгээр, хосоор болон дангаараа хийсэн ажлууд нь оновчтой болж чадсан уу?
- ◆ Ангиар, бүлгээр, хосоор болон дангаараа ямар ажлууд хийсэн бэ? Тэд оновчтой байсан уу?
- ◆ Хийх ажлын зааварчилгаа тодорхой байж чадсан уу?
- ◆ Сурагчид бүгд оролцож чадсан уу?
- ◆ Сурагчдад тодорхой ахиц гарсан гэдэг нь ажиглагдсан уу?

Ерөнхий

- ◆ Хэрэв би энэ хичээлийг заавал юуг нь өөрчлөх вэ?

Хичээлийн судалгааны баримт цуглуулахдаа дараах загваруудыг ашиглаж болно.

Жишээ	
Ямар зүйл амжилттай болов?	<i>Сурагчид хичээлд сайн оролцсон. Сурагчийн тайлбар амжилттай болсон.</i>
Яагаад амжилттай болсон бэ?	<i>Сурагчид уралдах дуртай учраас тоглоомд их идэвхтэй оролцсон.</i>
Ямар зүйл амжилтгүй болов?	<i>Дасгалын хуудас сурагчдад дэндүү хүнд байсан.</i>
Яагаад?	<i>Сурагчид, ялангуяа 5-р бүлгийн сурагчид зааврыг анхааралтай сонсоогүй.</i>
Энэ сэдвийг дахин заахад юуг нь өөрчлөх шаардлагатай вэ?	<i>Сурагчдад хийх ажлыг нь сайн ойлгуулахын тулд ажлын хуудсыг өгөхөөсөө өмнө тодруулах олон асуулт асууж, хариулт авах ёстой байсан. Мөн зааврыг хүүхдүүдээр өөрсдөөр нь дахин хэлүүлсэн бол дээр байх байсан.</i>

Давуу тал, сул тал, боломж ба аюул занал

Аливаа зүйлийн давуу, сул тал, ашигтай зүйлс болон учирч болзошгүй аюул заналыг олох нь хичээлийг үнэлэх өөр нэг арга юм. Үүнийг SWOT шинжилгээ гэж нэрлэдэг.

Жишээ: “Хүн-Орчин”, 2-р анги, “Голын ус яагаад бохирдов?” хичээл дээр хийсэн голын усыг шүүх туршилтын ажил

Давуу тал	Сурагчид маш идэвхтэй, сонирхолтой оролцсон. Хийсэн ажлаа өөрөө үнэлэхэд хялбар байсан.
Сул тал	Олон сурагч шүүлтүүрийн цаасыг зөв нугалж чадахгүй байв. Харин багш түүнийг тооцоолоогүй.
Боломж	Дадлагын үеэр сурагчид туршилтыг өөрсдөө хийж үзэхийг хичээж байсан. Тиймээс туршилтыг байнга хийж байх нь зүйтэй.
Аюул	Сурагчид энгийн туршилтыг хийж чадахгүй байгаа нь дараа дараачийн ажилд саад болох магадлалтай тул туршилтыг байнга хийлгэх хэрэгтэй.

Ажиглалтын тэмдэглэлээс дараах нүдэнд харгалзах мэдээллийг түүж бичнэ. Чухал гэж үзсэн 3 санааг сонгон авч, тайлбар хийнэ.

Сонирхолтой санагдсан.

Сурагчдын оролцооны карт

Аятайхан болсон.

4-р ажил

Маш сайн болсон

Самбарын төлөвлөлт

ҮА-1- Сонгосон зурагнууд

ҮА-4- будах

Эргэлзээтэй санагдсан.

ҮА бүрийн дараа заавал сурагчаар яриулахаар төлөвлөсөн нь эргэлзээтэй санагдлаа. ҮА ямар зорилготой вэ? гэдгээ бодох. Жишээ нь: ҮА-1 ажиглах, ҮА-2 хэмжилт хийх, тэмдэглэл хөтлөх, нэгтгэн дүгнэх, ҮА-3 график байгуулах чадвар байсан. ҮА бүрийн зорилготой, аргазүйгээ уялдуулан төлөвлөх

Ойлгомжгүй болсон

Асуулт ойлгомжгүй, төлөвлөлт байхгүй байна. Оновчгүй, ихэвчлэн хаалттай асуулт тавьж байна. Багш өөрөө хариултыг хэлж, сурагчдад хариулах боломж өгөхгүй байна.

Диаграммын хүснэгт см хуваариас зөрж байсан тул хэмжээт цаас өгөх хэрэгтэй байсан.

Би ингэж бодохгүй байна.

Сурагчаар бодуулах үйл ажиллагаа бага гарлаа. Харахад шууд ойлгогдохоор хэтэрхий хялбар агуулгатай байна.

Гутал хөдөлдөггүй гэдгийг би мэдэхгүй байсан гэсэн багшийн хариулт оновчгүй.

Бусад: Дэвтэрт тэмдэглэл хөтлөх, анги дүүрэн харах, сурагчдын оролцоо, идэвх хичээлийн төгсгөл рүү буурч байгааг анхаарах, багш зааврыг өгөхдөө удаж байсан. ҮА-ны тоог цөөрүүлэх, нэгтгэх

ҮА-1 нэг, нэгээр нь тайлбарлуулж наалгах

Багш төвтэй болсон, сурагчдын ярих чадвар сул. Багаар ажиллах чадвар дунд зэрэг

Жич: ҮА – Үйл ажиллагаа

Хэрэв хичээлийн судалгаанд олон хүн оролцсон бол хэлэлцүүлэг эхлэхийн өмнө багаар ажиллаж саналаа нэгтгэнэ. Ингэхдээ дараах байдлаар ажиллуулж болно. Үүнд:

1. Багийн ажлын нэгдсэн хүснэгтийг ашиглан, гишүүд саналаа нэгтгэнэ. Хүснэгт.

2. Багийн ажлын нэгдсэн тэмдэглэлийн чухал үг, хэллэг гэсэн хэсэгт байгаа түлхүүр үгнүүдийг багцлан тухайн хичээлээр ямар зүйлд анхаарах шаардлагатай байгааг тодорхойлно.
3. Тэдгээр түлхүүр санааг зургаан баллын үнэлгээгээр үнэлж тайлбарыг хийнэ.
4. Багаас нэг гишүүн багийн ажлыг хэлэлцүүлнэ.

Хэлэлцүүлэгт бэлтгэх багийн ажлын нэгдсэн тэмдэглэл


Өгүүлбэр	Үг хэллэг	Үг
<i>Багийн гишүүн бүр өөрийн тэмдэглэлээс чухал гэж үзсэн өгүүлбэрийг сонгон авна</i>	<i>Өгүүлбэрээс чухал үг, хэллэгийг сонгон авна</i>	<i>Чухал үгийг сонгон авна</i>
ҮА-ны тоо ихэдсэн Ж: ҮА1,4 зорилго ижил тул аль нэгийг хасах Тэмдэглэл хөтлөх, график байгуулах чадварыг цаашид анхаарч ажиллах Багш их ярьж сурагчдад бодох, хариулах боломж олгохгүй байна. ҮА2 хэмжилт хийсэн биетүүдээс 1 амьд, 1 амьгүй биеийг сонгон авч нэгдсэн хүснэгтэд бичиж тайлбарлавал ямар вэ? Хэрэглэгдэхүүнийг багцалж зааврыг товч ойлгомжтой өгөх Дэвтэрт нь тэмдэглэл хөтлүүлэхэд анхаарах Багш баг бүрт очиж дахин, дахин заавар өгөөд байна. Цаг ашиглалт хийдэл ихтэй, ач холбогдол багатай асуултууд асууж байна. Багшийн асуултууд ихэнх нь хаалттай хүүхдээр бодуулахгүй, бодох хугацаа өгөхгүй, багш өөрөө хариулаад байна. Бэлэн хэлж өгөх хандлагатай, хариултыг өөрөө хэлж өгөөд байна. Биетийн хэлбэрийг тодорхойлоход сурагчид маш их эргэлзсэн Сурагчдын ялгаатай байдлыг тооцож үзэх	ҮА төлөвлөлт Чадвар ба ҮА холбоо Багш, сурагчийн ҮА харьцаа ҮА2 дотоод менежмент Хэрэглэгдэхүүний заавар Дэвтрийн тэмдэглэл Багшийн заавар Цаг ашиглалт Багшийн асуулт Багш төвтэй арга зүй Сурагчийн бодит чадвар Сурагчийн ялгаатай байдал	Төлөвлөлт Чадвар Харьцаа Менежмент Заавар Тэмдэглэл Цаг Асуулт Арга зүй Ялгаа

Хичээлийг засан сайжруулж, дараачийн шатанд дахин заах

- Багийн гишүүн бүр өөрсдийн ангид хичээлийн зарим хэсгийг өөрчлөн тухайн сэдвийг дахин заана.
- Дахин заах явцад ямар ахиц, дэвшил гарч байгааг тодорхойлно..
- Ямар асуудал тулгарч байгаа талаар бусдадаа захидал илгээнэ.

Зургаан баллын үнэлгээ


Эргэцүүлэл 1: Төлөвлөлт



Тайлбар:

Төлөвлөлт хийхдээ ҮА-ны тоо, дотоод менежмент, зорилго, үр дүн, сурагчийн идэвхтэй оролцоо, бодит чадварыг тооцох


Эргэцүүлэл 2: Багшийн аргазүй



Тайлбар:

Багшийн асуултад төлөвлөлтгүй, хаалттай асуултауд хэт олон, багш хүүхдийн хариулт сонсохгүй, сурагчдын ярих чадвар сулхан, дуу султай, багш төвтэй арга зүй давамгайлж байна гэж үзэж болохоор байна.


Эргэцүүлэл 3: Хэрэглэгдэхүүн



Тайлбар:

Хэрэглэгдэхүүний төлөвлөлтийг сайжруулах, сурагчдын чадвартай үйлдүүлэн зааврыг сайн өгөх. Хэрэглэгдэхүүнийг тараах, заавар өгөх, зэрэг механик ажилд цаг их алдаж байна. Самбар төлөвлөлт сайн, сурагчийн дэвтэр хөтлөлт сайнгүй.


Эргэцүүлэл 4: Чадвар



Тайлбар:

Сурагчийн багш нагварын нэгдсэн үнэлгээг харуулах зорилготой. Үнэлгээг сурагчийн өөрсөнтэй харьцуулан

Хичээлийн хэлэлцүүлгийн ширээг дараах байдлаар засаж болно. Үүнд, хичээл явуулсан багш голд нь суух ба баруун гар талд хэлэлцүүлгийг удирдах багш нь сууна. Харин зүүн гар талаас ажиглагч багш нар ярих дарааллын дагуу суусан байна. Судалгаат хичээлийн зорилгоос хамаарч хамгийн түрүүнд юуны тухай эхэлж ярихаа ажиглагчид тохиролцсон байна.



ГУРАВДУГААР БҮЛЭГ.

МОДУЛЬТ СУРГАЛТЫН АРГА ЗҮЙ

3.1. Сургалтын төлөвлөгөө, хөтөлбөр

Сургалт явуулах хэрэгцээ, үндэслэл

- Монголд хийгдэж буй боловсролын шинэчлэлийг эрчимжүүлэх, суралцагчдад цогц чадамж төлөвшүүлэх зорилго бүхий боловсролын стандарт, багшлах шинэ арга зүйн үзэл санааг сурталчлах
- Багш нарын арга зүйг сайжруулах бодит хэрэгцээ шаардлагад үндэслэн 2006-2009 онд Монгол улсад хэрэгжсэн “Суралцагчдын суралцахуйг дэмжих арга зүйн хөгжил” БСШУЯ-ЖАЙКА Олон улсын байгууллагын хамтарсан төслийн үр дүнг сурталчлах, суралцахуйг дэмжсэн арга зүйг Хүн-Орчин хичээлд туршсан туршлагаас хуваалцах, түгээн дэлгэрүүлэх

Зорилго:

Суралцахуйг дэмжсэн шинэ арга зүйн үзэл санааг ойлгох, Японы багш нарын хичээлийн судалгааны арга зүйг Хүн-Орчин хичээлийн жишээн дээр турших, багшлах арга зүйг өөрчлөн, шинэчлэх хэрэгцээ шаардлагыг ухааран, өөрийн үйл ажиллагаандаа хэрэгжүүлэх, бусдад түгээн дэлгэрүүлэх хүсэл сонирхлыг төрүүлэх

Зорилт:

- Боловсролын стандарт, багшлах шинэ арга зүйн үзэл санаа, багшлах арга зүйгээ шинэчлэх хэрэгцээ, шаардлагыг ойлгох, ухаарах
- 2006-2009 онд Монгол улсад хэрэгжсэн “Суралцагчдын суралцахуйг дэмжих арга зүйн хөгжил” БСШУЯ-ЖАЙКА хамтын төслийн явцад Хүн-Орчин хичээлээр боловсруулсан шинэ арга зүй, түүнийг хэрэгжүүлэх явцад хуримтлуулсан туршлагатай танилцах
- Хичээлийн бэлтгэл судалгаа хийх, сургалтын хөтөлбөр боловсруулахдаа түүнийг тусгах, хүүхдийн алдааг шинжлэх түүн дээр ажиллах арга барилуудаас суралцах
- Хичээлийн судалгаа хийх, хичээлийн судалгааны үр дүнг хөтөлбөр сайжруулахдаа ашиглах арга зүйд суралцах

Хүрэх үр дүн:

- Төслийн үзэл санааг бүрэн ойлгосон байх
- Хичээлийн бэлтгэл судалгаа, хичээлийн судалгааны талаар ойлголт мэдлэгтэй болсон байх
- Төслийн үзэл санааг түгээн дэлгэрүүлэх үйл ажиллагаанд оролцох хүсэл эрмэлзэлтэй болсон байх

Сургалтын агуулга

д/д	Сэдэв	Мэдлэг	Чадвар
1	Багшлах шинэ арга зүй /Хүн-Орчин хичээлийн жишээн дээр/	• Хүн-Орчин хичээлийн стандарт, агуулга • Багшлах шинэ арга зүй • Алдааны шинжилгээ	• Арга зүйг шинэчлэх хэрэгцээ шаардлагыг ухаарах • Шинэ арга зүйн бодит жишээтэй танилцах
2	Хичээлийн бэлтгэл судалгаа /Хүн-Орчин хичээлийн жишээн дээр/	• Хичээлийн бэлтгэл судалгаа • Хөтөлбөр боловсруулах арга зүй	• Хичээлийн бэлтгэл судалгаа хийх түүнд тулгуурлан хичээлийн хөтөлбөрийг оновчтой төлөвлөх арга зүйд суралцах
3	Хичээлийн судалгаа	• Хичээлийн ажиглалт	• Хүн-Орчин хичээлийг заах ажиглах,

	/Хүн-Орчин хичээлийн жишээн дээр/	• Хичээлийн хэлэлцүүлэг • Мониторинг • Хөтөлбөрийн үнэлгээ	хэлэлцүүлэг зохион байгуулах, хичээлийн хөтөлбөрт үнэлгээ хийх түүнийг засан сайжруулах арга зүйд суралцах
--	-----------------------------------	--	--

Сургалтын ерөнхий арга зүй

Хичээлийн хэлбэр	Сургагч багшийн чиглүүлэн дэмших үйл ажиллагаа	Суралцагчийн гүйцэтгэх үйл ажиллагаа	Сургалтын арга	Хэрэглэгдэхүүн
Мэдээлэл	• Тухайн мэдээлэлтэй холбоотой оролцогчдын ойлголт төсөөллийг асуух • Тухайн асуудлыг сонирхох, сэдэл хэрэгцээг төрүүлэх • Мэдээллийг товч тодорхой оновчтой хийх • Жишээ баримт татах • Харилцан ярилцах	• Мэдээллийг сонсож эргэцүүлэх • Нэмэлт тэмдэглэл хөтлөх • Сонирхсон асуултаа асуух • Харилцан санал солилцох	Лекцийг идэвхжүүлэх аргууд	PPP мэдээллийг урьдчилан хувилж тараах
Дадлага ажил	• Мөс хайлуулах дасгал төлөвлөн хийх • Баг зохион байгуулах • Ажлын зааврыг танилцуулах • Хэрэглэгдэх материалыг тараан өгөх • Хугацааг баримтлуулах • Ажлыг үнэлж дүгнэх, зөвлөн туслах	• Нөхөрсөг дулаан уур амьсгалыг бүрдүүлэх • Багийн дотоод зохион байгуулалт хийх • Бүлгээр хамтран ажиллах, харилцан бие биеэ хүндэтгэх • Нэгдсэн шийдэлд хүрч хамтын бүтээл гаргах • Бүтээсэн зүйлээ нийтээр хэлэлцэх	Бүлгээр судалгаа хийх аргууд	Үйл ажиллагааны зааварчилгааг урьдчилан бэлтгэсэн байх
Хэлэлцүүлэг	• Хэлэлцүүлгийн дүрмийг танилцуулах • Хэлэлцүүлгийн дарааллыг тогтоох • Анхааралтай сонсож дүгнэх	• Дүрмийн дагуу соёлтой оролцох • Бусдыг анхааралтай сонсох • Санал, үзэл бодлоо үндэслэлтэйгээр илэрхийлэх • Тэмдэглэж авах	Хэлэлцүүлэг зохион байгуулах аргууд	Хэлэлцүүлгийн удирдамжийг багш урьдчилан төлөвлөсөн байна.

Сургалтад ашиглах материал

1. Багшлахуйн хөгжил. “Хүн-Орчин” хичээлийн модуль. УБ., 2013
2. Багшлахуйн хөгжил. “Үндсэн модуль” УБ., 2013
3. Хүн-Орчин хичээлийн 1-3 дугаар ангийн сурах бичиг. УБ., 2007-2009
4. ЕБ-ын 12 жилийн сургуулийн Хүн-Орчин хичээлийн 1-3 дугаар ангийн Үндэсний хөтөлбөр, УБ., 2007-2009
5. Амьд биеийн хөгжлийг таниулах арга зүй. Зөвлөмж 1. БСШУЯ, Жайка ОУБ-ын хамтарсан “Суралцагчдын суралцахуйг дэмжих арга зүйн хөгжил” төсөл. УБ., 2007
6. Монгол орны бүс нутгийн байгаль ба нийгэм ахуйн шүтэлцээг таниулах арга зүй. Зөвлөмж 2. БСШУЯ, Жайка ОУБ-ын хамтарсан “Суралцагчдын суралцахуйг дэмжих арга зүйн хөгжил” төсөл. УБ., 2008
7. Хүрээлэн буй орчинг тоглоомын явцад таниулах арга зүй. Зөвлөмж 3. БСШУЯ, Жайка ОУБ-ын хамтарсан “Суралцагчдын суралцахуйг дэмжих арга зүйн хөгжил” төсөл. УБ., 2009

3.2. Арга зүйн төлөвлөлт

Цаг	Сэдэв	Гүйцэтгэх үйл ажиллагаа	Хэлбэр	Сургагч багш
Нэг дэх өдөр Зорилго: Суралцахуйг дэмжсэн шинэ арга зүйн талаар ойлголттой болох				
Хоёр дахь өдөр Зорилго: Суралцахуйг дэмжсэн шинэ арга зүйн талаарх ойлголтоо гүнзгийрүүлэх				
9:00-9:30 30 минут	2.Суралцахуйг дэмжсэн арга зүйг туршин хэрэгжүүлсэн нь	2.1 Мөс хайлуулах дасгал	Дасгал	
9:40-10:20 45 минут		2.2 “Хүн-Орчин” хичээлийн онцлог, арга зүйг шинэчлэх хэрэгцээ, шаардлага	Мэдээлэл Хэлэлцүүлэг	
10.40-13.00 135 минут		2.3 Өмнөх төслийн үр дүн /“Хүн-Орчин” хичээлийн жишээн дээр DVD үзэх, зөвлөмжүүдийг судлах, хэлэлцэх/	Мэдээлэл дадлага ажил	
14.00-16.15 135 минут		2.4 Алдааны шинжилгээг сургалтанд тооцох /”Хүн-Орчин” хичээлийн жишээн дээр/	Мэдээлэл дадлага ажил	
16:25-17:10 45 минут		2.5 Арга зүйн шинэчлэлийн талаар ойлголтоо нэгтгэх бүлгийн хэлэлцүүлэг	Хэлэлцүүлэг	
17:20-17:50 30минут		2.6 Нэгдсэн хэлэлцүүлэг, асуулга	Хэлэлцүүлэг	
Гурав дахь өдөр Зорилго: Хичээлийн бэлтгэл судалга хийх арга зүйд суралцах				
9:00-10:30 90 минут	3. Хичээлийн бэлтгэл судалгаа	3.1 Хичээлийн бэлтгэл судалгаа	Дадлага ажил	
10.50-17.20 270 минут		3.2 Хичээлийн хөтөлбөр боловсруулах, хичээлийн судалгааны бэлтгэлийг хангуулах	Дадлага ажил	
17:00-17:30 30 минут		3.3 Нэгдсэн хэлэлцүүлэг, асуулга	Хэлэлцүүлэг	
Дөрөв дэх өдөр Зорилго: Хичээлийн судалгаа хийх арга зүйд суралцах				
9:00-9:45 45 минут	4. Хичээлийн судалгаа	4.1 Туршилт хичээл заах, ажиглах	Дадлага ажил	
10:00-11:30 90минут		4.2 Хичээлийн ажиглалт судалгааны хэлэлцүүлэг	Дадлага ажил	
11:40-16:40 270минут		4.3 Хөтөлбөрийг засан сайжруулах	Дадлага ажил	
16:50-17:25		4.3 Нэгдсэн хэлэлцүүлэг	Хэлэлцүүлэг	
Тав дахь өдөр Зорилго: Модульт сургалтын үр дүнг нэгтгэн дүгнэх				
17:30-18:00		Сургалтын хаалт		

Үйл ажиллагааны дэлгэрэнгүй төлөвлөлт

Сэдэв 2. Суралцахуйг дэмжсэн арга зүйн талаарх ойлголтоо гүнзгийрүүлэх

Зорилго: Суралцахуйг дэмжсэн шинэ арга зүйн талаарх ойлголтоо гүнзгийрүүлэх

Зорилт:

1. “Хүн–Орчин” хичээлийн онцлог, арга зүйг шинэчлэх хэрэгцээ шаардлагыг ойлгох
2. “Хүн–Орчин” хичээлийн зөвлөмж I,II,III болон DVD материалыас хичээлийн судалгааны талаар ойлголтоо гүнзгийрүүлэх, шинэ санааг олж харах
3. “Хүн–Орчин” хичээлийг заах явцад сурагчдаас гарч болзошгүй хариу үйлдлүүдийн зөв шийдлийг олох арга зүйд суралцах

2.1 Мөс хайлуулах дасгал

Хугацаа: 30 минут

Зорилт: Оролцогчид харилцан танилцах, эерэг дулаан уур амьсгал бүрдүүлэх

Арга зүй:

Үйл ажиллагааны алхам	Хугацаа	Сургагч багшийн чиглүүлэн дэмжих үйл ажиллагаа	Арга	Оролцогчийн үйл ажиллагаа
Мөс хайлах дасгал	30 минут	• Үйл ажиллагааны зааварчилгааг өгнө • Хамтран гүйцэтгэнэ	Хосоор танилцах арга	1. Оролцогчид 5 минутийн хугацаанд хос хосоороо харилцан бие биетэйгээ танилцана. 2. Танилцсан хүнээ хамт олондоо танилцуулна. 3. Бие биедээ амжилт хүсэн алга ташина.

2.2 Арга зүйн шинэчлэл ба “Хүн–Орчин” хичээлийн онцлог

Хугацаа: 45 минут

Зорилт: Арга зүйн шинэчлэлийн талаарх ойлголтоо Хүн–Орчин хичээлийн онцлогтойгоор гүнзгийрүүлэх

Арга зүй:

Үйл ажиллагааны алхмууд	Хугацаа	Сургагч багшийн чиглүүлэн дэмжих үйл ажиллагаа	Арга	Оролцогчийн үйл ажиллагаа	Хэрэглэгдэхүүн
1. Өмнөх ойлголт төсөөллийг судлах	10 минут	Арга зүйн шинэчлэл, боловсролын стандарт, цогц чадамж, хичээлийн бэлтгэл судалгаа, хичээлийн судалгаа зэрэг ойлголтуудыг асууж ярилцана.	Асуулгын арга	Өөрсдийн ойлголтыг ярих, бодол санаагаа хуваалцах	
2. Мэдээлэл хийх	30 минут	Бэлтгэсэн мэдээллийг өгөх, харилцан санал солилцох	Илтгэх	Идэвхтэй сонсох, тэмдэглэх	Хавсралт 1.1.
3. Дүгнэлт	5 минут	“Хүн–Орчин” хичээлд арга зүйн шинэчлэл хийх хэрэгцээ шаардлагыг асууж ярилцах	Дүгнэн ярилцах	Өөрсдийн ойлголт төсөөллийг хэлэх, нэгдсэн дүгнэлтэд хүрэх	

2.3 Өмнөх төслийн үр дүн

Хугацаа: 135 минут

Зорилт: Суралцахуйг дэмжсэн шинэ арга зүйг “Хүн-Орчин” хичээл дээр туршсан талаар мэдээлэл сонсох видео материал үзэх, боловсруулсан зөвлөмжүүдийг судлах

Агуулга, арга зүй:

Үйл ажиллагааны алхмууд	Хугацаа	Сургагч багшийн чиглүүлэн дэмжих үйл ажиллагаа	Арга	Оролцогчийн үйл ажиллагаа	Хэрэглэгдэхүүн
1. Зөвлөмжүүдийн бүтцийг танилцуулах	15 минут	Зөвлөмж 1-3-ын бүтцийг танилцуулах	Лекц		Модулын 1.2. бүлгээс танилцуулах
2. Видео бичлэг үзэх	40 минут	“Хүн-Орчин” хичээлээр өмнөх төслийн үйл ажиллагааг харуулсан видео бичлэгийг үзүүлэх	Үзүүлэн таниулах, тайлбарлан ярих	Төслийн талаар ойлголтоо гүнгийрүүлэх, дүн шинжилгээ хийх	Видео хичээл, зураг
3. Зөвлөмж 1-3-ийг судлах, хэлэлцэх	80 минут	Оролцогчдыг 3 баг болгон зөвлөмж 1,2,3-ыг өгч, уншиж судлах ажлын зааварчилгааг өгөх	Зааврын дагуу унших арга	Зааврын дагуу хамтран ажиллаж агуулгыг бусдад танилцуулна.	Үйл ажиллагааны зааварчилгаа

Үйл ажиллагааны зааварчилгаа: Зөвлөмжүүдийг судлах:

Дараах алхмуудын дагуу зөвлөмжтэй танилцана.

- Зөвлөмжийн бүтэц, агуулгыг олж бүлэглэнэ үү.
Агуулга:
1-р бүлэг
 -
 2-р бүлэг
 - гэх мэт.
- Зөвлөмжид тусгагдсан шинэлэг үзэл санаануудыг жагсааж бичнэ үү.
 - ...
 - ...
 - ...
- Хичээлийн хөтөлбөрийн бүтцийг тодорхойлно уу

Бүлэг сэдвийн хөтөлбөр	Нэгж хичээлийн хөтөлбөр	Ээлжит хөтөлбөр	Хичээлийн хэрэглэгдэхүүн
• • ... •	• ... • • ..	• ... • ... • ...	• ... • ... • ...

- Зөвлөмж дэх туршилт хичээлүүдийн үр дүнг судална уу?

Шинэлэг арга зүй	Гарсан өөрчлөлт, үр дүн	
	Сурагчдад	Багшид

2.4 Алдааны шинжилгээг сургалтад тооцох хэрэгцээ, шаардлага

Хугацаа : 135 минут

Зорилт: “Хүн-Орчин” хичээлийг заах явцад сурагчдаас гарч болзошгүй хариу үйлдлүүдэд багшийн зүгээс хандах хандлагыг шүүн хэлэлцэх, зөв шийдлийг олох

Арга зүй:

Үйл ажиллагааны алхмууд	Хугацаа	Сургагч багшийн чиглүүлэх ажиллагаа үйл	Арга	Оролцогчийн ажиллагаа үйл	Хэрэглэгдэхүүн
1. Мэдээлэл	45 минут	Цумазуки буюу алдааны шинжилгээний талаарх мэдээлэл өгөх	илтгэх	Идэвхтэй сонсох, тэмдэглэх	Хавсралт 1.2.
2. Алдааны шинжилгээ хийх	80 минут	Оролцогчдыг 4 баг болгон хуваан дараах чиглэлээс сонгуулан алдааны шинжилгээ хийлгэнэ.	Бүлгээр хамтран ажиллах ярилцах	Гаргадаг алдаануудыг нэрлэн, түүний шалтгааныг олох, өөрсдийн гаргадаг хариу үйлдлийн зөв бурууг тунгаан хэлэлцэх	Үйл ажиллагааны зааварчилгаа
3. Дүгнэлт	10 минут	Багуудын хийсэн ажилд тулгуурлан дүгнэн ярина	Харьцуулан дүгнэлт хийх	Өөрсдийн өмнөх хандлагатай харьцуулан дүгнэлт хийх	Багуудын хийсэн бүтээл

Үйл ажиллагааны зааварчилгаа: Алдааны шинжилгээ хийх

- Оролцогчдыг 4 баг болгон хуваана.
- Баг тус бүр дараах чиглэлийн аль нэгээр судалгаа хийнэ. Үүнд:
 - Хүүхдийн буруу төсөөлөл
 - Багшийн үйл ажиллагаанаас үүдэлтэй алдаа
 - Хүүхдийн насны онцлогтой холбоотой алдаа
 - Хэлээд, тайлбарлаад байхад гаргадаг алдаа
 - Тесттэй ажиллах үед гаргадаг алдаа
- Сонгосон чиглэлээрээ багууд дараах хүснэгтийн дагуу ажиллана.

Гаргадаг алдаанууд	Түүний шалтгаан	Та хэрхэн ханддаг байсан бэ?	Тухайн алдааг хичээлд хэрхэн ашиглаж болох вэ?

2.5 Дүгнэлт, хэлэцүүлэг

Хугацаа: 45 минут

Зорилт: Арга зүйн шинэчлэлийн талаар оролцогчдын ойлголтыг нэгтгэх


Арга зүй:

Үйл ажиллагааны зааварчилгаа:

Дараах асуултын дагуу нэрийн хуудсанд өөрсдийн бодол санааг бичих хэсэгт бичнэ.

- “Арга зүйн шинэчлэл” гэдгийг та хэрхэн ойлгож байна вэ?

- 2 Таны арга зүйг шинэчлэгдэхэд чухал гэж үзсэн зүйлсээ жагсаан бичнэ үү?
- 3 Арга зүйгээ шинэчлэхэд тохиолдож буй бэрхшээл юу байна вэ?
- 4 Арга зүйгээ шинэчлэхийн тулд та хамгийн түрүүнд юу хийх вэ?



Сэдэв 3: Хичээлийн бэлтгэл судалгаа хийх арга зүйд суралцах

Зорилго: “Хүн-Орчин” хичээлээр бэлтгэл судалгааг явуулах, ээлжит хичээлд бэлтгэх арга зүйд суралцах

Зорилт:

1. Хичээлийн бэлтгэл судалгаа хийх арга зүйд суралцах
2. Судалгаанд суурилсан хичээлийн хөтөлбөр боловсруулах арга зүйд суралцах
3. Хичээлийн хэрэглэгдэхүүнийг сонгон бэлтгэх
4. Хичээлийн судалгаанд, ажиглагчид тодорхой үүрэгтэйгээр оролцохыг ойлгох

3.1 Хичээлийн бэлтгэл судалгаа

Хугацаа: 90 минут


Зорилт: Хичээлийн бэлтгэл судалгаа хийх арга барилд суралцах

Арга зүй:

Үйл ажиллагааны алхмууд	Хугацаа	Сургагч багшийн чиглүүлэн дэмжих үйл ажиллагаа	Арга	Оролцогчийн үйл ажиллагаа	Хэрэглэгдэхүүн
1. Мэдээлэл	20 минут	Хичээлийн бэлтгэл судалгааны талаар мэдээлэл өгөх	Илтгэх	Хичээлийн бэлтгэл судалгааны талаар ойлголт төсөөлөлтэй болох	Хавсралт 1.3.
2. Хичээлийн бэлтгэл судалгаа хийх	60 минут	Хичээлийн бэлтгэл судалгаа хийх үйл ажиллагааны зааварчилгааг танилцуулна. Багуудын ажлыг анхааралтай ажиглаж үнэлэлт дүгнэлт өгөх	Бүлгээр ажиллах тойргийн арга	1. “.....” ээлжит хичээлийн бэлтгэл судалгааг хийх 2. Судалгааны ажлыг багууд тойруулан судалж дүгнэх, үнэлэх 3. Багууд хийсэн ажлаа дахин нягтлан үзэх 4. Нийтэд ажлаа тайлагнах	Цаас, маркер, Зөвлөмж 2, стандарт, сурах бичиг, ажлын заавар
3. Дүгнэлт	10 минут	Хийсэн судалгааг үзэж, үнэлэлт дүгнэлт өгөх	Дүгнэлт ярилцлага		Судалгааны ажлууд

Үйл ажиллагааны зааварчилгаа: Хичээлийн бэлтгэл судалгаа хийх

- Оролцогчдыг жижиг баг болгон хуваана.
- Багууд том цаасан дээр тойрог зурж түүнийгээ 5 хэсэгт хуваан тухайн сонгосон хичээлийн бэлтгэл судалгаа хийнэ.
 - Хичээлийн агуулгын судалгаа
 - Мэдлэг эзэмшилтийн явцын судалгаа
 - Заах арга барилын судалгаа:
 - Үнэлгээний судалгаа:
 - Хэрэглэгдэхүүний судалгаа
- Багууд хийсэн ажлаа солилцон судална. Өөрсдийн дүгнэлтийг тойргийн гаднах хэсэгт харгалзах газарт нь бичнэ.
- Багууд судалгааны ажлаа танилцуулан дүгнэн ярилцана.



3.2 Хөтөлбөр боловсруулах, хэрэглэгдэхүүнийг бэлтгэх

Хугацаа: 270 минут

Зорилт: : Судалгаанд суурилсан хичээлийн хөтөлбөр боловсруулах арга зүйд суралцах

Арга зүй:

Үйл ажиллагааны алхмууд	Хугацаа	Сургагч багшийн чиглүүлэн дэмжих үйл ажиллагаа	Арга	Оролцогчийн үйл ажиллагаа	Хэрэглэгдэхүүн
1. Мэдээлэл	45 минут	Хөтөлбөрийн бүтцийн элементүүдийг оновчтой томъёолох талаар мэдээлэл өгөх	Харилцан санал солилцох	Өөрсдийн хөтөлбөр боловсруулдаг арга зүйтэй харьцуулан, тэмдэглэж авна.	Хавсралт 1.4.
2. Хөтөлбөр боловсруулах	90 минут	Оролцогчдыг 3 багт хуваан ижил сэдвээр хөтөлбөр боловсруулах болно гэдгийг танилцуулна	Бүтээн туурвих арга	Оролцогчид 3 баг болон нэг ижил сэдвээр хөтөлбөр боловсруулан хэлэлцүүлнэ.	Цаас, маркер сурах бичиг, зөвлөмж, стандарт, бусад
3. Хэлэлцүүлэг	45 минут	Хөтөлбөрийг үнэлэх, зөвлөгөө өгөх	Хэлэлцүүлгийн арга	Оролцогчид хөтөлбөрүүдийн давуу болон сул талуудыг шүүн хэлэлцэх замаар харилцан бие биеэс суралцана	Боловсруулсан хөтөлбөрүүд
4. Хөтөлбөрийг засан сайжруулах, хичээлийн судалгааны бэлтгэлийг хангах	90 минут	Багш оролцогчдыг 3 баг болгон хувааж ажил үүргийг хуваарилан өгч хичээлийн судалгааны бэлтгэлийг хангуулна.	Бүлгээр хамтран ажиллах	Багууд дараах 3 чиглэлээр ажиллана. - Хичээл заах, хөтөлбөр боловсруулах баг - Хичээлийн хэрэглэгдэхүүнийг бэлтгэх баг - Хичээлийн судалгааны зохион	Хөтөлбөр, сурах бичиг, стандарт, үнэлгээний хуудсууд, бусад

				байгуулалтыг хариуцах баг	
--	--	--	--	---------------------------	--

Сэдэв 4. Хичээлийн судалгаа хийх арга зүйд суралцах

Зорилго: Хичээлийн судалгааны арга зүйд суралцах

Зорилт:

1. Боловсруулсан хөтөлбөрийн дагуу хичээл заан турших
2. Хичээлийн ажиглалт судалгаа хийх арга зүйд суралцах
3. Хичээлийн хэлэлцүүлэгт тодорхой үүрэгтэйгээр оролцох арга барилд суралцах
4. Хэлэлцүүлгийн дагуу хөтөлбөрөө засан сайжруулах
5. Хичээлийн судалгааг ЗАН-ийн ажлын төлөвлөгөөндөө тусгах

4.1 Туршилт хичээл заах, ажиглах

Хугацаа: 45 минут

Зорилт: Бэлтгэсэн хөтөлбөрийн дагуу хичээлийн судалгаа явуулах арга зүйд суралцах

Арга зүй:

Үйл ажиллагааны алхмууд	Хугацаа	Сургагч багшийн чиглүүлэн дэмжих үйл ажиллагаа	Арга	Оролцогчийн үйл ажиллагаа	Хэрэглэгдэхүүн
1. Хичээлд бэлтгэх	10 минут	Сурагчдад хичээлийн зорилгыг тайлбарлаж өгөх	Тайлбарлах	Хичээлийн хэрэглэгдэхүүнийг байрлуулах, байраа эзлэх	Хөтөлбөр, ажиглалтын хуудас, хэрэглэгдэхүүн, анги танхим, тоног төхөөрөмж
2. Хичээл заах, ажиглах	35 минут	Хичээлийн явцыг ажиглах, бичлэг хийх	Ажиглах, тэмдэглэл хөтлөх	Хичээл заах Ажиглалт хийх	

Хичээлд ажиглалт хийхдээ энэхүү модулийн 2.2 бүлэгт байгаа ажиглалт хийх аргачлалын дагуу хийгээрэй.

4.2 Хичээлийн ажиглалт судалгааны хэлэлцүүлэг

Хугацаа: 90 минут

Зорилт: Хичээлийн судалгааны хэлэлцүүлэг зохион байгуулах арга зүйд суралцах

Агуулга, арга зүй:

Үйл ажиллагааны алхмууд	Хугацаа	Сургагч багшийн чиглүүлэн дэмжих үйл ажиллагаа	Арга	Оролцогчийн үйл ажиллагаа	Хэрэглэгдэхүүн
1. Удирдамжийг танилцуулах	10 минут	Оролцогчдод хэлэлцүүлгийн дараалал, журам, ёс зүйг тайлбарлаж өгөх	тайлбарлах	Анхааралтай сонсох	Хөтөлбөр, ажиглалтын болон мониторингийн хуудас, хэрэглэгдэхүүн, анги танхим, бичлэг
2. Хичээлийн хэлэлцүүлэг	60 минут	Хэлэлцүүлгийг удирдах	Ярилцлага, санал солилцох	Зааврын дагуу хэлэлцүүлэгт оролцож өөрийн санал дүгнэлтийг хэлэх, бичиж тэмдэглэж авах	
3. Дүгнэлт	20 минут	Багш туршилт хичээлийн явцыг дүгнэн ярихдаа онцлог зүйлсийг бичлэгээр үзүүлэн дүгнэнэ.		Мониторингийн хуудсыг бөглөж нэгтгэх	

Хэлэлцүүлэг хийх тухай энэ модулийн 2.3. бүлэгтэй сайтар танилцаж зааврын дагуу хийхэд анхаараарай.

4.3 Хөтөлбөрийг засан сайжруулах

Хугацаа: 270минут

Зорилт: Хөтөлбөрийг засаж сайжруулах, боловсронгуй болгох замаар хөтөлбөрийн талаар ойлголтоо гүнгийрүүлэх

Агуулга, арга зүй:

Үйл ажиллагааны алхамууд	Хугацаа	Сургагч багшийн чиглүүлэн дэмжих үйл ажиллагаа	Арга	Оролцогчийн үйл ажиллагаа	Хэрэглэгдэхүүн
Хөтөлбөрт анализ хийх	60	Хөтөлбөрт анализ хийх үйл ажиллагааны зааварчилгаатай танилцуулах	Анализ синтез хийх	Туршилт хичээлээр заасан хөтөлбөрийг үнэлэх	Анализийн хуудас
Хөтөлбөрийг засан сайжруулах	90 минут	Оролцогчдод ажиллах боломжийг бүрдүүлэх, асуултад хариулах	Бүтээн туурвих арга	Бие даан хөтөлбөрөө сайжруулан өөрийн арга барилд нийцүүлэх боловсруулах	Хөтөлбөр, сурах бичиг, стандарт
Хөтөлбөрийг солилцон судлах	45 минут	Үйл ажиллагааны зааварчилгааг танилцуулах	Хосоор ажиллах	Оролцогчид харилцан хөтөлбөртэй нь танилцах, оновчтой санааг тэмдэглэн авах	Хөтөлбөр
Хөтөлбөр боловсруулах арга зүйг эргэцүүлэх	45 минут	Үйл ажиллагааны зааварчилгааг өгөх	Эргэцүүлэмж бичих арга	Хөтөлбөрийн талаар өөрийн үзэл бодол, арга барилд гарсан өөрчлөлтүүд, шинэ санаанууд болон өөрийн хөтөлбөрийн шинэлэг байдал, хөтөлбөртэйгээ харьцуулан дүн шинжилгээ хийх	Хөтөлбөр хичээлийн тэмдэглэл
Дүгнэлт	30 минут	Хичээлийн судалгааг хийж сурахын ач холбогдлын тадаар нэгтгэн дүгнэж ярилцана	Асуулт хариулт, харилцан ярианы арга		

Үйл ажиллагааны зааварчилгаа: Хөтөлбөрт анализ хийх

Судалж буй ээлжит хичээлийн хөтөлбөр:

- Анги.....
- Хичээлийн нэр
- Нэгж сэдвийн нэр

Багш хөтөлбөрөө боловсруулахдаа ямар баримт бичгийг ашигласан.

№	Баримт бичгүүд	
1.	Боловсролын стандарт	

2.	Боловсролын стандартын зөвлөмж	
3.	Сургалтын төлөвлөгөө	
4.	Агуулгын үлгэрчилсэн хүрээ	
5.	Сурах бичиг	
6.	Багшийн ном	
7.	Зөвлөмж, гарын авлага	
8.	Сургуулийн хөтөлбөр	
9.	Интернэтийн мэдээ, мэдээлэл	
10.		

1. Багшийн бүлэг сэдвийн хөтөлбөрт дараах элементүүд тусгагдсан эсэхийг үзэж, тохирох хэсэгт (+,-) тэмдэглэгээ хийнэ үү.

Хамрах хүрээ	☐
Хэрэгцээ	☐
Зорилго, зорилт	☐
Агуулга	☐
Арга зүй	☐
Сургалтын хэрэглэгдэхүүн	☐
Үнэлгээ	

2. Хамрах хүрээ нь:
- А. Тухайн бүлэг сэдвийг аль ангид судлахыг тодорхойлсон бол 1 оноо,
 - Б. Суралцагчдын нас, сэтгэхүйн онцлог, хамт олны хөгжлийн түвшинг тодорхойлсон бол 2 оноо,
 - В. Суралцагчдын өмнөх мэдлэг, чадвар, туршлагыг оношилсон бол 3 оноо,
3. Хэрэгцээ нь:
- А. Суралцагчдын бие бялдар, танин мэдэхүй, нийгэмшихүйн харилцаанд суралцах хэрэгцээнд баримжаалан тодорхойлсон бол 3 оноо,
 - Б. Суралцагчдын хэрэгцээг ерөнхий байдлаар тодорхойлсон бол 2 оноо,
 - В. Хувь хүний болон нийгмийн хэрэгцээг стандартад тодорхойлсноор үгчлэн томъёолсон бол 1 оноо,
4. Хөтөлбөрийн зорилго нь:
- А. Суралцагчийн цогц чадамжид хувь нэмэр оруулахуйц бүхэллэг байдлаар тодорхойлсон бол 3 оноо,
 - Б. Зорилгыг суралцагчийн цогц чадамжид хувь нэмэр оруулахуйц байдлаар тодорхойлсон боловч, жагсаан бичсэн бол 2 оноо,
 - В. Зөвхөн агуулга эзэмшүүлэхэд чиглэсэн зорилго тодорхойлсон бол 1 оноо
5. Зорилт нь:
- А. Цогц чадамжид баримжаалан тодорхой, үнэлэгдэхүйц байдлаар тодорхойлсон бол 3 оноо
 - Б. Цогц чадамжид баримжаалан тодорхойлсон боловч зарим нь үнэлэгдэхүйц биш байдлаар тодорхойлсон бол 2 оноо
 - В. Зөвхөн мэдлэг, чадваруудыг жагсаасан бол 1 оноо
6. Агуулга нь:
- А. Суралцагчийн хэрэгцээнд тулгуурлаж шинжлэх ухааны болон үйл ажиллагааны аргын тухай мэдлэг, хийж бүтээх чадварыг багтаан тодорхойлсон бол 3 оноо,
 - Б. Суралцагчдад эзэмшүүлэх мэдлэг, чадвар (судлагдахуун ба ур ухааны тогтолцоо)-ыг тодорхойлсон бол 2 оноо

- В. Тухайн шинжлэх ухааны судлагдахуунд суурилж сонгосон бол 1 оноо
7. Арга зүй нь:
- А. Суралцагчийн хөгжлийн түвшинд нийцүүлэн мэдлэг бүтээх, бүтээлгэх аргуудыг хэрэгжихүйц байдлаар боловсруулсан бол 3 оноо
 - Б. Сургалтын идэвхтэй аргуудыг сонгосон боловч хэрэгжих боломж нь тодорхойгүй бол 2 оноо
 - В. Зөвхөн мэдлэг, мэдээлэл дамжуулах арга (уламжлалт)-ыг сонгосон бол 1 оноо
8. Хэрэглэгдэхүүнийг сонгосон, боловсруулсан байдал:
- А. Хөтөлбөрийн зорилго, агуулгад нийцүүлэн суралцагчийн нас сэтгэхүйн онцлогт тохируулан хэрэглэгдэхүүнээ сонгож, ашиглах аргаа боловсруулсан бол 3 оноо,
 - Б. Хэрэглэгдэхүүнээ сонгосон боловч ашиглах аргаа боловсруулаагүй бол 2 оноо,
 - В. Хэрэглэгдэхүүнээ зөвхөн сурах бичиг, самбар шохойгоор хязгаарласан бол 1 оноо
9. Үнэлгээг боловсруулсан байдал нь:
- А. Үнэлгээ нь хөтөлбөрийн зорилго, зорилттойгоо нийцсэн, танин мэдэхүйн түвшний шалгуурт тохирсон, хэмжээсжүүлсэн үнэлгээний даалгавар боловсруулсан бол 3 оноо,
 - Б. Зөвхөн үнэлгээний даалгавар, шалгуурыг боловсруулсан бол 2 оноо,
 - В. Даалгавар боловсруулаагүй зөвхөн үнэлгээний арга, хэлбэрийг бичсэн бол 1 оноо

ХАВСРАЛТ 1.

Сургалтад ашигласан PPP илтгэлүүдээс

Хавсралт 1.1.

Сэдэв 2.2. Арга зүйн шинэчлэл ба” Хүн-Орчин” хичээлийн онцлог

Хүн-Орчин хичээлийн судалгаа ба арга зүйн шинэчлэлийн холбоо

- Богд хаант Монгол улс байгуулагдсан 1911 оноос бага сургуульд “Монгол ба бусад олон газрын байдла”, “Аж төрөхийг сайжруулах ёс” зэрэг хичээлүүдийг заах болсоноор бага ангийн байгалийн ухааны хичээлийн эхлэл тавигдсан ба Байгалийн ухааны хичээлийг дараах байдлаар нэрлэж иржээ. Үүнд:
 - 1921-1935 онд 1-3р ангид “Түмэн бодис”
 - 1932-1971 онд 1-4р ангид “Байгалийн шинжлэл”
 - 1972-1991 онд 1-4р ангид “Түмэн бодис”
 - 1992 онд “Байгаль, шинжлэл”
 - 2004 онд “Хүн байгаль”
 - 2005 онд “Хүрээлэн буй орчин”
 - 2007 оноос “Хүн-Орчин”

2008-2010 онд 1-3-р ангийн “Хүн-Орчин” хичээлийн сургалтын үндэсний хөтөлбөр, зөвлөмж, “Хүн-Орчин” 1-3-р ангийн сурах бичиг хэвлэгдэн гарчээ.

- “Хүн-Орчин” хичээлийн агуулга нь цаашид судлах Байгалийн ухаан, Нийгмийн ухаан, Эрүүл мэнд хичээлийн үндсэн суурь болно.

Хүснэгт 1. “Хүн-Орчин” хичээлийн агуулгын тогтолцоо

Эрх амынх үүсгэс	Хүрээлэн буй байгаль	Нийгэм, соёл
• Биеийн эрүүлжилт (он хооллолт, хувийн эрүүл ахуй, ариун тусгай, амьсгалын эрүүл мэнд) • Амьсгал, амьсгал (оргуу, орчин, бие, эрүүл, хамгаалах, өсөл, гэмтлэгс, сэрвэлх, эрүүл аж төрөх)	• Амьсгал ба амьсгал (амьсгал ба амьсгалын шинж чанар, амьсгалын орчин) • Монгол орны Байгаль, цаг агаарын үзэгдэл, улирын өөрчлөлт, байгалийн гамшигт үзэгдэл • Байгаль хамгаалах	• Нийгэм, соёлын орчин (би, гэр бүл, ахуй, хамт олоо, төрөл, садан, найз нөхөд, сургууль гэх мэт) • Эрх үүрэг, дүрэм, журам, ёс зүй (сурагчийн эрх үүрэг, сургууль, соёлын орчин дахь хүүхдийн эрх гэх мэт)

- “Хүн-Орчин” хичээл нь байгаль, нийгэм, эрүүл аж төрөх ёсны хамгийн түгээмэл ойлголтуудыг судалдаг учраас багшаас дараах мэдлэг чадварыг эзэмшсэн байхыг зүй ёсоор шаарддаг. Үүнд:
 - Газарзүй, түүх нийгэм судлал, хууль эрх зүй, байгалийн шинжлэл, эрүүл мэндийн боловсролын зохих мэдлэг, чадвартай байх
 - Суралцагчдын нас сэтгэхүйн онцлог, хэрэгцээнд тохируулан сургалтын агуулга, арга зүйг оновчтой сонгон сургалтыг төлөвлөх чадвартай байх
 - Суралцагчдын суралцахуйг дэмжсэн арга зүйгээр сургалт зохион байгуулах дадлага, туршлагатай байх
 - Хичээлийн тодорхой арга зүйг хамтран турших, харилцан суралцах, арга зүйгээ сайжруулах хүсэл эрмэлзэлтэй байх шаардлагатай.

“Хүн-Орчин” мэргэжлийн багийн зүгээс дараах асуудалд анхааран ажиллаж байна. Үүнд:

Хичээлийн судалгаагаар дамжуулан багш нар хамтран арга зүйгээ сайжруулах. Үүний тулд:

- Суралцагчийн хөгжилд хувь нэмэр оруулах хичээлийг хэрхэн төлөвлөн заах,
- Хичээлийг хэрхэн ажиглах, дүн шинжилгээ хийх,
- Хичээлийг сайжруулах арга замуудыг хэлэлцэх,
- Хичээлийн хэрэглэгдэхүүн, хөтөлбөрийг засан сайжруулах
- Хичээлийг сайжруулан дахин заах замаар заах арга барил, ур чадвараа дээшлүүлэх.

“Хүн-Орчин” хичээлд судалгааны үндэстэй хандах нь

- Японд хичээлийн судалгаанд оролцохоор улс орны өнцөг булан бүрээс хэдэн зуун багш цугладаг. Тэд судалгаат хичээлд оролцсоноор сурагчдын хийж буй ажил, урам зориг, сэтгэл хөдлөл, жижиг бүлгийн ярилцлага, уулга алдалт, бүлгээр хамтран ажиллах чадвар зэрэг амьд процессыг олж харж чаддаг. Тиймээс багшийн арга зүйг сайжруулах хамгийн оновчтой арга хэрэгсэл хичээлийн судалгаа болдог.

Японы багш нар дараах чиглэлээр голчлон хичээлийн судалгаа хийдэг. Үүнд:

- Суралцагчдын хувьд хэцүү зүйлийг
- Заахад хүнд сэдвүүдийг
- Агуулга, арга зүй нь шинэчлэгдсэн хичээлийг
- Бусад хичээлийн үндэс болдог чухал ач холбогдолтой хичээлүүдийг.

Харин АНУ-д голдуу математик заримдаа байгалийн ухаан, хэл, зургийн хичээлүүд дээр хичээлийн судалгаа хийдэг.

- Хичээлийн судалгаа нь багш нар нэг удаа хамтран хичээл заах биш, заасан хичээлээ сайжруулан дахин дахин заадаг цикл үйл явц бөгөөд дараах үе шатуудаас тогтоно.

```

graph TD
    A[Хичээл заах, ажиглах, баримт нотолгоо цуглуулах] --> B[Судлах хичээлээ сонгож төлөвлөх]
    B --> C[Хичээлээ хэрхэн сайжруулахыг хэлэлцэх]
    C --> D[Хичээлийн судалгааны зорилгыг тодорхойлох]
    D --> A
    
```

Хичээлийг ийнхүү циклээр судлах нь багш нарт дараах боломжуудыг олгодог. Үүнд:

- Тухайн хичээл, бүлэг сэдэв, ээлжит хичээлийн агуулгын хүрээний зорилго, зорилтыг маш нухацтай тунгаан бодоход хүрнэ.
- Сурагчдын хөгжлийн одоогийн түвшин ба цаашид хүрсэн байх түвшингийн хоорондох зөрүү (наашдын хөгжил, төлөвлөлийн зорилго)-ний талаар бодох шаардлагатай болно.
- Хамгийн сайн гэсэн хичээлээ судалж, улам сайжруулдаг.

- Ямар ойлголт, мэдлэг чухал болох, хэрхэн түүнийг хөгжүүлэх, сурагчдын ойлголт ба мэдлэгийн хооронд ямар зөрүү байна вэ? гэх мэт асуудалд анхаарлаа төвлөрүүлснээр хичээлийн талаарх мэдлэг нь гүнзгийрэх болно.
- Хичээлийг хамтран төлөвлөдөг болно.
- Сурагчдын санаа бодлыг таамагладаг болно.
- Суралцагчдын суралцахуй болон зан байдлыг маш хянуур судалдаг болно.
- Суралцагчдыг асуултаар хөгжүүлэх, сонирхлыг нь татах, суралцахуйг амжилттай удирдах зэрэг маш чухал арга барилуудыг өөртөө бий болгоно.

Анхаарал хандуулсанд баярлалаа

Хавсралт 1.2. Цумазуки ба алдааны шинжилгээ

Хүүхдийн бүдрэлт-цумазуки

- Сурагчид ихэвчлэн алим амьгүй гэж боддог.

Яагаад сурагчид ойлгохгүй байна вэ?

Сурагчид ойлгохгүй байгаа зүйлийг зориулж болон нэвэй хэвнэг хийнэ.

Кёзай кенкю-г хийхийн тулд:

- "Ямар зүйл хэрэглэнэ?" хэмээн бодно.
- Үүнд:
 - Түршил
 - Хүнийн нэвэйг ариуца
 - Повар хойгчигчигч

Алим амьд үү?



- Энэ удаагийн кёзай кенкю-н зорилго нь: Алим амьд болохыг бэлтгэ
- Бид повар хойгчигчигчгаар сонгодог

Алим амьд үү?



Алимд амьд биеийн ямар шинж байна вэ?



Хэрэглэнэ зориулж бодуулж хэрэглэнэ мэдэхийн зүйлийг нэвэй болон ариуца. Жишээ: Хойр хууцныг аль нэ амьд вэ?



Алим амьд үү?



Алимд амьд биеийн ямар шинж байна вэ?



Энэ юу вэ?






















Алимны бялуу болон алимны шүүс амьд үү?





Хавсралт 1.4.

Хөтөлбөр боловсруулах арга зүй



ХАВСРАЛТ 2.

Нэгж ба ээлжит хичээлийн хөтөлбөрийн загвар

1. Нэгж хичээлийн хөтөлбөр боловсруулах

Сэдэв: Ургамал

Нэгж хичээлийн зорилго: Сурагчдад, ургамал амьд бие болох талаар ерөнхий ойлголт өгнө.

Суралцахуйн зорилт:

- Амьд ба амьгүй биеийг ялган таних, амьд биеийн онцлогийг тайлбарлах
- Ургамлын эрхтнүүдийг нэрлэх, ургамал амьд болохыг навчны өсөлтөөр батлах
- Ургамал ургахад шаардагдах нөхцөлүүдийг үр ургуулж, турших замаар танин мэдэх
- Тасалгааны ургамлын ашиг тус, түүнийг арчлах аргыг мэдэх
- Хүнсний ногоо, жимс зэрэг хүнсэнд хэрэглэдэг ургамлын ашиг тусыг мэдэх

Нэгж хичээлийн агуулга

№	Ээлжит хичээл	Судлах цаг	Судлах зүйл	Эзэмших чадвар
1	Амьд ба амьгүй бие	35 мин	• Амьд ба амьгүй биеийн ялгаа	• Амьд ба амьгүй биеийг ялгах, харьцуулах
2	Ургамал амьд бие болох нь	35 мин	• Ургамал өсдөг учраас амьд бие юм. • Ургамлын эрхтэн: үндэс, иш, навч, цэцэг, үр, жимс	• Ургамал амьд болохыг навчны өсөлтөөр батлах • Ургамлын эрхтнүүдийг нэрлэх, таних
3	Ургамлын эрхтэн	35 мин	• Үндэс • Иш • Навч • Цэцэг • Жимс • Үр	• Ургамлын эрхтэнг нэрлэх • Ялган таних • Ажиглах • Харьцуулах • Бүлэглэх
4	Ургамал ургахад юу хэрэгтэй вэ?	35 мин	• Гэрэл • Дулаан • Ус • Хөрс	• Таамаглал дэвшүүлэх, • Үр ургахад шаардлагатай нөхцөлүүдийг хамтран турших • Ус дутагдсанаас, даарснаас ургамал хатсан, үхс эн гэдгийг батлах • Хөрсгүйгээр ургаж болох эсэхийг ярилцах, батлах
5	Тасалгааны ургамлыг арчлах	35 мин	• Услах • Цэвэрлэх • Зөв байрлуулах	• Услах хэмжээг мэдэх • Цэвэрлэх, арчилж ургуулах аргад суралцах • Улирлын онцлогоос хамааран цэцгээ зөв байрлуулах
6	Ургамлын ашиг тус	35 мин	• Хүнсний ногоо • Жимс жимсгэнэ	• Хүнсний ногоо, жимс жимсгэнийг таних, ялгах, нэрлэх • Ашиг тусыг тайлбарлах, ярих • Зөв хэрэглэх (угаах, цэвэрлэх) чадвартай болох

Ээлжит хичээлийн хөтөлбөр

Сэдэв: Ургамал амьд бие болох нь

Зорилго:

Ургамал бол амьд бие гэсэн ойлголт өгч, туршилт хийх арга зүйд суралцана.

Зорилт:

- Амьд биеийг үндсэн шинжээр нь амьгүй биеэс ялгаж чаддаг болох
- Ургамал амьд бие болохыг мэдэх
- Орчныхоо амьд, амьгүй биеийг ажиглан ялгаж, өөрсдийн дүгнэлт гаргаж, бусдад тайлбарлаж чаддаг болох

Агуулга:

- Ургамал бол амьд бие
- Амьд биеийн адил ургамал нь өсөж, хөгжиж, амьсгалж, хооллон хөдөлдөг болох нь

Арга зүй:


Ажиглалтын арга, харьцуулан жиших арга, харилцан ярилцах арга, тайлбарлан ярих, санал бодлоо солилцох, багаар ажиллах арга

Хэрэглэгдэхүүн:

- Слайд 5 –ын зургийг (Хавсралт 2.1.) А4-ийн хэмжээтэй хэвлүүлнэ.
- Тасалгааны ургамал, савх, алим юмуу урт ургамал – багийн тоогоор
- Хуваарьтай хэмжих цаас, хавчаар, гялгар уут – багийн тоогоор
- Өнгийн цаас /цэнхэр, улаан/
- Бичгийн үдээс
- Өнгийн харандаа
- Ажиглалтын тэмдэглэл хөтлөх хуудас

Хичээлийн явц:

Хичээлийн элементүүд	Багшийн үйл ажиллагаа	Сурагчийн үйл ажиллагаа
Сэргээн сануулах үе	ҮА-1. Слайд 5-ын зургаас баг тус бүрт 2 ширхгийг өгч ажиглуулан, амьд ба амьгүй биеийг ялгуулж самбарын 2 талд байрлуулна. ҮА-2. Слайд 6-г харуулж аль нь амьд, аль нь амьгүй болохыг асууж ярилцана. Гараа өргөсөн идэвхтэй сурагчаар яриулна. Яагаад амьд, эсвэл амьгүй бие болохыг тайлбарлах даалгавар өгнө.	Амьд амьгүй биеийг ялгаж, ялгагдах онцлог шинжийг харилцан ярилцаж тайлбарлана. Жишээ нь: Ургамал өсөж томордог, ургадаг, амьтад хооллодог, хөдөлдөг, хүн ярьдаг гм.
Мэдлэг бүтээх үе	ҮА-3. Навчны өсөлтийг хэмжих туршилт хийлгэнэ. Ургамал амьд уу? Амьгүй юу? Ургамал өсөх үү? Ургамал амьд гэдгийг батлахын тулд бид одоо дараах туршилтыг хийж үзнэ. Навчны өсөлтийг хэдэн өдөр дараалан хэмжих ба хэрхэн хэмжихийг слайдаар үзүүлж тайлбарлана /Слайд 8-10/.	Ургамал амьд, амьгүй гэх мэтээр янз бүр хариулж болно. Асуулт нээлттэй учраас Зааврын дагуу туршилтыг хийж гүйцэтгэнэ.

	ҮА-4 Үр соёолуулах туршилт Туршилтын үр дүнг хоёр долоо хоногийн туршид 3 хоногийн зайтай ажиглаж, тэмдэглэл хөтөлнө /Слайд 12-15/.	 
Бататгах үе	Багуудад, ургамал яагаад амьд бие болохыг дээрх туршилтын үр дүнд ажиглан, тайлбарлах даалгавар өгнө. Багш багуудын хийсэн тайлбарыг амьд биеийн шинж дээр төвлөрүүлж дараах байдлаар нэгтгэнэ. Ургамал хооллоно, өсөж хөгжинө, үржинэ, хөдөлнө, амьсгална.	Багийн гишүүд хоорондоо санал бодлоо солилцон, дараах ойлголтод хүрнэ. Ургамал өсөж томордог. Ургамлаас дахин ургамал бий болдог. Ургамал үндсээрээ усыг авч хэрэглэдэг. Энэ нь хооллож байгаа хэлбэр. Ургамал агаараар амьсгалдаг гэх мэтээр хариулна.
Үнэлгээ, дүгнэлт	Хичээлийн үнэлгээний хуудсыг тарааж өгнө.	Хичээлийн үнэлгээний хуудсыг бөглөнө.
Гэрийн даалгавар	Та нар гэрт байгаа тасалгааны ургамлаа усалдаг уу? Яагаад усалдаг болохын учрыг ойлгож ирээрэй.	

2. Ээлжит хичээлийн арга зүйг төлөвлөх

Арга зүйн төлөвлөлтийг хийх олон төрлийн загвар бий. Бид тэдгээрээс сургалтыг үр дүнтэй төлөвлөж болох хувилбарыг сонгон авах нь зүйтэй. Та бүхэнд дараах хэдэн хувилбар загварыг танилцуулж байна.

2.1. Ээлжит хичээлийн төлөвлөлтийн загвар (Хувилбар 1)

“Монгол-Кембриджийн боловсролын санаачлага” төслийн загвар


ХИЧЭЭЛ:		Сургууль:	
Өдөр:		Багшийн нэр:	
АНГИ:		Ирсэн:	ирээгүй:
Тухайн хичээлийг үзсэнээр ямар үр дүнд хүрэх вэ?		<i>Мэдээллийг улирлын төлөвлөгөөнөөс буюу сэдвийн ерөнхий төлөвлөгөөнөөс авч бичнэ.</i>	
Хичээлийн зорилго		<i>Зорилго нь дээр бичсэн зүйлтэй адил төсөөтэй юмуу ядаж түүний заримыг нь баримталсан байж болно.</i> <i>Зорилго нь 40 минутийн хугацаанд хийж болох, бодитой, тодорхой байх ёстой.</i>	

Ямар үг хэллэг хэрэглэх		Ямар шинэ үг заах, ямар үг хэллэг хэрэглэхээ тодорхойлно. Мэргэжлийн үг хэллэг, нэр томъёо: Харилцан ярихад болон бичиж найруулахад шаадлагатай үг хэллэгүүд:	
Сурагчдын өмнөх мэдлэг		Сурагчид энэ талаар юу хийж чаддаг болсон. Энэ сэдвийг ойлгохын тулд юу мэдэж байх шаардлагатай. Сурагчдын өмнөх мэдлэгийг хэрхэн илрүүлэх	
Төлөвлөгөө			
Төлөвлөсөн хугацаа	Төлөвлөсөн ажлууд		Ашиглах материал
Хичээлийн эхлэл хэсэг	Хичээлийн эхэнд багш дараах зүйлсийг хийнэ: Сурагчдын анхаарлыг татах Хичээлийн сэдэлжүүлэлтийг хийх\контекст\ Зорилгоо хэлэх		
Хичээлийн дунд үе	Хичээлийн дунд үед сурагчид дараах ажлуудыг хийнэ: Хичээлийн зорилгод чиглэсэн мэдлэг, чадварыг хөгжүүлэх Техник, ур чадвар эзэмших Эзэмисэн мэдлэг, чадвараа хэрэглэх Хууль зүй, тогтлыг турших Асуудлыг шийдвэрлэх		
Хичээлийн төгсгөлд	Хичээлийн төгсгөлд сурагчид дараах зүйлсийг хийж болно: Сурсан зүйлээ сэргээн санах Дараагийн хичээлийн зорилгыг тодорхойлох Өөрийгөө болон харилцан бие биенээ үнэлэх		
Нэмэлт мэдээлэл			
Ялгаатай байдал–Илүү сайн дэмжлэг үзүүлэхийн тулд юу төлөвлөсөн бэ? Илүү чадварлаг сурагчдад зориулан юу төлөвлөсөн бэ?		Үнэлгээ, шалгалт – Суралцагчдын суралцахуйг шалгахын тулд юу төлөвлөсөн бэ?	Эрүүл, аюулгүй байдал МХТ холбоос
Ялгаатай байдал- өгсөн даалгавар, гаргасан үр дүн, тэдэнд үзүүлэх дэмжлэг, гүйцэтгэх хугацаа, хичээлд ашиглах хэрэглэгдэхүүн зэргээр ялгаатай хандана. Хичээлийн аль ч үед ялгаатай хандаж болно.		Хичээлийн явцад суралцагчдын сурч мэдсэн зүйлсийг ямар аргаар үнэлэхээ энэ хэсэгт бичнэ.	Хийж буй ажлууд нь суралцагчдын эрүүл мэнд, аюулгүй байдалд нөлөөлөх үү? Хичээлийн явцад суралцагчдын МХТ-н чадвар дээшлүүлэх үү?
Эрэгцүүлэл болон үнэлгээ			
Эргэцүүлэл Хичээлийн зорилго бодитой байсан уу? Суралцагчид өнөөдөр юу сурсан бэ? Хичээлийн уур амьсгал ямар байсан бэ? Миний төлөвлөлт хэр оновчтой байсан бэ? Би цагаа барьж чадсан уу? Би төлөвлөлтдөө ямар өөрчлөлт оруулах вэ? Яагаад?		Хүснэгтийн зүүн талд бичсэн асуултуудаас шаардлагатай гэсэн асуултдаа хариулж бичээрэй.	
Нэгдсэн дүгнэлт Таны хамгийн сайн болсон хоёр зүйл юу вэ? (багшлах болон суралцахуйн аль алинтай нь холбоотой) 1: 2: Таны сайжруулах шаардлагатай гэж үзсэн хоёр зүйл юу вэ? (багшлах болон суралцахуйн аль алинтай нь холбоотой) 1: 2: Энэ хичээлээс сурсан хувь хүн болон хичээлтэй холбоотой ямар арга зүйг дараагийн хичээлдээ			

ашиглах вэ?

Ээлжит хичээлийн төлөвлөлт. Хувилбар 1-ийн жишээ:

ХИЧЭЭЛ: “Хүн-Орчин”, Голын ус яагаад бохирдов?		Сургууль:	
Огноо: 2012-6-4		Багшийн нэр: Ц. Пагмасүрэн	
АНГИ: 2-р анги		Ирсэн сурагчдын тоо:	Ирээгүй:
Хичээлийн зорилго:	Голын бохирдол, түүний шалтгааныг өөрсдийн хэмжээнд тодорхойлох		
Суралцахуйн үйл ажиллагааны зорилт	Гол бохирдсон шалтгааныг эргэцүүлэн бодох, санаа бодлоо илэрхийлэх, бусдын санаа бодлыг сонсох		
Түлхүүр үг	Гол бохирдох шалтгаан		
Эзэмшсэн мэдлэг, чадвар	• <i>Сурагчдын өмнө эзэмшсэн мэдлэг чадвар:</i> Ундны ус ба цэвэр усны талаар ойлголттой болсон • <i>Шинээр эзэмших мэдлэг, чадвар:</i> Гол бохирдох шалтгааныг тунгаан бодох санаа бодлоо чөлөөтэй илэрхийлэх • <i>Дараачийн хичээлээр үргэлжлүүлэн эзэмших мэдлэг, чадвар:</i> Усыг бохирдуулахгүйн тулд өөрсдийн оруулах хувь нэмрийг тодорхойлох		
Төлөвлөгөө			
Төлөвлөсөн цаг	Төлөвлөсөн үйл ажиллагаа		Ашиглах материалууд
Сэдэлжүүлэх 7 минут	Мэндэлж хичээлийн зохион байгуулалтыг /багаар ажиллах/ хийнэ . Үйл ажиллагаа1: Сэдэлжүүлэлт <i>Багш :</i> Голын зураг слайд харуулан, Та нар гол дээр очиж үзсэн үү? Энэ голд юу байгаа бол? гэж асууна. Сурагчдын нэрлэсэн үгнүүдийг самбарт бичнэ. <i>Сурагчид:</i> Голд байдаг зүйлсийг нэрлэнэ. Жишээ нь: элс, чулуу, замаг, загас, ургамал, амьтан, шавж, мэлхий гэх мэт. <i>Багш:</i> Сэлбэ голын слайдыг харуулна. Та нар энэ голын нэрийг мэдэх үү? гэж асууна. Энэ гол ямар харагдаж байна гэж асууна. <i>Сурагчид:</i> Голын нэрийг Туул, Сэлбэ гэх мэтээр таамаглан нэрлэнэ. Энэ гол бохир харагдаж байна гэж хариулна. <i>Багш:</i> Голын нэрийг нь хэлж өгөөд энэ голоос авчирсан усны дээжийг харуулна. “Бүгдээрээ өнөөдөр энэ голын ус хэр зэрэг бохирдсон, яагаад ийм бохир болсон талаар судална” гэж хичээлийн зорилгыг танилцуулна.		Слайд1-3 Усны дээж
Мэдлэг бүтээх 15 минут	Үйл ажиллагаа2: Туршилт, ажиглалт <i>Багш:</i> Голоос авчирсан дээжийг үзүүлээд “Энэ усыг ууж болох уу? Яагаад?” гэж асууна. <i>Сурагчид :</i> Болохгүй, учир нь бохир гэж хариулна. <i>Багш:</i> За бүгдээрээ нэг туршилт хийж үзье. <i>Багш:</i> Цэнхэр наалттай аяганд ундны цэвэр ус бага зэрэг , шар наалттай аяганд голын уснаас бага зэрэг хийж өгье. Та нар эдгээрийг цагаан цаасан дээр тавьж ажиглаарай. <i>Сурагчид:</i> Цэнхэр цаастай аяган дахь ус тунгалаг учраас маш цэвэр байна. Харин шар цаастай аяган дахь ус булинггартай учраас бохир гэж хариулна. <i>Багш:</i> Бохир усыг цэвэрлэж болох үү?.		Туршилтын хэрэглэгдэхүүн багийн тоогоор: Нэг удаагийн тунгалаг хуванцар аяга 2ш, юүлүүр, шүүлтүүрийн цаас тус бүр 1ш, бичгийн цагаан цаас-1ш

	Сурагчид: Бохир усыг цэвэрлэж болно, болохгүй, зарим нь шүүнэ гэж хариулж болох юм. Багш: Одоо бүгдээрээр голын усыг шүүлтүүрээр шүүж үзье. Савтай усныхаа хагасыг шүүгээрэй. Шүүсэн усаа шүүгээгүй устай харьцуулан ажиглаарай. Сурагчид: Шүүх үйл ажиллагааг нямбай хийж, шүүсэн ба шүүгээгүй усыг цагаан цаасан дээр тавьж, харьцуулан ажиглана. “Голын усыг шүүсний дараа цэвэрхэн болсон байна” гэж хариулна. Багш: Шүүж дууссаны дараа шүүлтүүрийн цаасан дээр юу үлдсэнийг асууна. Сурагчид: Бохир байна, хиртэй байна гэх мэтээр хариулна. Багш: Голын ус шүүсний дараа цэвэр болж чадсан уу? Шүүсэн усыг одоо ууж болох уу? хэмээн асууна Сурагчид: Ууж болохгүй учир нь буцалгаагүй, бохир гэх мэтээр хариулна. Үйл ажиллагаа3: Сурах бичгийн зураг дээр ажиллан голын ус бохирдсон шалтгааныг тодруулах Багш: Сурах бичгийн зургийн хуулбар, өнгийн наадаг цаас баг бүрт тараан өгнө. Ажлын зааврыг тайлбарлана. Үүнд: 1. Хосоор хамтран, сурах бичгийн зураг дээрээс голын усыг бохирдуулж байгаа хэсэгт өнгийн цаас наана. 2. Багаараа ярилцан өгөгдсөн хуулбар дээр өнгийн цаас наана. Үйлдвэр, мал, хүн, машин 3. Багаас нэг сурагч самбарт гарч яагаад энэ хэсэгт өнгийн цаас нааснаа тайлбарлана. Багш: Энэ голын ус юунаас болж бохирдсон бэ? Сурагчид: Үйлдвэр- бохир ус, мал- баас, шээс, хүн-хог хаях, юмаа угаах, машин угаах- бензин, угаалгын нунтаг гэх мэтээр бохирдуулж байгаа бодисуудыг нэрлүүлэхэд анхаарах Багш: Хүүхдийн хариултаас самбарт голыг бохирдуулж буй шалтгааныг бичнэ. Ингээд дараах асуултуудыг асууж ярилцана. Санамж: Сурагчдыг жигд оролцуулах үүднээс сурагчдыг дугаарлах, нэрийг нь бичсэн сугалаа сугалах зэрэг идэвхжүүлэх аргуудыг хэрэглэх хэрэгтэй. • Голын усыг бохирдуулж байгаа эдгээр зүйл голд байх ёстой юу? • Хүн ийм уснаас уувал яах вэ? • Ийм зүйлс их байвал голын амьтан, ургамал амьдарч чадах уу? • Голын усны бохирдол гэж юуг хэлэх вэ? Голд байх ёсгүй зүйлс их орсноос гол бохирдоно гэсэн дүгнэлтэд хүрнэ.	   Сурах бичгээс хуулбарласан зураг, өнгийн наалт-багийн тоогоор Самбар, шохой
Баталгал: 10 минут	Үйл ажиллагаа4: Голын ус бохирдсон өөр шалтгааныг тайлбарлах Багш: Голын усыг бохирдуулж буй өөр шалтгааныг та нар мэдэх үү? Сурагчид: Голд юмаа угаах гэх мэтээр хариулна. Багш: Голд хивс, машин, хувцасаа угааж байгаа зураг харуулж, “Та нар яагаад голыг бохирдоно гэж үзэж байна вэ?” гэж асууна. Сурагчид: Голд савантай, хиртэй ус орсон учраас бид уснаас ууж болохгүй, амьтан ургамал голд амьдрах боломжгүй болно гэх мэтээр өөрийн санаа бодлыг чөлөөтэй илэрхийлнэ. Багш: Гар аргаар алт угааж байгаа зураг харуулж, “Энэ юуны зураг вэ?” гэж асууна. Сурагчид: Нинжа нарын зураг гэж хариулна. Багш: Зураг дээр яаж байгаа талаар тодруулан асууна. Сурагчид: Нинжа нар шороог усаар угаан, алтыг нь авч байгаа талаар ярина. Багш: “Алт угааснаар голд юу их болсон байна?” гэж асууна.	Голд хувцас, машин, хивсээ угааж байгаа зураг, алт угааж байгаа зураг

	Сурагчид: “Шороо их болсон байна” гэж хариулна. Багш: “Шороо ихтэй усанд амьтад амьдарч чадах уу?” Сурагчид: Чадахгүй гэж хариулна. Багш: Бидний шүүсэн усанд юу байсан билээ? Сурагчид: Шороо Багш: Сэлбэ голын ус яагаад бохирдсон юм бол? Сурагчид: Хүмүүсийн буруугаас гэж хариулна.													
Гэрийн даалгавар: 3 минут	Голын усыг бохирдуулахгүйн тулд: • Чи юу хийж чадах вэ? • Бусад хүмүүс юу хийж чадах бол? гэдгийг бодоод ирээрэй.													
Нэмэлт мэдээлэл														
Ялгаатай байдал – та яаж илүү дэмжлэг үзүүлэх гэж байна вэ? Илүү чадварлаг сурагчдыг яаж сургах /хүчийг нь сорих/ гэж байна вэ?	Үнэлгээ – та сурагчдын сурах үйл ажиллагааг хэрхэн үнэлэх гэж байна вэ?	Эрүүл мэнд ба аюулгүй байдлын хяналт Бусад тэмдэглэл/сануулга												
• Сурагчдыг аль болох бүрэн хамруулахад анхаарах • Бодох, ярих чадварыг хөгжүүлж байна гэдгээ санах • Гол бохирдуулах өөр ямар шалтгааныг мэдэх вэ? гэсэн нээлттэй асуултаар дамжуулан чадварлаг сурагчдын хүчийг сорих	• Туршилтын үр дүнг ажиглах, харьцуулах, • Багшийн асуултыг бодож, тунгаан хариулт өгч буй байдал • Зургийг ажиглаж, бохирдох учир шалтгааныг өөрийнхөөрөө тайлбарлаж байгаа байдал • Өөрийн амьдралын туршлагаас хуваалцаж буй байдал	• Туршилтын үед хэрэглэсэн усыг асгахгүй, амсаж болохгүйг сануулах • Багаар ажиллуулж сургахад анхаарах • Бүх сурагчдыг хичээлд жигд оролцуулахад анхаарах • Сурагчдын хариултыг анхааралтай сонсож, урамшуулах												
Эргэцүүлэл	Дараах хэсэгт та хичээлийнхээ талаар эргэцүүлэн бичнэ үү. Туршилтын арга оновчтой байсан. Гэхдээ ажиглалтын тэмдэглэл хөтлүүлэхэд анхаарах Багшийн асуух асуултыг оновчтой төлөвлөөгүй, сурагч бүрт хариулах боломж олгох тал <table border="1"> <thead> <tr> <th>Ус</th> <th>Өнгө</th> <th>Ууж болох уу?</th> </tr> </thead> <tbody> <tr> <td>Шүүгээгүй ус</td> <td></td> <td></td> </tr> <tr> <td>Шүүсэн ус</td> <td></td> <td></td> </tr> <tr> <td>Усны бохирдол</td> <td></td> <td></td> </tr> </tbody> </table> дээр дутуу анхаарсан.		Ус	Өнгө	Ууж болох уу?	Шүүгээгүй ус			Шүүсэн ус			Усны бохирдол		
Ус	Өнгө	Ууж болох уу?												
Шүүгээгүй ус														
Шүүсэн ус														
Усны бохирдол														
Дүгнэлт үнэлгээ Хичээлийн ямар хоёр хэсэг хамгийн амжилттай болсон бэ (сургах, сурах үйл ажиллагааг хамтад нь авч үзнэ үү? 1: Туршилт 2: Сурах бичгийн зураг дээр ажиллах Хичээлийн ямар хоёр хэсгийг сайжруулах байсан бэ? (багшлах, суралцах хоёрыг авч үзнэ үү) 1: Багшийн асуулт 2: Хичээлийн төгсгөл хэсэгт сурагчдын идэвх суларсан. Учир нь цөөн тооны сурагчид багшийн асуултад хариулаад байсан Би энэ хичээлээс тухайн ангийн, эсвэл сурагчдын талаар юу сурав, түүнийгээ дараагийн хичээлд хэрхэн хэрэглэх вэ? Сурагчдын хичээлд татан оролцуулах аргуудыг хэрэглэх, туршилтын үр дүнг тэмдэглүүлэх, илүү үр дүнтэй туршилт олж, төлөвлөх														

2.2. Ээлжит хичээлийн төлөвлөлтийн загвар (Хувилбар 2)

Батлав. с/м

Хичээлийн сэдэв:

Хамрах хүрээ:

Зорилго:

Зорилт:



Агуулга:

Мэдлэг



Чадвар



Хэрэглэгдэхүүн:

Арга зүй:

Зохион байгуулалтын хэлбэр:

Хичээл заах арга:

Үйл ажиллагааны төлөвлөлт:

Үе шат	Багшийн үйл ажиллагаа	Сурагчийн үйл ажиллагаа	Хэрэглэгдэхүүн	Багшийн анхаарах зүйл
Сэдэлжүүлэлт				
Мэдлэг бүтээх				
Бататгах				
Даалгавар				

Ээлжит хичээлийн төлөвлөлтийн Хувилбар 2-ын жишээ:

Хичээлийн сэдэв: Голын ус яагаад бохирдов?

Хамрах хүрээ: 2 г анги

Зорилго: Голын ус яагаад бохирдсон талаар сурагчдад ойлгуулах

Зорилт:

- Голын усны бохирдсон шалтгааныг зураг дээр ажиглах, өөрийн үгээр тайлбарлах
- Голын усыг бохирдуулахгүй, зөв харьцаж сурах
- Голын усыг хайрлан хамгаалж, байгалийг хайрлах

Агуулга:

Мэдлэг

- Голын ус бохирдох шалтгаан

Чадвар

- Голын ус бохирдох шалтгааныг тоочих, өөрийн үгээр тайлбарлах
- Гол, горхи, булаг шандыг хайрлан хамгаалах
- Бохир ус уухгүй, эрүүл мэндээ хамгаалах
- Туршилт хийх, ажиглах, тэмдэглэх, харьцуулалт хийх

Хэрэглэгдэхүүн:

Сурах бичиг, зураг, цэвэр ус ба голын бохир ус, шилэн аяга, юүлүүр, шүүлтүүрийн цаас, дэлгэц, проектор, компьютер

Арга зүй:

Зохион байгуулалтын хэлбэр:

- Багаар

Хичээл заах арга:

- Туршилтын арга, ажиглах, харьцуулах, тайлбарлан ярих арга, харилцан ярилцах, бичиж тэмдэглэх арга

Үйл ажиллагааны төлөвлөлт

Үе шат	Багшийн үйл ажиллагаа	Сурагчийн үйл ажиллагаа	Хэрэглэгдэхүүн	Багшийн анхаарах зүйл
Сэдэлжүүлэлт 10 мин	Үйл ажиллагаа 1. Багш, Зураг 1-2 дээр ярилцан 2 савтай усны аль нь Сэлбэ голоос авсан болохыг асууна. - 2 усыг харуулж тайлбарлана /Сэлбэ голоос авсан ус, дэлгүүрээс авсан цэвэр ус/ - Дараах асуултыг асууж ярилцана - Энэ 2 усны алийг нь ууж болох вэ? - Цэвэр усыг яагаад ууж болж байна? - Голын усыг яагаад ууж болохгүй байна вэ?	Анхааралтай харж, харилцан ярилцаж, санал бодлоо хэлэлцэнэ. - Сэлбэ голын ус бохир байна - Хогтой байна - Бохир усыг Сэлбэ голоос авсан байх гэх мэтээр хариулна. Хариулт: - Бохир усыг ууж болохгүй, цэвэр усыг ууж болно. - Цэвэр ус нь газрын гүнээс аваад цэвэршүүлэн шүүсэн ус байдаг тул ууж болдог, харин голоос авсан ус нь бохир, шүүгээгүй, буцалгаагүй ус байдаг тул ууж болохгүй. - Бохир ус уувал гэдэс өвдөнө, өвчин тусна гэх мэтээр сурагчид өөрсдийн үзэл бодлыг чөлөөтэй илэрхийлнэ.	- Зураг 1, 2 дугаар /слайдаар бэлдсэн байж болно/ - Сэлбэ голын болон цэвэр усны дээж Сэлбэ гол  Зураг 1.  Зураг 2.	
	Үйл ажиллагаа 2. Тэгвэл одоо хэдүүлээ жижигхэн туршилт хийж үзнэ гэж хэлэн урьдчилан бэлтгэсэн туршилтыг зааврын дагуу хийлгэнэ. - Голын усны дээжийг 2 тэнцүү хэсэг хуваана. - Нэг хэсгийг нь үлдээж нөгөөг шүүнэ - Шүүсэн болон шүүгээгүй усыг харьцуулж ажиглана. Дараах асуултыг асууна. - Ямар ялгаа байна вэ? - Голын ус бохир гэдэг нь үнэн байна уу? - Шүүсэн усыг ууж болох уу? Яагаад? - Голын ус яагаад бохирдов?	Сурагчид багшийг дагаж туршилтыг гүйцэтгэнэ. Хүүхдүүд ажиглалт, харьцуулалт хийнэ. Багшийн асуултад хариулна. Хариулт: Шүүгдсэн ус нь цэвэр устай адилхан тунгалаг боллоо. Шүүгдэст шороо, хог, навч гэх мэт байна. Голын ус бохир гэдэг нь үнэн байна гэж хэлнэ. Шүүсэн усыг ууж болно, болохгүй. Яагаад гэвэл, бохир байна, буцалгаагүй болохоор, өвчин тусна гэх мэт.	- Цэвэр ба бохир ус – тус бүр 50 мл - Цэвэр шилэн аяга - Юүлүүр - Шүүлтүүрийн цаас	Туршилтыг хийх явцад сурагчид зөв хийж байгаа эсэхэд анхаарч, буруу хийж байгаа бол туслах хэрэгтэй. Шилэн савтай ажиллаж байгаа бол аюулгүй байдлыг хангахад анхаарах хэрэгтэй. Шилэн аягаа унагаж хагалан гар хөлөө гэмтээхгүй байх тал дээр анхаарч болгоомжтой ажиллахыг сануулаарай.

	Зүйтэй. Тэгвэл өнөөдрийн хичээлээр бид голын ус яагаад бохирддог талаар үзэх гэж байна гэж хэлэн хичээлийн сэдвийг самбарт бичнэ. • Өнөөдрийн хичээлийн сэдэв: Голын ус яагаад бохирдов?	Дэвтэрт хичээлийн гарчиг бичнэ.		
Мэдлэг бүтээх үе	Үйл ажиллагаа 3. Багш сурах бичгийн 57-р хуудасны зургийг сайтар ажиглах даалгавар өгнө Дараах асуултыг асууна: - Голын ус яагаад бохирдсон бэ? - Яагаад үүнийг гол бохирдуулах шалтгаан гэж үзсэн бэ? гэж асууна.	- Хүүхэд бүр өөрийн сурах бичгийн зургийг ажиглан өнгийн цаасаар тэмдэглэгээ хийнэ. - Багаараа хамтарч ярилцан, саналаа нэгтгээд нэг сурагч гарч тайлбарлана. Яагаад ус бохирдуулах шалтгаан гэж үзсэнээ өөрсдийн үгээр тайлбарлана.	- Сурах бичиг - Сурах бичгийн зургийн хуулбар	Сурах бичиг хангалтгүй бол багш зургийг өнгөтөөр хувилж олшруулан баг бүрт тарааж өгч болно. Багийн ажлыг тайлбарлахад багш ангийнхаа сул сурагчийг сонгож яриулахыг хичээгээрэй.
	Багууд ажлаа тайлбарлаж дууссаны дараа багш анги дунд дараах асуултыг асууна. - Бидний сая ярилцсан зүйлээс өөр голыг бохирдуулах ямар шалтгаанууд байж болох вэ? Хэн хэлэх вэ? гээд гар өргүүлэн нэг нэгээр нь хариулуулна. Сурагчдыг хариулж байх үед багш оновчтой санааг самбарт бичнэ.	Сурагчид нэг нэгээрээ гар өргөн босож хариулна. - Машин болон юм угаах - Үйлдвэрийн хог хаягдал - Алт угаах г.м.		Багш аль болох олон шалтгаан хэлүүлэхийг хичээнэ. Мөн хичээлд идэвхгүй оролцож байгаа хүүхэд байвал багш нэр цохон асууж болно.
Багтах үе мин	Үйл ажиллагаа 4. - Багш, голын усыг бохирдуулж байгаа зургийг үзүүлж, ийм дүр зургийг хаана харсан талаар асууж ярилцана. - Ийм бохир усанд амьд амьтан, ургамал амьдрах боломж бий юу? Сурагчдаар самбарт бичсэн үгсийг дэвтэрт нь бичүүлээд гэрийн даалгавар өгнө.	Зургийг харж өөрийн үгээр хэлнэ. - Хог хаясан - Хувцас, хивс угаасан - Алт угаасан гэх мэтээр хариулна. - Байна, байхгүй Багшийн самбарт нэгтгэн бичсэнийг дэвтэртээ хуулж бичнэ	Голын усыг бохирдуулж байгаа төрөл бүрийн зураг, эх хувиар, эсвэл слайдаар бэлтгэх	
Даалгавар	Голын усыг бохирдуулахгүйн тулд чи юу хийж чадах вэ? Бусад хүмүүс юу хийж болох вэ? гэсэн асуултад хариулт бэлтгэж ирэх даалгавар өгнө			

Туршилт хийх заавар:

Хэрэглэх зүйл: Бохир устай сав, цэвэр шилэн сав /эсвэл цэвэр усны сав/, юүлүүр, шүүлтүүрийн цаас

(Шилэн сав, юүлүүр хүрэлцээгүй, эсвэл байхгүй бол цэвэр усны савыг ашиглаж болно. Үүний тулд цэвэр усны савны дээд хэсгийг тайран юүлүүр болгож доод хэсгийг шилэн сав /воронк/ болгон ашиглаж болно.)

Ажлын дараалал:

Юүлүүрт шүүлтүүрийн цаасаа хийж хоосон цэвэр шилэн саванд углаж байрлуулна. Шүүлтүүр цаасыг воронкны хананд бэхлэхийн тулд урьдчилж усаар норгож бэлдсэн байна. Дараа нь бохир уснаасаа 20 мл орчмыг хийж шүүнэ. Усыг хийхдээ савх юмуу гуурсыг хананд нь хүргэлгүй барьж байгаад түүнийг дагуулж хийнэ. Тэгвэл ус цалгихгүй, ихээр орж асгардаггүй.

Анхаарах зүйл: ус их бохирдолтой, шүүгдэс их байгаад ус нь шүүгдэхээ боливол шүүлтүүр цаасыг солино. Эсвэл, шүүсэн ус хангалттай болсон бол шүүх ажлыг зогсоож болно.

2.3. Ээлжит хичээлийн төлөвлөлтийн загвар (Хувилбар 3)

Сэдэв:

Анги:

Хүүхдийн тоо:

Хичээл заасан багш:

Зорилго:

Зорилтууд:

•

Сурагчдын өмнөх ойлголт, төсөөлөл:

Арга зүйн төлөвлөлт:

Хичээлийн үе шат	Суралцахуйн үндсэн үйл ажиллагаа	Сурагчдын үзүүлэх хариу үйлдэл	Заах арга зүйн дэмжлэг
Сонирхол хэрэгцээг төрүүлэх			
Хөгжүүлэх			
Дүгнэлт			

2.4. Ээлжит хичээлийн төлөвлөлтийн загвар (Хувилбар 4)

Сэдэв:

Анги:

Хүүхдийн тоо:

Хичээл заасан багш:

Зорилго:

Зорилтууд:

•

Сурагчдын өмнөх ойлголт, төсөөлөл:

Арга зүйн төлөвлөлт:

Үе шат	Хугацаа	Агуулга/ Зорилго	Сурагчдын үйл ажиллагаа • Хийх ажлууд • Юу бодох • Бүлгээр, хосоор, бие даан хийх	Багшийн үйл ажиллагаа: • Асуух асуулт • Үзүүлэхажил • Аюулгүй ажиллагаа	Үнэлгээ • Мэдлэг • Шинжлэх ухаанч арга барил • Ур чадвар • Сонирхол
Сонирхол хэрэгцээг төрүүлэх					
Хөгжүүлэх					
Дүгнэлт					

2.5 Ээлжит хичээлийн төлөвлөлтийн загвар (Хувилбар 5)

БИДНИЙ ЭРХ, ҮҮРЭГ

Зорилго: Эрх, үүргийн талаар энгийн ойлголттой болгох

Зорилт:

- Хүүхдийн орчин дахь эрх, үүргүүдээс нэрлэх
- Эрх, үүргийн ялгааг харьцуулан ярилцах, тайлбарлах
- Эрх, үүргийн талаар өөрийн үзэл бодлоо илэрхийлэх

Хичээлийн үйл ажиллагааны явцын төлөвлөлт

№	Үе шат	Хичээлийн	Хугацаа	Багшийн үйл ажиллагаа	Сурагчийн үйл ажиллагаа
1	Баримжааг ялган таних үе шат	Зохион байгуулалт	3 минут	Хүүхдүүдийг 4 өнгөнөөс сонгуулан баг болгон суулгана (шар, цэнхэр, улаан, ногоон). Хүүхдүүд ээ! Өнөөдөр бүгдээрээ нараа инээлгэцгээе. Хичээлийн явцад зөв хийсэн тохиолдолд багт нэг цацраг өгнө. Хичээлийн төгсгөлд хамгийн олон цацраг авсан баг өнөөдрийн хичээлд нараа инээлгэж чадна. Нарыг ширээ болгонд байрлуулна.	Сонгосон өнгийн дүрсийн дагуу багийн зохион байгуулалтаар суух 1-р баг "Сурах", 2-р баг "Хөгжих", 3-р баг "Эрүүл өсөх", 4-р баг "Санаагаа хэлэх" <u>Цацраг 1</u>
2		Өмнөх мэдлэгийг сэргээн сануулах	5 минут	• Хэрчмэл хэрэглэгдэхүүнийг ашиглан өмнөх хичээлд зохиосон ангийн дүрмээ сэргээн ярилцах Эдгээр дүрмийг биелүүлэхгүй байж болох уу? Заавал биелүүлэх ёстой үйлийг юу гэж нэрлэдэг вэ? ҮҮРЭГ	<u>Багийн ажил 1</u> Өгөгдсөн дүрэм журмыг агуулгаар нь багцлан нэгтгэх, дүгнэх <u>Цацраг-2,3</u>
3		Шинэ мэдлэг эзэмшүүлэх		Зураг тарааж өгнө. • Багш зурган бичвэрүүдийг үзүүлэх, зурагт дөхүүлсэн асуулт тавих Зураг тарааж өгнө • Багш зурган бичвэрүүдийг үзүүлэх, зурагт дөхүүлсэн асуулт тавих 1. Зургийг хамтран үзэж, санаа бодлоо илэрхийлэн ярилцах.	Багийн ажил 2. Зураг өгөх Цацраг 4. Ярих

4	Баримжааг эзэмшүүлэх үе шат	Шинэ мэдлэг эзэмшүүлэх	18 минут	2. Сурах бичгийн 24-25 хуудсыг уншуулахдаа аль хэсгийг уншихыг тодотгон хэлэх Багшийн нэмэлт материал Багш нэгдсэн үндэстний байгууллага нь даян дэлхийд энхийг тогтоох байгууллага гэдэг мэдээллийг өгөх.	Суралцагчид дараах дүгнэлтийг хийнэ. 1. Бид сурах эрхтэй 2. Бид эрүүл өсөн торних эрхтэй 3. Санаа бодлоо илэрхийлэх эрхтэй 4. Бид чөлөөт цагаа зөв өнгөрүүлэн, авьяасаа хөгжүүлэх эрхтэй
5				3. Хүүхэд бүрийн эдлэх ёстой хүний эрхийн тунхаг бичиг гэдгийг тайлбарлах. Хэдэн эрх, хэдэн үүрэгтэйг асуух Үүргийг самбарт наана. Дэвтэрт өөрийн багийн зурагт тохирох эрхийг бичүүлнэ.	Сурагчид сурах бичгийн зураг дээр ажиллаж хэлэлцүүлэг хийнэ. Эндээс 4 эрх, 4 үүрэг байгааг тодорхойлоно. <i>Цацраг5</i> <i>Цацраг6</i>
6	Баримжааг үнэлж хөгжүүлэх	Бататгал	5 минут	Алжаал тайлах дасгал: /Бид чөлөөт цагаа зөв өнгөрүүлэх эрхтэй/ Самбар дээрх эрхүүдийг зэрэг унших явцдаа УРТ эгшигтэй үг дээр сууна, БОГИНО эгшигтэй үг дээр босно. <i>Цацраг7</i> АЗ ЖАРГАЛЫН ӨРГӨӨГӨӨР аялал зохион байгуулах. -Видео бичлэгийг үзүүлж яриулна. - МӨНГӨ-нөөс эрх, үүрэг нь нэг зүйлийн 2 тал юм гэдгийг ойлгуулна.	1.Багийн ажил 3. /Эрх үүргээ ялган наана/ 2. Цонх нээнэ. Сурагчид цонх 1 эрхээ ялгаж наана. Цонх 2 сургачид үүргээ ялган наана. <i>Цацраг8</i> 3. Хаалгаа нээнэ. Эрх үүрэг салшгүй гэдгийг ярилцана. ВИДЕО /you tube-ийн www.EAGLE_TV.mn 2010.09.09 Хүүхдийн.хөдөлмөр.flv бичлэг дээр ярилцах, Эндээс сурагчид бидний эрх, үүрэг гэдгийг мэдэж авч биелүүлэх санаа төрнө.
7		Дүгнэлт	3 минут	1. Сурагчдын идэвх оролцооны үнэлгээг хамгийн олон цацраг нааснаар үнэлнэ. 2. Хичээлийн зорилго, зорилтоо дүгнэнэ (Нарны цацраг дээрх даалгаврын гүйцэтгэлээр үнэлж дүгнэнэ)	Цацраг дээрх үгийг уншиж өгөхөд Эрх байвал гараа даллана. Үүрэг байвал алгаа 3 ташаарай.
8		Гэрийн даалгавар	1 минут	Гэр бүлийн гишүүдийнхээ үүргүүдийг ялган бүлэглэж ирээрэй.	

- Заалт 6.**
Эрүүл өсөн торних эрхтэй
- Заалт 13.**
Санаа бодлоо илэрхийлэх эрхтэй
Авъяасаа хөгжүүлэх эрхтэй
Сурч боловсрох эрхтэй
Хүүхэд бүр эрүүл мэндийн үйлчилгээнд бүрэн хамрагдах эрхтэй
- Заалт 28**
Сурч боловсрох эрхтэй
- Заалт 15**
Хүүхэд бүр эвсэл холбоо байгуулах, эвгэлдэн нэгдэх, тайван замаар жагсаал цуглаах хийх эрхтэй
- Заалт 30**
Хүүхэд бүр үндэс нийкээ соёлыг эзэмших, сүсэглэх, цашынзан үйл үйлдэх, төрөлх хэлээрээ ярих эрхтэй. Хүүхэд бүр өөрийн хуссан цашинаа шүтэх эрхтэй.

ХАВСРАЛТ 3.

Багшид зориулсан нэмэлт унших материал

Суралцагчдын суралцахуйг дэмжих арга зүйн хөгжил

Суралцагчдын суралцахуйг дэмжсэн арга зүй гэж юу вэ?

Боловсролыг мэдлэг дамжуулах үйл ажиллагаа биш, мэдлэг бүтээлгэх арга барилыг эзэмших идэвхтэй үйл болохыг дэлхий нийтээрээ хүлээн зөвшөөрч байна. Энэ нь улс орон бүрт өөрийн онцлог, нийгмийн байдлаас шалтгаалж өөр өөр байна.

Энэхүү өөрчлөлтийн гол нөхцөл болсон хүчин зүйл нь хүйтэн дайны төгсгөл болон мэдээллийн даяарчлал, түүнчлэн олон улсын холбоо харилцаа өргөжин дэвшиж, шинэ мэдлэг маш их хэмжээгээр боловсруулах болсон явдал юм.

Боловсролын шинэ үзэл баримтлалын дагуу багшийн үүрэг нь “мэдээлэл дамжуулагч”-аас “хүүхдийн хөгжлийг туслан дэмжигч, чиглүүлэгч” болон өөрчлөгдөж байна. Монголд ч боловсролын шинэчлэл өрнөж байна.

XXI зуунд мэдээлэл, харилцаа холбооны технологийн хөгжил асар хурдацтай өрнөж, улс орон бүр бүх дэлхийг хамарсан даяарчлалын давалгаанд хамрагдан, нийлэхийн зэрэгцээгээр өөрийн өв, соёл уламжлалаа хадгалан үлдэхийн төлөө хүчтэй тэмцэл хийж байна.

Эдүгээ аливаа улс гүрний нийт иргэдийн дотоод нөөцийн бүтээх чадамж нь тухайн нийгмийн хөгжлийг шийдвэрлэх гол хүчин зүйл болдог. Тиймээс ч дэлхийн улс орнууд хүн төвт хөгжлийн бодлого хэрэгжүүлж байна. Нийт иргэдийн дотоод нөөцийн бүтээх чадавхыг хөгжүүлэх гол хэрэглүүр нь иргэний боловсролын тогтолцоо юм. Үүнтэй уялдуулан дэлхийн боловсролын шинжлэх ухааны байгууллага болох ЮНЕСКО-оос дэлхийн улс орнуудад хандан “аливаа боловсролын зорилго нь суралцагсдад *мэдэх, бүтээх, нийгэмшин иргэнших, бие даан амьдрах* гэсэн 4 зүйлийн арга ухааны цогц чадамжийг төлөвшүүлэхэд оршвоос зохилтой” гэж зөвлөмжилсөн. Энэхүү зөвлөмжийг бага, дунд боловсролын стандартыг боловсруулахдаа үндсэн чиг баримжаа болгосон юм.

Хүүхдийн хөгжлийн онцлогийг суралцахуйн тулгуур баганатай уялдуулж, сургалтыг амжилттай явуулах /Жайка зөвлөмжөөс/

Боловсролын 4 тулгуур	Хүүхдийн хөгжил	Оюун ухааны			Нийгмийн			Сэрэл/сэдэл	
		Пиже /Выготский	Тоо, мэдрэмж, хэл	Орон зай ой тогтоолт үг хэлний жигд байдал	Бусадтай харьцах мэдрэмжийн холбоо	Амьдралын үндсэн хэвшил тохирсон үйлдэл	Үүрэг (нийгмийн ур чадвар)	Хөгжлийн сэдэл (амжилт алдаанаас айх)	Сэтгэл хөдлөл
Мэдэхийн тулд суралцахуй	Өргөн хүрээний ЕБ-ийн сургалт	Мэдээллийг таних, хүртэн хүлээн авах							
	Мэдлэг олох аргын сургалт								
	Хөдөлмөрийн арга барил								
	Бусадтай нөхөрлөн хамтран ажиллах арга барил								
Т у л д	Ажлын сургалт				Мэдээллийг				

	Мэдлэг болон дадлагын нэгдэл				тайлбарлах, дүрслэн илэрхийлэх					
	Бусадтай хамтран ажиллах									
Оршихуйн тулд суралцахуй	Өөртөө шүүмжлэлтэй хандах бодол							Мэдээллийг загварчлан боловсруулах		
	Шийдвэр гаргах чадвар									
	Бие даасан ухаан									
	Хариуцлага									
	Ой тогтоолт болон дүгнэх чадвар, гоо сайхны мэдрэмж харагдах байдал, харицааны чадвар									
Нийгэмшихуйн тулд суралцахуй	Бусад үндэстний соёл, үзэл бодлыг хүндэтгэх	Мэдээллийг бусадтай хамтран ашиглах. Мэдээллийг хүлээн авагч байгаад зогсохгүй, түгээгч байх гэсэн зарчмыг танин мэдэх								
	Олон талтай чанар, харилцан ойлголцол, тайван амгалан сэтгэхүй									
	Хүний харилцааны дайсагналыг шийдэх арга									
	Бусдыг ойлгох бусадтай хамааралтай байх									

Мэдлэг бүтээх онолууд /Жайка зөвлөмжөөс/				
Арга зүйн асуудлууд	Конструктив онол		Когнитив онол	
	Тэнцвэрийн онол	Суралцахуйн үйл ажиллагааны онол	Мэдээлэл идэвхтэй боловсруулах онол	Мэдлэгийн тавилын онол
Мэдлэг бүтээх зүй тогтлыг авч үзэхдээ	Дасан зохицох үйл явц	Эзэмших үйл явц	Мэдээлэл боловсруулах үйл явц	Мэдлэгийн тавил (баримжаа, дүрслэл өөрчлөгдөх үйл явц)
Мэдлэг бүтээх үйл явцын төрөл, чиглэл	-Ассимиляцлах (ижилсэх) -Аккомодацилах (хувирган зохицох)	Экстриоризаци (үйл гадагшлах) Интериоризаци (үйл дотогшлох)	-Урт санамжаас богино санамжид шилжих(мэдлэгийн бүтэц өөрчлөгдөхгүй) - Богино санамжаас урт санамжид шилжих мэдлэгийн бүтэц өөрчлөгдөнө)	-Гадаад тавил дотогшлох -Дотоод тавил гадагшлах
Мэдлэг бүтээх үйлийн үе шатууд	-Зөн билгийн -Үйлийн өмнөх -Тодорхой үйлдлийн -Формаль үйлдлийн	-Мэдлэг бүтээх үйлийн баримжааг таних -Баримжааг эзэмших -Баримжааг хэрэглэх, хөгжүүлэх	-Хүртэж мэдрэх - Сэтгэж мэдрэх -Мэдээллийг ухаарч, шүүж богино хугацааны санамжид боловсруулах	-Ахуй амьдралын хэл -Шинжлэх ухааны хэл -Загвар, тэмдэглэл, томъёоны хэл

Мэдлэг бүтээх үйл явцын үр дүн	Ассимляцлах, аккомадацлах барил өргөжин хөгжинө	Сэтгэхүйн үйлийн шинэ арга барил төлөвшинө	Урт хугацааны санамж дахь мэдлэгийн бүтэц өөрчлөгдөнө	Ухагдахууны дотоод сүлжээ бий болох
Оюун сэтгэлгээний загварын шинж	Зөн билгийн ба туршин танихын суурь болдог	Үйлийн баримжаа болдог	Урт хугацааны санамж дахь мэдлэг болдог	Ухагдахууны сүлжээ болдог
Суралцагчийн хөгжих үйл явц	Дасан зохицох чадварын хөгжлөөр	Сэтгэхүйн барил эзэмших аргын өөрчлөлтөөр	Шинэ мэдлэг бүтээх аргын өөрчлөлтөөр	Мэдлэгийн гадаад дотод тавилын зохицлоор
Суралцагчийн хөгжилд нөлөөлөх гол хүчин зүйл, орчин	Суралцагчийн дотоод фикзиологийн төрөлх төлөв	Нийгэм, соёлын орчин	Тухайн нийгмийн түүхэн нөхцөл	Мэдлэгийн гадаад дотоод тавилыг шинэчлэн хөгжүүлэх багшийн бүтээлч үйл ажиллагаа
Суралцахуй гэж юу вэ?	Сурагч мэдлэгээ бүтээх үйл ажиллагаа	Эзэмших үйлээр төлөвших сэтгэхүйн шинэ бүрдэл	Суралцагч мэдээллийг боловсруулж, шинэ мэдлэг бүтээх үйл ажиллагаа	Мэдлэгийг гадаад дотоод тавилын нөлөөгөөр суралцагч өмнөх мэдлэгийнхээ дотоод тавилыг шинэчлэх үйл ажиллагаа

Дидактик зарчим

Дидактикийн ерөнхий зарчмууд

- Суралцагчийн өмнөх мэдлэг дээр тулгуурлах
- Хүмүүнлэг, ардчилсан байх
- Суралцагчийн нас, сэтгэхүйн онцлогт тохирсон байх
- Суралцагчийн хэрэгцээ, сонирхлыг харгалзсан байх
- Агуулгын судлагдахууны тогтолцоот байдлыг хангах
- Онол, практикийн зохистой харьцаатай байх
- Сургалт, амьдралд хэрэгцээтэй, холбоотой байх
- Агуулгыг интеграцчилах, элементарчлах
- Систем, дэс дараатай мэдлэг эзэмшүүлэх
- Сургалтын таатай орчин бүрдүүлэх, сургалтын хэрэглэгдэхүүнийг оновчтой сонгох

Боловсролын тусгай дидактик

- Шинжлэх ухааны үндэстэй байх

Тухайн боловсролоор эзэмшиж байгаа мэдлэг, чадвар нь шинжлэх ухааны /хууль, зүй тогтол, хамаарал нь батлагдсан/ үндэстэй байна.

- Асуудлыг нэгдмэл байдлаар авч үзэх

Аливаа асуудлыг шийдэхдээ салангид мэдлэгийн хүрээгээр бус, олон талаас нь, нэгдмэл, цогц мэдлэгийн өргөн хүрээнд шийдвэрлэнэ.

- Ойроос хол руу, мэддэгээс мэддэггүй рүү чиглэх

Шинэ мэдлэг бүтээх үйл ажиллагаа нь өдөр тутмын амьдралаас олсон мэдлэг, өмнө нь эзэмшсэн мэдлэг, чадвар дээр суурилна.

Агуулгыг сонгох зарчим

- Тогтвортой байх
- Шинжлэх ухаанч байх
- Хувь хүний хэрэгцээ, сонирхолд нийцсэн байх

Тухайн боловсролын сургалтын агуулгыг сонгохдоо аливаа өөрчлөлтөд инвариант байх, интеграцчилагдсан, дэлхий нийтийн жишигт ойртсон, хувь хүний хэрэгцээ, сонирхолд нийцсэн шинжлэх ухаанч байх зарчмыг баримтална.

Сургахуйн зарчим

- Боловсролын философи үндэслэл
- Боловсролын психологи үндэслэл
- Мэдээллийн онолын үндэслэл

Багш нь боловсролын бодлого философи, психологи болон сургалтын дидактик зарчим дээр тулгуурлан суралцагчдад байгаль, нийгмийг таних ур ухааныг төлөвшүүлэх үйл ажиллагааг удирдан зохион байгуулагч, чиглүүлэгч байна.

Сурагчдад аливааг танин мэдэх сонирхол, арга барицыг бий болгохын тулд багш мэдлэг бүтээх таатай орчинг бүрдүүлэх, мэдлэг бүтээх аргад сургах, сурах үйлийг эзэмшихүйн үе шатны дагуу зохион байгуулна.

Багш (суралцагчийн мэдлэг бүтээх үйл явцыг удирдан чиглүүлэх) сурагчийн (идэвхтэй ажиллан мэдлэг олж авах) хамтын үйл ажиллагааг **сургалт гэнэ**.

Багш мэдлэг бүтээх явцад дараах үүрэгтэй оролцоно. Үүнд:

- Хичээлийг төлөвлөх
- Мэдээллийн сан бүрдүүлэх
- Зохион байгуулах
- Сурагчдад зөвлөх, санал солилцох
- Сурагчдын үйл ажиллагааг дэмжих чиглүүлэх
- Сурагчдыг үнэлэх зэрэг болно.

Багшийн сурган хүмүүжүүлэх үйлүүд		Сурагчийн танин мэдэх үйлүүд
Тайлбарлан ярих	→	Сонсох, ухамсарлах, ойлгох харьцуулах, тогтоох асуух
Үзүүлэн, таниулах	→	Харах, задлан шинжлэх, харьцуулах, шинэ зүйл олох, бичих, зурах
Асуух	→	Сонсох, бодох, хариулахад хэрэгтэй мэдлэгийг хайх, эмхлэх, төлөвлөх, тэмдэглэх
Харьцуулан жиших	→	Ярих, харьцуулах, жиших, төсөөтэй болон ялгаатай шинжүүдийг олох, дүгнэлт хийх
Материал тараан өгөх	→	Авсан материалыг унших, хэрэгтэй зүйлийг хайх олох, тэмдэглэх


Сургалтын үйл ажиллагаа ба үнэлгээ

Багш, сурагчийн үйл ажиллагаа		Үнэлгээ
Багш	Сурагч	
- Сэдэл хэрэгцээг төрүүлэх - Зорилго, зорилтыг тодорхойлох - Сурагчаар мэдлэг бүтээлгэх үйл ажиллагааг төлөвлөх - Сурагчийн мэдлэг бүтээх үйл ажиллагааг зохион байгуулах - Арга зүйн зөвлөгөө өгөх - Сурагчдад багаар болон бие даан ажиллах боломжийг олгох - Сурагчдын гүйцэтгэсэн ажлыг анхааралтай сонсох, тэдэнд хүндэтгэлтэй хандах - Алдааг залруулах гэж яарахгүй өөрсдөөр нь олуулах, түүнийг нь хичээлдээ үр ашигтайгаар хэрэглэх - Олж авсан мэдлэг, чадвараа шинэ нөхцөлд хэрэглэх, амьдрал практикийн жишээн дээр тайлбарлах боломжийг бүрдүүлэх - Мэдлэгээ чөлөөтэй ашиглах боломжит даалгавруудыг төлөвлөн хэрэгжүүлэх	- Тухайн асуудлыг судлах сонирхол, хэрэгцээ бий болох - Судлахын тулд хийх ажлын заавартай сайтар танилцаж ойлгосон байх - Тухайн асуудлыг судлах /унших, тэмдэглэх, ажиглах, турших, харьцуулах, зурах гэх мэт/ - Бүлгээр, эсвэл анги нийтээр хэлэлцүүлэг хийх - Өөрсдийн хийсэн зүйлийг бусдын хийсэнтэй харьцуулах, алдаагаа олж харах, илүү оновчтой аргыг олж мэдэх, өөртөө нээлт хийх - Мэдлэгээ амьдрал практикийн жишээ баримтаар баяжуулах, шинэ нөхцөлд хөрвүүлэн хэрэглэх - Мэдлэг чадвараа ашиглан бие даан бүтээл хийх, өөрийн үзэл бодол, үнэлэмжээ илэрхийлэх гэх мэт үйлийг гүйцэтгэнэ.	<u>Мэдлэг- Мэдсэн зүйлс:</u> Тухайн агуулгын үндсэн ойлголт, нэр томьёо, хууль зүй тогтол, учир шалтгааны уялдаа холбоо зэргийг шалгах <u>Хийж гүйцэтгэх чадвар:</u> Тухайн агуулгаар дамжуулан сурагчдын зайлшгүй хийж чаддаг болсон байх зүйлс: харьцуулах, ангилах, ялгах, ажиглалт, туршилт, зураглах, схемчлэл гэх мэт. <u>Сүрч мэдсэнээ ашиглах чадвар:</u> Мэдлэгээ практикийн жишээ баримтаар баяжуулан тайлбарлах, шинэ нөхцөлд ашиглах, өөрийгөө илэрхийлэх чадвар

Суралцахуйн зарчим

Суралцахуй нь:

- Сурахуйн танин мэдэхүйн үндсэн процесс
- Сурахуйн танин мэдэхүйн хууль зүй тогтлын дагуу явагддаг



- Орчин үеийн сэтгэл судлалын онолын чиг хандлага үзэл баримтлалын үүднээс **мэдлэг нь нэг хүнээс нөгөөд зүгээр нэг дамждаггүй, мэдлэгийг хүн өөрөө бүтээдэг** гэж үзэж байна.
- Хүн бүрт хүрээлэн буй орчин өдөр тутмын амьдралаасаа олж авсан тодорхой хэмжээний мэдлэг байдаг
- Энэ мэдлэгээ ашиглан юмс үзэгдлийн учир шалтгаан зөв бурууд тайлбар өгч тайлбарлаж чадахгүй зүйлийг тайлбарлахын тулд түүнд шинэ мэдлэг хэрэгтэй болдог

- Сургалтын явцад сурагчдын өдөр тутмын амьдралаасаа олж авсан мэдлэгийг илрүүлж, буруу зөвийг засаж, энэ мэдлэг дээр нь тулгуурлан шинэ мэдлэгийг эзэмшүүлнэ.

Шинэ мэдлэг эзэмших үйл ажиллагаа нь:

- Үйл ажиллагааг эзэмших сэдэл бий болох
- Үйл ажиллагааны талаар баримжаа олж авах
- Үйл ажиллагааг дууриан үйлдэх
- Үйл ажиллагааны талаар бусдад тайлбарлан ярих
- Үйл ажиллагааг өөрөө өөртэйгээ ярих
- Үйл ажиллагааг чөлөөтэй үйлдэх гэсэн үе шатаар явагдана.

Сурагчдын **мэдлэг бүтээх үйл явц нь** эзэмшихүйн зүй тогтолд тулгуурлах ба энэ нь баримжааг ялган таних, баримжааг эзэмших, баримжааг хэрэглэх хөгжүүлэх гэсэн 3 үе шаттай байдаг.

1. Баримжааг ялган таних шатанд

Мэдээллийн төрөл, түүнийг сонгох, шийдвэрлэх асуудлаа дэвшүүлэн тавих, түүнийг ухаарч ойлгох, мэдээлэл боловсруулах асуудлаа шийдвэрлэх, төлөвлөгөө зохиох, ойлгосноо өөрийн үгээр тайлбарлах, тэмдэглэл хөтлөх, дадлага ажил, туршилт хийх, таамаглал дэвшүүлэх гэх мэт үйл хийнэ.

2. Баримжааг эзэмших үе шатанд

Сурагчдад тухайн агуулгаар итгэл, үнэмшил бий болох, мэдээлэл солилцох ба сурагчид хоорондын бие даасан хамтын ажиллагаа төлөвшиж, материаллаг үйлийн (зурах, бичих, ярих, тооцоолох гэх мэт) хүрээ өргөжнө. Энэ үед сэтгэхүйн задлан шинжлэх (анализ), нэгтгэн дүгнэх (синтез) үйлдэл хийгдэнэ. Түүнчлэн эзэмшсэн мэдлэгээ танил нөхцөлд хэрэглэх чадвар төлөвшиж эхэлнэ. Сэтгэхүйн дараах үйлүүдийг үзэгдэл юмсын шинж чанар, холбоо хамаарлыг илрүүлэх явцад төлөвшүүлэх хэрэгтэй.

- Задлан шинжлэх
- Нэгтгэх
- Харьцуулах
- Хийсвэрлэх
- Тодруулан авч үзэх
- Ерөнхийлөн дүгнэх

• Сэтгэхүйн задлан шинжлэх үйл

Судалж байгаа юмс үзэгдлийг оюун санаандаа, эсвэл бодит байдал дээр, эсвэл түүний загвар дээр ажиллан бүрэлдэхүүн хэсгүүдийг олж, шинж чанар холбоо хамаарлыг илрүүлэхийг хэлнэ.

Задлан шинжлэх үйлийн үр дүнд хүлээн авсан мэдээллийн гол, гол биш холбоо хамаарлыг ялган тодруулдаг.

• Сэтгэхүйн нэгтгэн дүгнэх үйл

Задлан шинжлэх үйлийн үр дүнд ялган тодруулсан гол шинж чанар, холбоо хамаарлыг оюун санаандаа нэгтгэж, юмс үзэгдлийг бүхэл бүтэн цогц болгон авч үзэхийг хэлнэ.

Ж: Нар, сарны хиртэлтийг бүдүүвчээр дүрсэлж өөрийн үгээр тайлбарлана уу?

Судалж байгаа асуудлын эхний өгөгдсөн агуулга тодорхой биш байвал задлан шинжлэх үйлдэл давамгайлна.

Хэрэв агуулга тодорхой байвал бодол санаа шуудхан явагдаж, нэгтгэх үйл давамгайлна.

3. Баримжааг хэрэгжүүлж хөгжүүлэх шатанд

Суралцагчдын материаллаг үйлээс сэтгэцийн үйл давамгайлж, мэдээллийн агуулгыг системчлэх, хураангуй товч хэллэг бичлэгт шилжих, асуудалд шүүмжлэлтэй хандах, эзэмшсэн мэдлэг, чадвараа шинэ нөхцөлд бүтээлчээр хэрэглэх чадвар төлөвшинө.

“Хүн-Орчин” хичээлийн агуулга

2007-2008 оны хичээлийн жилээс ЕБС 12 жилийн сургалтын тогтолцоонд шилжсэнээр бага боловсрол 6 жил болсон.

“Хүн-Орчин” хичээл нь эрүүл мэнд, нийгмийн ухаан, байгалийн ухааны нэгдмэл хичээл бөгөөд хүн, байгаль, нийгмийн харилцан холбоон дахь олон асуудлыг авч үздэг бөгөөд хувь хүн болж төлөвшихөд чухал үүрэгтэй хичээл болно.

“Хүн-Орчин” хичээлийн агуулгын тогтолцоог судлахдаа стандарт, үндэсний хөтөлбөр, 1-3 ангийн “Хүн-Орчин” хичээлийн сурах бичгүүдийг ашиглана.

“Хүн-Орчин” хичээлийн агуулгын хүрээ нь дараах үндсэн бүрэлдэхүүн хэсэгтэй бөгөөд анги тус бүрээр хэрхэн судалсныг **Хавсралт „„„** хараарай.

Эрүүл амьдрах үндэс	Хүрээлэн буй байгаль	Нийгэм, соёл
- Биеийн эрүүл мэнд (зөв хооллолт, хувийн эрүүл ахуй ариун цэвэр, амны хөндийн эрүүл мэнд) - Аюулгүй амьдрал (эрүүл орчин бүрдүүлэх, бие эрхтнээ хамгаалах, осол гэмтлээс сэргийлэх, эрүүл аж төрөх)	- Амьгүй ба амьд бие (Амьгүй ба амьд биеийн шинж чанар, амьдралын орчин) - Байгаль, цаг агаарын үзэгдлүүд (байгаль, цаг агаар, улирлын өөрчлөлт, байгалийн гамшигт үзэгдэл) - Байгаль хамгаалах	- Нийгэм, соёлын орчин (би,гэр бүл, анги хамт олон, төрөл садан, найз нөхөд, сургууль гэх мэт) - Эрх үүрэг, дүрэм журам, ёс зүй (сурагчийн эрх үүрэг, сургууль соёлын орчин дахь хүүхдийн эрх гэх мэт)

Хичээлийн судалгааны арга зүй

Японы Жигё кенкю буюу хичээлийн судалгаа гэж юу вэ?

Хичээл заасан болон хичээлд ажиглалт хийсэн багш нар хичээлийн ололттой тал, сайжруулах арга замыг хамтран ярилцаж, албан тэмдэглэл хөтлөн, баримтжуулж үлдээхийг хэлнэ.

Хичээлийн судалгааг хэд хэдэн түвшинд хийж болно. Үүнд:

- Сургууль дотроо
- Ойролцоо байрлах сургуулиудын хооронд
- Дүүргийн, хотын, улсын хэмжээнд

Японд хичээлийн судалгааг дараах түвшинд хийж байна.

Хичээлийн судалгааны тогтолцоо

Сургуульд суурилсан
хичээлийн судалгаа

Муж, тойргийн хэмжээний
хичээлийн судалгаа

Үндэсний хэмжээний хичээлийн
судалгаа

Дунд сургуулийн
багш нар, зохион
байгуулагчид

Дунд
сургуулийн
багш нар

Сургалт,
семинар

Лаборатори
сургуулиуд,
зохион
байгуулагчид

Яам, харьяа
байгууллагууд

Японд хичээлийн судалгааг, сургууль төвтэй, судалгаа төвтэй гэсэн хоёр арга зүйгээр хэрэгжүүлдэг.

1. Сургууль төвтэй хичээлийн судалгаа нь:

- Сэдвээ сонгох
- Сэдвээ судлах, жилийн төлөвлөгөөндөө тусгах, бэлтгэх
- Хичээлийн судалгаа явуулах
- Хэлэлцэх, сайжруулах
- Жилийн төлөвлөгөө, үйл ажиллагааг дахин хэлэлцэх гэсэн үе шаттайгаар зохион байгуулагддаг.

2. Судалгаа төвтэй хичээлийн судалгаа нь:

Хэн	Юу хийх	Яаж хийх
Хичээл заах багш	Зорилго: Суралцагчдын суралцахуйг дэмжсэн арга зүйн дагуу сургалтын хөтөлбөр боловсруулж, хэрэгжүүлэх, хичээлийн судалгаа хийх арга зүйд суралцах, сургалтын хөтөлбөрөө сайжруулах	
	• Заах хичээлийн хөтөлбөрийг боловсруулах, хичээл заах • Хичээлийн хэлэлцүүлэгт оролцох • Өөрийн заасан хичээлд үнэлэлт, дүгнэлт өгөх • Хичээлийн арга зүйн боловсруулалтыг дахин сайжруулах • Хичээлд анализ хийх, үр дүнг хэрэглэх	• Дидактикийн үндэстэйгээр хичээлийн судалгаа хийх • Бүлэг сэдэв, нэгж, ээлжит хичээлийн хөтөлбөр боловсруулах
Хичээлийн судалгаа хийх багийн гишүүд:	Зорилго: Удирдах ажилтан: Сургалтын орчин болон сургалтын үйл ажиллагааг үнэлэх, хөгжүүлэх Менежер: Багш нарын багшлахуй болон сурагчдын суралцахуйг үнэлж, сайжруулах Багш: Хичээлийн судалгаа хийх аргаа сайжруулах, үнэлгээ өгөх, арга зүйн шинэ санаа олж авах	
• Удирдах ажилтан		

- Менежер - Багш	- Хичээлд ажиглалт хийх, тэмдэглэл хөтлөх - Хичээлийн хэлэлцүүлэг зохион байгуулах - Хичээлийн арга зүйг дахин сайжруулахад дэмжлэг үзүүлэх - Хичээлд үнэлэлт, дүгнэлт өгч баримт цуглуулах	- Дидактикийн үндэстэйгээр хичээлийн судалгаа хийх - Ажиглалтын болон мониторингийн хуудас дээр ажиллаж, анализ хийх
Хичээлийн судалгааг удирдан явуулах мэргэжлийн багийн гишүүн	Зорилго: Хичээлийн судалгаа хийх арга зүйд суралцах, үйл ажиллагааг удирдан чиглүүлэх	
	- Хичээлийн судалгааг зохих үе шатны дагуу удирдан зохион байгуулах - Арга зүйн зөвлөгөө өгөх - Хэлэлцүүлгийг удирдан явуулах - Дүгнэлт хийх	- Хичээлийн судалгааны мониторингийн хуудсыг боловсруулах - Хичээлийн судалгаанд оролцогчдод тайлбарлах, үйл ажиллагааг чиглүүлэх - Хэлэлцүүгийн аргачлал боловсруулж, хэрэгжүүлэх - Хэлэлцүүлгийг нэгтгэн, дүгнэх

Судалгаат хичээл зохион байгуулах сургуулийн жилийн ажлын төлөвлөгөө

/Японы улсын жишээн дээр/

2011-2012 оны хичээлийн жил

Хийх ажил	Хугацаа	Сургалтын хэлбэр	“Хүн-Орчин”	Бусад (Хүн-байгаль, хими, физик, математик бага, математик дунд, төсөлт ажил)	Сургалт зохион байгуулах багш
9 сар Судалгааны баг зохион байгуулах, жилийн ажлын төлөвлөгөө гаргах	9 сарын 1-15	Бүх багш нарын сургалт	Энэ хичээлийн жилийн сургуулийн бодлогыг тодорхойлох		Захирал
	9 сарын 15-20	Бүлгээр ажиллах	Заах хичээлийн сэдвийг тодорхойлох		ЗАН ахлагч
	9 сарын 20-25	Бүх багш нарын сургалт	Судалгаат хичээл зохион байгуулахад шаардлагатай онолуудыг судлах		Сургалтын менежер
	9 сарын 25-30	Бүх багш нарын сургалт	Сургалтын хөтөлбөр боловсруулах		Судалгааны багаар ажиллах
10 сар Судалгаат хичээл заах ажиглах, үр дүнг тооцох	10 сарын 5	Бүлгээр ажиллах	Сургалтын хөтөлбөр боловсруулахад зөвлөн, туслах		Сургалтын менежер
	10 сарын 10	Бүх багш нарын сургалт	Хичээлийн бэлтгэл судалгаа хийх		Сургалтын менежер
	10 сарын 15	Бүх багш нарын сургалт			Мэргэжлийн багийн зөвлөх багш
	10 сарын 20	Залуу багш нарт	4 хүртэл жил ажиллаж буй багш нар оролцоно		Зөвлөх багш

		зориулсан сургалт		
	10 сарын 25	Бүх багш нарын сургалт	Хичээлийн бэлтгэл судалгаа хийх	Сургалтын менежер
	10 сарын 30	Бүх багш нарын сургалт		Үнэлгээний баг
11 сар Судалгаат хичээлийн үр дүнд тулгуурлан, сургалт зохион байгуулах	11 сарын 5	Бүлгээр ажиллах	Сургалтын хөтөлбөр боловсруулахад зөвлөн туслах	Сургалтын менежер
	11 сарын 10	Бүх багш нарын сургалт	Жижиг бүлгээр ажиллах (судалгаат хичээлийг 2 дахь жилдээ явуулж буй багш нар)	Мэргэжлийн багийн зөвлөх багш
	11 сарын 15	Бүх багш нарын сургалт	Жижиг бүлгээр ажиллах (судалгаат хичээлд дагуулан сургах)	Мэргэжлийн багийн зөвлөх багш
	11 сарын 20	Үнэлгээ хийх		Зөвлөх багш
	11 сарын 25	Бүх багш нарын сургалт		Сургалтын менежер

Судалгаат хичээл зохион байгуулах сургуулийн жилийн ажлын төлөвлөгөө /матрицан загвар/

2011-2012 оны хичээлийн жил

№	Үйл ажиллагаа	9 сар	10 сар	11 сар	12 сар	1 сар
1.	“Хүн-Орчин” хичээлээр судалгаа хийх сургуулийн баг зохион байгуулж, захирлын тушаал гаргах					
2.	Багийн уулзалтыг зохион байгуулж, дотоод зохион байгуулалтын асуудлыг хэлэлцэх, ажил үүргийн хуваарь хийх					
3.	Хичээлийн судалгааны сэдэв, хугацаа зэргийг товлож, ЗАН болон сургуулийн ажлын төлөвлөгөөнд тусгах					
4.	Хуваарийн дагуу хичээлийн судалгаа хийх					
5.	Багаараа хамтран хичээлийн бэлтгэл судалгаа хийх					
6.	Бэлтгэсэн хичээлээ заах, ажиглах					
7.	Хичээлийн хэлэлцүүлэг зохион байгуулах					
8.	Сургалтын хөтөлбөрийг засан сайжруулах, турших					
9.	Хоёр дахь хичээлийн судалгааны бэлтгэлийг хангах					

ЕБ-ын 12 жилийн сургуулийн 1-3 дугаар ангийн “Хүн-Орчин” хичээлийн агуулгын тогтолцоо

	I анги		II анги		III анги	
	Мэдлэг	Чадвар	Мэдлэг	Чадвар	Мэдлэг	Чадвар
Эрүүл мэнд	Гар, амны хөндий, хувийн ариун цэвэр	Гар, шүдээ зөв угааж сурах, Хувийн ариун цэвэр сахих	Сүүн шүд	Шүдээ арчлах	Эмч зөвлөж байна	Шүд цоорох өвчнөөс хамгаалах
	Хөдөлгөөн ба чийрэгжүүлэлт	Тоглох, дасгал хийх, агаар, нар, усаар бие чийрэгжүүлэх	Хараа, Сонсгол,	Хараагаа хамгаалах Сонсголоо хамгаалах	Би өсөж байна	Идэвхтэй хөдөлгөөнтэй байх бусдад туслах
	Зөв хооллолт ба хадгалалт	Зөв хооллох ба хоол хүнсээ зөв хадгалах	Зөв хооллолт ба хүнсний төрөл	Зөв хооллох, хүнсний ногоог таних хэрэглэх, хүнсний бүтээгдэхүүнийг нэрлэх, ангилах	Хүнсний сонголт ба хэрэглэлт	Хүнсээ зөв сонгох, хэрэглэх
			Зөв хувцаслалт	Хувцсаа тохируулан өмсөх	Бэртэж гэмтэхээс сэргийлье	Бэртэж гэмтэхээс сэргийлэх аргыг хэрэгжүүлэх
					Бидний харилцаа	Хүмүүстэй зөв харилцах, анхааралтай сонсох, хүндлэх
Хүрээлэн буй орчин	Хүрээлэн буй орчин	Хүрээлэн буй орчинтой танилцах	Намрын улирал Сургуулийн орчин	Намрын байгаль ажиглах. Сургуулийн орчны мод, ургамал, шувуудыг ажиглах, таньж мэдэх	Эх орон Эх орны газрын зураг	Хил залгаа улсуудыг заах, нэрлэх
	Жилийн дөрвөн улирал	Улирлын ялгааг ажиглах, харьцуулах, ярилцах	Амьд ба амьгүй байгаль	Амьгүй ба амьд байгалийг ялгах, нэрлэх	Газрын гадарга	Ой тайга, хээр тал, говь цөл нутгийн газрын гадаргыг ажиглах, харьцуулах, зурагт заах
			Ургамал, ургамлын ургах орчин, ургамлын ашиг тус	Ургамлыг таних /модлог, бутлаг, өвслөг/	Газар усаа хүндэтгэх ёс	Газар усаа хүндэтгэх уламжлалт аргыг хэрэгжүүлэх
			Тасалгааны ургамал	Тасалгааны ургамлыг таних, нэрлэх	Уур амьсгал	Цаг агаар уур амьсгалын ялгааг мэдэх Ажил хөдөлмөрөө зохицуулах

Тэжээмэл, зэрлэг амьтад	Тэжээмэл ба зэрлэг амьтдыг ялган нэрлэх, таних	Амьтад Өвлийн улирал Зэрлэг амьтдын өвлийн амьдрал, Тэжээмэл амьтдын өвлийн амьдрал Өвөлждөг шувууд	Өвлийн улирлыг ажиглах, Зэрлэг ба тэжээмэл амьтдын өвлийн амьдралыг мэдэх, Зэрлэг ба тэжээмэл амьтдыг нэрлэх, тэжээмэл амьтдыг маллах, хөдөлмөрт оролцох, Өвөлждөг шувуудыг нэрлэх таних, тэжээх	Гол мөрөн, нуур	Гол мөрөн нуурыг нэрлэх, газарзүйн зурагт зааж нэрлэх
		Хаврын улирал Ургамлын хаврын амьдрал Шавж ба шувууд Зэрлэг амьтдын хаврын амьдрал Тэжээмэл амьтдын хаврын амьдрал	Хаврын байгалийг ажиглах Ургамлын хаврын амьдралыг ажиглах Шавж ба шувуудыг нэрлэх, ялгах Зэрлэг ба тэжээмэл амьтдыг ялгаж, нэрлэх Тэжээмэл амьтдыг тэжээх ашиг шимийг мэдэх	Хөрс ургамал амьтан Хөрс	Ой тайга, хээр тал, говь цөл нутгийн хөрсийг ялгах, нэрлэх
		Ундны ус ба голын ус Хүүхэд ба байгаль	Ундны ус ба голын усыг бохирдуулахгүй байх	Бид байгалиас юу авч ашигладаг вэ?	Байгалийн баялгийг нэрлэх, ашиглах, хамгаалах нэрлэх, харьцуулах, ашиглах,
				Монгол орны ургамал	Эмийн ургамлыг ялгах, хэрэглэх Ой тайга, хээр тал, говь цөлийн ургамлыг хамгаалах,
				Амьтдын амьдрал Амьтдыг ажиглаж цаг агаарыг шинжих	Ой тайга, хээр тал, говь цөл нутгийн амьтдыг ялгах, харьцуулах, хамгаалах Амьтдыг ажиглаж цаг агаарыг шинжих аргуудыг мэдэх, хэрэгжүүлэх
				Байгалийн гамшгаас сэргийлье	Байгалийн гамшигт үзэгдлийг нэрлэх, ялгах, сэргийлэх
				Хүүхэд байгалийн нөхөр	Байгальтай зөв харилцах, хамгаалахад

						хувь нэмрээ оруулах, мод тарих
					Хүмүүс дэлхийн тухай Дэлхийн хөдөлгөөн	Глобус, газрын зургийн ялгааг тайлбарлах Өдөр, шөнө болдгийн учрыг тайлбарлах
					Зураг, план зураг	План зургийг таних тэмдгийг унших, зурах
					Хуурай газар, далай	Хуурай газар далайг глобус дээр заах, хуурай газар, далайг нэрлэх
Нийгэм соёл	Аав, ээжийн ажил	Аав, ээж гэр бүлийнхээ ажлын онцлогийг мэдэх	Бид сургууль дээрээ	Бид юу хийж чадах вэ? Сургуулийн түүхтэй танилцах Сургуулийн дүрэм Ангийн журам гаргах, мөрдөх Сурагчийн эрх үүргийг мэдэх, мөрдөх	Хүмүүсийн эрхлэх хөдөлмөр	Орон нутгийн хүмүүсийн хөдөлмөрийн ялгааг мэдэх, хөдөлмөрийг хүндэтгэх, бахархах
	Хүмүүсийн харилцааны соёл	Хүмүүстэй зөв харилцах, туслах	Үйлчилгээний газар	Үйлчилгээний газруудаар зөв үйлчлүүлэх		
	Өдрийн дэглэм	Өөрийнхөө нэг өдрийн тухай ярилцах				
	Гэр орны цахилгаан хэрэгсэл	Зурагт, халаагч, индүү, хөгжим, компьютер гэх мэт цахилгаан хэрэгсэлтэй зөв харьцах				
	Гэрлэн дохио, замын хөдөлгөөний таних тэмдэг	Явган хүний гарцаар гарах, гэрлэн дохиог анхаарах	Замын хөдөлгөөн	Замын хөдөлгөөний дүрмийг баримтлах, замын тэмдгийг мэдэх		
	Орон нутагтай танилцах аялал	Орон нутгийн музей, соёлын төв, суурин газрын үйлчилгээний газруудтай танилцаж, ярилцах				
	Найзуудын харилцаа	Найзууддаа туслах, тоглох, хичээлээ давтах				

